
2024

ТАЙЛАН

МБҮА
SINCE 2009
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

15 ЖИЛ

Зөв зүгт манлайлна



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

МБҮА

SINCE 2009

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Зөв зүгт Манлайлна

Хамтдаа бүтээсэн 15 жил

JIGUUR GRAND GROUP
МАКС өргөө
TSAST CONSTRUCTION
КОНСТРАКШН
Royal New Castle
ultrasonic
NCD NOMIN CONSTRUCTION DEVELOPMENT GROUP
NBTK
ZAG GROUP
BASALTWOOL МОНГОБАЗАЛЬТ ХК
ERELT IMPEX ERELT IMPEX GROUP
MCS property LLC
БҮТИ
UGUUJ KHISHIG CO.,LTD
T&G
GREEN RESOURCE
SD ENGINEERING & CONSTRUCTION
ERIN INTERNATIONAL
ERCHIM ENGINEERING LLC
ChMM construction
SERUUN SINCE 1991
БАТС-ӨРГӨӨ ХХК
MONCON MONGOLIAN CONSTRUCTION GROUP
barilga.mn
БУЯНПЭЛ ХХК
БАРМОН
RENDERBAU
BRIDGE CONSTRUCTION ISO 9001
TESO
DYNAMIC TOWER
VIP RESIDENCE
UNISTEEL
SKETCH LLC
EFES CONSTRUCTION
ТУМ АРВИЖИХ
БОДЬ ИНТЕРНЭШНЛ
GR PRECAST CO.,LTD
InvesCore PROPERTY LLC
BDMT BUSINESS DEVELOPMENT & MANAGEMENT TEAM
ТАВАН БОГА ПРОПЕРТИ ХХК
Хамтын хүч - Амжилтын түлхүүр
ОФФИС ПАРТНЕР
HIMON CONSTRUCTION
DOBU
СҮНДЭР ӨРГӨӨ ТРЕЙД ХХК
АЛТАН ЖОЛОО КОНСТРАКШН
BAGANAT URGUU COMPANY
HYUNDAI ХЬЁНДЭ ЭЛЕВАТОР МОНГОЛ ХХК
ТОПОЛОГИ ХХК ЭРЧИМ ХҮЧ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭД БҮТЭЦ
RENDER TRADE
ТЭНХЛЭГ ЗУУЧ УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
Ecological Civil Construction
ХУРД ГРУПП
GLOBAL TELECOM
NATIONAL ARCHITECTURAL PROJECT N.A.P GROUP
MINES UP
SOYOLON ENGINEERING
БАЗУРА ДИЗАЙН
АРГАЛАНТ АРВИС ГРУПП
UB GROUP
EUROZIGI ENGINEERING Co.,Ltd
ХАЙРХАН ГРУПП
MCS estates
ЦАГААН УРАН ХИЙЦ
BUTANGUUD CONSTRUCTION LLC
"БОДЬ ЦОГТ" ХХК
"AGGS" LLC
PD Solutions LLC
BULDOORS MON PERFECT DOOR SOLUTIONS
НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК
daco
МИШЭЭЛ ГРУПП
INTERNATIONAL
ULAANBAATAR PROPERTIES
Смарт Грийн Девелопмент
GOLDEN LIGHT GROUP
БАЯНСҮНДРЭЛ
ЭВЭР ТУУРАЙ ХХК
ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН ХХК
АЛХ ХАДААС ХХК
BOLD
IG CON ENGINEERING CONSULTANTS
"АТИМОС ТРЕЙД" ХХК
ego ENGINEERING & CONSTRUCTION
MONGOL 333 CORPORATION
РАДИУС ХХК
SILVER TOWER
ИМ ИХ МОДУН ХХК
ИНК ИНСТАЛЛ НАРАН КОНСТРАКШН
Oortsog-Uul
ГУРВАН БУХАТ ГРУПП
A1 ARCHITECTS
АССЭ ХХК
CHOKWANG PAINT
ZINDAA CONSTRUCTION
ЦАГААН ХӨШӨӨ ТРЕЙД
MANDALT CONSTRUCTION Co.,Ltd
ENDLESS energy
O&OCH LLC
NATIONAL CONSTRUCTION CONSULTING SERVICES
HAPPY BUILDING LLC
ОРОНТНУТАГ
RE/MAX STAR
ДЭЛГЭРЭХ ТАВАН ЧАНДМАНЬ ХХК
ОРГИЛ ЖИМ
ХОНТОЛ АРХИТЕКТ ХХК
DKH
RICHWELL ENGINEERING LLC
VISION DEVELOPMENT LLC
ГАНЬТ CONSTRUCTION AND TRADING
MMSE
ХАРХОРИН - ӨРГӨӨ ХХК
SATRADE
NAB GROUP NATIONAL ADVANCED BUSINESS
TML
MIRC CONCRETE
PARCO FACADE LLC
MPI consultants PETROLEUM CONSULTING & ENGINEERING
CONSTRUCTION

АГУУЛГА

01 15 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

02 ГИШҮҮДЭЭ ДЭМЖИН АЖИЛЛАХ ХҮРЭЭНД

03 ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

04 ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

05 ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД



МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫН 15 ЖИЛИЙН ОЙ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЛОО

МБҮА ТББ нь барилгын төсөл хөгжүүлэгчид, гүйцэтгэгчид, гэрээлэгчид, архитектур, зураг төсөл зохиогчид, барилгын ханган нийлүүлэгчид, зөвлөх үйлчилгээний компаниуд, материал үйлдвэрлэгчид, үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын зэрэг 200 орчим гишүүн компаниудаас бүрдсэн том гэр бүл болоод байгаа ба өнөөдөр манай гишүүн компаниудын цаашаа ажил олгож, хамтран ажиллаж буй компаниудыг оруулаад тоон дүнгээр авч үзвэл 100,000 илүү мянган ажлын байрыг бид улсдаа бий болгож явна.

2008 оны дэлхийн санхүүгийн хямрал Монголын эдийн засагт нөлөөлж түүний дотор барилга үл хөдлөх хөрөнгийн салбарт огцом уналт бий болсон цаг үед энэ чиглэлээр ажилладаг бидний хэдэн нөхөд нийлж хямралыг хэрхэн бага хохиролтой даван туулах, түүний төлөө нэгдэж хамтарч ажиллах зорилгоор МБҮА-ыг анх байгуулж байлаа.

МБҮА ТББ-ын зорилт нь улс үндэснийхээ хөгжлийн зорилттой нэгдмэл, органик холбоотой байж улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулах, ойрын зорилт нь олон айл, байгууллагуудыг орон байр, ажиллах орчинтой, амар түвшин ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэх явдал юм. Нэг үгээр хэлбэл бидний зорилт бол Монгол Улсын хөгжил дэвшил гэж үздэг.

Бид өнгөрсөн 15 жилийн хугацаанд хөгжлийн стратеги төлөвлөгөө гарган ажиллаж өөрийн гишүүд, салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд багагүй үр дүнд хүрчээ. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж ирсний үр дүнд Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож иржээ.

Барилгын бизнесийн орчныг сайжруулах, зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулах ажлыг манлайлан ажилласны үр дүнд энэ ажлыг ТББ- уудаар гүйцэтгүүлэх шийдвэрийг төр засгаар гаргуулан, 7 дахь жилдээ салбарын 6 холбоодтой хамтран амжилттай гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар уг үйл ажиллагаа бүрэн цахимжиж, байгууллагууд ажлын 5-7 хоногт зөвшөөрлөө авдаг болсон байна.

Мөн бид гадаад харилцаагаа тогтмол өргөжүүлэн ажилласны үр дүнд Ази болон Баруун Номхон Далайн Орнуудын Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүнээр 5 дахь жилдээ ажиллаж, олон талт хамтын ажиллагааны үр дүнд эдгээр байгууллагуудын дэмжлэгтэйгээр Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо, FIDIC н Түншлэгч гишүүнээр сонгогдон идэвхтэй ажиллаж байна. Үүний үр дүнд бид саяхан Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын эрхийг авч үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болж бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Мөн бид Франц Улсын Жэрэс Монгол ОУТББ хамтран Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын айлуудын дулаан алдагдлыг бууруулахад мэргэшсэн технологийн сургалтаар дамжуулан бригадуудаар дулаалга хийлгүүлэх сургалт, дадлагад чадавхжуулах, нийслэлийн төлөвлөлтгүй бүсэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг барихад зөвлөгөөг өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээг үзүүлэх зорилготой төслийг хэрэгжүүлэхээс гадна 15 жилийн түүхтэй МБҮА -ыг өндөр хөгжилтэй орнуудын ижил төрлийн холбоодтой харьцуулахад туршлага дутмаг, хүнээр бол өсвөр

насандаа яваа хэдий ч энэ нас бол хамгийн эрч хүчтэй нас юм.
Монголын барилгын салбарын хөгжилд зөв манлайлал үзүүлж ажиллана гэсэн уриатай ТББ -ын хувьд бид цаашдын үйл ажиллагаандаа дараах хэдэн чиглэлийн хамтын ажиллагааг онцгойлж байна.
Нэгдүгээрт: Дотооддоо улам олуулаа болон нэгдэн нягтарч, супер гүйцэтгэх чадвартай холбоо болох
Хоёрдугаарт: Хэрэглэгчидтэй нягт хамтран ажиллан, тэдэнд чухам ямар бүтээгдэхүүн хэрэгтэй байгаа, барилгаас шалтгаалсан ямар асуудлууд,хүндрэл бэрхшээлүүд бий болоод байгааг сайн мэддэг байх
Гуравдугаарт: Төр, засгийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллах замаар улс орны хөгжлийн зорилт, стратегитэй ажлаа уялдуулан ажиллах
Дөрөвдүгээрт: Харилцан уялдаатай салбарын болон бусад салбарын ижил төрлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах Ингэснээр салбарт тулгамдаж буй асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлээд явах боломж бүрдэнэ.
Тавдугаарт: Хөгжингүй орнуудын ижил төрлийн холбоодтой маш сайн хамтарч ажиллах замаар барилгын салбарын орчин цагийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах талаар ажиллахаар төлөвлөж байна.
Ойн арга хэмжээгээр тус байгууллагад өнөөдрийг хүртэл санхүү болоод цаг зав, сэтгэл зүрхээ гарган мөр зэрэгцэн яваа ЭКО КОНСТРАКШН ХХК, ЭС ДИ ИНЖЕНЕРИНГ ЭНД КОНСТРАКШН ХХК, НБИК ХХК, ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК, БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК, ЗАГ ГРУПП ХХК нартаа Ерөнхийлөгчдийн нэрэмжит шагналыг гардууллаа. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Тэргүүний барилгачин цол тэмдэгээр Ажлын албаны ажилтан Б.Отгонгэрэл, Жуух бичгээр А.Гантуул нар тус тус шагнууллаа.


Бидний урилгыг хүндэтгэн хүлээн авч хүрэлцэн ирсэн:

- Х.Баделхан БХБ-ын сайд асан
- Өргөн тээвэрлэх машин төхөөрөмж үндэсний холбооны Тэргүүн Н.Ганболд
- Монголын Барилгын Инженерүүдийн Холбооны Ерөнхийлөгч Б.Гантулга
- Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын Холбооны Ерөнхийлөгч Я.Сумхүү
- Монголын Барилгын Инженер Геологичдын Холбооны Тэргүүн Л.Ганзориг
- Монголын Барилгын Төсөвчдийн Холбооны Тэргүүн Ү.Банди
- Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбооны Ерөнхийлөгч Ц.Эрдэнэбат
- Г.Мягмар Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төвийн ТУЗ-ын дарга
- Р.Шагдаррагчаа Барилга корпораци ХХК
- Б.Жүгдэр Улаанбаатар барилга ХХК
- Ц.Амарсанаа Улаанбаатар дулааны сүлжээ ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал
- Ц.Эрдэнэбат Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбоо ТББ
- Жэрэс ОУТББ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Квинтин Морро
- Б.Ганзориг МБҮА ТББ-ын Үүсгэн байгуулагч
- Я.Батцэцэг Ажлын албаны анхны Гүйцэтгэх захирал, Б.Бямбажав, Д.Цэнд болон барилга, бүтээн байгуулалтын салбарын хамт олны төлөөлөл та бүхэндээ МБҮА-ийн Ерөнхийлөгчид, УЗ-ын гишүүд, Нийт гишүүд, Ажлын албаны нэрийн өмнөөс талархал илэрхийлж МБҮА ТББ байгуулагдсаны 15 жилийн ойн баярын мэндийг хүргэе!

Бидний ажлын үр дүнд Монголын барилгын салбар өөдрөг байвал бидний хувийн бизнес өөдрөг байх нь гарцаагүй.

15 жил хөгжил дэвшлийн төлөө хамтдаа байсан Та бүхэндээ баярлалаа

АЗИ БАРУУН НОМХОН ДАЛАЙН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ (IFAWPCA)-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ НОЁН КЕННЕТ ЛУ



ifawpca

GREETINGS FROM THE IFAWPCA PRESIDENT

On behalf of the International Federation of Asian and Western Pacific Contractors' Associations (IFAWPCA), I extend my heartfelt congratulations to the Mongolian National Construction Association (MNCA) on your remarkable 15th Anniversary.

Your journey over the past 15 years has been one of dedication, resilience, and significant contributions to the construction industry in Mongolia. The commitment of the MNCA NGO staff to advancing the sector and fostering collaboration is truly commendable.

As a member of IFAWPCA, MNCA plays a vital role in strengthening regional cooperation and sharing expertise among member countries. We encourage MNCA members to actively participate in IFAWPCA's activities, including conventions, dialogues, and knowledge-sharing platforms, to further build connections and advance our shared vision for the construction industry. The next IFAWPCA Convention will be held in Singapore from 7-11 April 2025, and we look forward to welcoming the Mongolia delegation to join us as well.

Congratulations once again on this milestone achievement. May MNCA continue to reach greater heights in the years to come!

Sincerely,
Mr Kenneth Loo
President, IFAWPCA

Ази, Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн нэрийн өмнөөс та бүхэнд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойн баярын халуун мэндийг хүргэж байна. Та бүхний бүтээсэн 15 жил Монгол Улсын барилгын салбарын хөгжилд тууштай, даацтай, чухал хувь нэмэр оруулсан аялал байлаа. МБҮА ТББ-ын ажилтнууд салбараа хөгжүүлж, хамтын ажиллагааг дэмжиж эрчимжүүлэхийн төлөө ажиллаж байгаа нь үнэхээр сайшаалтай байна. Ази, Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн гишүүний хувьд МБҮА нь гишүүн орнуудын хооронд бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдлэг, туршлага хуваалцах солилцох чиглэлд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. IFAWPCA-ийн үйл ажиллагаанд, түүний дотор хурал чуулган, яриа хэлэлцээ, мэдлэг хуваалцах хөтөлбөрүүд, харилцаа холбоог бий болгох, өргөжүүлэх, барилгын салбарын хамтын алсын хараагаа хэрэгжүүлэх үйлсэд ахиц дэвшил гаргахад МБҮА-ын гишүүдийн идэвхтэй оролцоог бид хөхиүлэн дэмжиж байдаг юм. IFAWPCA-гийн ээлжит их хурал 2025 оны 4-р сарын 7-11-ний өдрүүдэд Сингапурт болох бөгөөд Монголын төлөөлөгчидтэй уулзахыг бид сэтгэл догдлон хүлээж байна.Та бүхний өнгөрсөн хугацаанд бүтээсэн ололт амжилт бүхэнд дахин баяр хүргэе. МБҮА ТББ ирэх жилүүдэд улам өндөр оргилд хүрэх болтугай гэсэн ерөөл өргөе!

Хүндэтгэсэн,
IFAWPCA-гийн Ерөнхийлөгч Кеннет Лу


БНХАУ-ЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН НИЙГЭМЛЭГИЙН ДАРГА ФАН КИУЧЕНЬ

Эрхэм Ерөнхийлөгч Н.Баярсайхан,
Эрхэм зочид, төлөөлөгчид,
Ноёд хатагтай нар аа,

БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэгийн нэрийн өмнөөс Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын хамт олонд 15 жилийн ойн баярын халуун мэндчилгээ дэвшүүлэх завшаан тохиосонд маш их баяртай байна.

Сүүлийн жилүүдэд Хятад, Монгол хоёр орны стратегийн түншлэлийн харилцаа тууштай хөгжиж, олон салбарын ажил хэрэгч хамтын ажиллагаа, ялангуяа дэд бүтцийн салбарт шинэ ахиц дэвшил гарлаа.

Бид хамтдаа зам, гүүр, сэргээгдэх эрчим хүчний байгууламж, орон сууц гэх мэт



中国对外承包工程商会
China International Contractors Association

2024 оны 11 сарын 28

Н.Баярсайхан
Ерөнхийлөгч
Монголын Барилгын Үндэсний Ассоциаци (МБҮА)

Эрхэм хүндэт н. Нямрагчаагийн Баярсайхан танаа,

Таны 11-р сарын 27-ны өдрийн захидлыг хүлээн авч, элэгсэг дотно урилга илгээсэнд тань маш их баярлалаа. Гэвч урьдчилан төлөвлөсөн албан ёсны үйл ажиллагааныудаас шалтгаалан танай ойн арга хэмжээнд оролцож чадахгүй болсондоо хүлцэл өчье.

Миний бие Хятадын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (CHINCA)-ийн нэрийн өмнөөс танд болон танай гишүүдэд МБҮА-ийн 15 жилийн ойн халуун мэндчилгээ дэвшүүлье. 2010 онд найрсаг харилцаа тогтоосноос хойш МБҮА нь Монгол Улсын барилгын салбарын хөгжил дэвшилд онцгойлон анхаарч, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээвэр байгууллага болон амжилттай хөгжиж ирснийг бид харж байна.

Танай байгууллагын 15 жилийн ойтой холбогдуулан, та бүхэн CHINCA-г ихээхэн дэмжиж, дэд бүтцийн салбарт Хятад, Монголын компаниудын үр дүнтэй харилцаа холбоо, хамтын ажиллагааны платформыг бий болгоход оруулсан хувь нэмрийг тань эргэн дурсаж санахад туйлын таатай сайхан байна.

Бид хоёр талын барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөгжил цэцэглэлтэд хамтран ажиллах найрсаг харилцаа, үр дүнтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх болно гэдэгт итгэлтэй байна.
Та бүхэнд баярын мэнд хүргэж, 15 жилийн ойн ёслолын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Цаашид та бүхэнтэйгээ хамтран ажиллана хэмээн хүлээх сэтгэлд баяр төрүүлж байна.

Таныг хүндэтгэн ёсолсон,

Фан Киучень
Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэгийн дарга

нэлээд хэдэн төслийг хамтдаа амжилттай хэрэгжүүлсэн. Цаашдаа Хятадын Олон улсын гэрээлэгчдийн нийгэмлэг танай байгууллагатай улам нягт хамтран ажиллаж, гишүүдийнхээ солилцоог улам нэмэгдүүлэн, Хятад, Монголын дэд бүтцийн хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргахад бэлэн байна.

Танай байгууллагын сүүлийн 15 жилийн хугацаанд бүтээсэн асар их ололт амжилт, нөр их хувь нэмрийг би өндрөөр үнэлмээр байна.


Ингээд та бүхнийхээ 15 жилийн ойн баяр амжилт бүтээлээр дүүрэн байхыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе

ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБООНЫ МЭНДЧИЛГЭЭ

Сайн байцгаана уу,

Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (FIDIC)-ны Ерөнхийлөгч Кэтринь Каракатсанис миний бие нь дэд бүтцийн инженер бөгөөд Моррис энд Хиршфилд компанийн Үйл ажиллагаа хариуцсан захирлаар, одоо Stantec компанийн захирлын албыг хашдаг.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын 15 жилийн ойг тохиолдуулан танай гишүүдэд хандаж үг хэлж байгаадаа баярлаж, бахархаж байна. Та бүхэнд ойн баярын мэнд хүргэе.



International Federation of Consulting Engineers
The Global Voice of Consulting Engineers

Catherine Karakatsanis
President of FIDIC

Эрхэм хүндэт нөхөд ээ

Юуны өмнө Монгол Улсын Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн 15 жилийн ойн арга хэмжээ болж байгаа энэ түүхэн явдалд баяр хүргэе.

Энэхүү хүндэтгэлэгт үйл ажиллагаа нь түүхийн хуудаснаа тодоор тамгалагдан үлдэж байгаа нь тодорхой тэдийгүй Монгол Улсын барилгын салбараас анх удаа ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН болж бид бүхэнтэй зам мөрөө нэгтгэж байгаа та бүхэндээ баярлалаа.

Азийн улс орнуудаас шинэхэн хөгжиж буй орнуудын тоонд орж улс орноо хөгжүүлэн мандуулахад ихээхэн ач холбогдол өгч буй та бүхэн тэр дундаа МБҮА ТББ-ынхаа хамт олон, нийт гишүүдэд нь түүхэн ойгоо ёслол төгөлдөр өнгөрүүлэх гэж буйд талархал дэвшүүлье.

Та бүхэндээ 15 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье, манай хоёр байгууллагын хамтын ажиллагаа улам өргөжин хөгжиж байгаад баяртай байна.

Та бүхний зохион байгуулж байгаа баярын арга хэмжээнд өндөр амжилт хүсье.

Хамгийн сайн сайхныг хүсэн мэндчилсэн,

C. Karakatsanis

Кэтрин Каракатсанис, M.E.SC., P.Eng., ICD.D, FEC, FCAE, LL.D., D.Eng.
Ерөнхийлөгч
Инженерийн ухааны магистр, Мэргэжлийн инженер, ICD.D, FEC (Канадын шилдэг инженер цол), FCAE (Чанарын инженер), Хууль зүйн доктор, Инженерийн ухааны доктор.

FIDIC SECRETARIAT
World Trade Center II, Geneva Airport, P.O. Box 311, CH-1215 Geneva 15, Switzerland
+41 22 560 9700 - www.fidic.org - IDE Number: CHE-106.002.602 TVA

Та бүхэн гишүүдийнхээ болон салбарынхаа ашиг сонирхолд нийцүүлэн барилгын салбарын бодлого, хууль эрх зүйн болон эдийн засгийн орчны шинэчлэлийг хийх үйл ажиллагаагаараа дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулахын төлөө хичээн зүтгэж байна. Эдгээр нь сайн засаглал, хамтын ажиллагаа, инноваци, хөгжил, тогтвортой байдлын төлөөх та бүхэн урт хугацаанд гаргасан сайшаан магтууштай чармайлтууд мөн.

ФИДИК нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа манай бүх гишүүн холбоодын нэгэн адил эдгээр бүх зорилгыг тавьж ажилладаг бөгөөд МБҮА зэрэг ФИДИК-ийн гишүүн холбоод, тэдгээрийн гишүүн компаниудын хийж буй гайхалтай бүтээн байгуулалтаар улс орныхоо иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж байгааг хэзээ ч дутуу үнэлж болохгүй билээ. Бид хийж бүтээж байгаа ажлаа байнга тэмдэглэж байх ёстой бөгөөд танай байгууллагын 15 жилийн ой бол үүний нэг төгс жишээ илэрхийлэл юм.

МБҮА ТББ болон түүний гишүүн компаниуд эдгээр зорилтыг шийдвэрлэх чухал шийдлүүдийг гаргахад гол үүрэг гүйцэтгэдэг. Түүхт 15 жилийн ойн баярыг тохиолдуулан МБҮА ТББ нь Монгол Улсад манлайлах чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэн баяр хүргэхийг хүсч байна. Сайн засаглал, манлайлал нь та бүхний үнэт зүйлсийн нэг бөгөөд та бүхний хийж байгаа хэлэлцүүлэг, яриа хэлэлцээгээр дамжуулан төрийн бодлогод нөлөөлж, салбарын үйл хэргийг урагшлуулахад чиглэсэн ажлууд тань маш чухал гэдгийг би мэднэ. Манлайлал нь аливаа ажил мэргэжлийн холбоонд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ФИДИК нь дэлхийн барилгын салбарт мөн л энэ үүргийг гүйцэтгэдэг.

МБҮА ТББ нь дэлхийн холбоонд гишүүнээр элсэж, ФИДИК-ийн үйл ажиллагааг дэмжиж байгаад талархаж байна. Гишүүдийнхээ байнгын дэмжлэг, оролцоогүйгээр бид үр дүнтэй ажиллаж чадахгүй. Тиймээс би та бүхэнд ФИДИК болон дэлхийн барилгын салбарыг дэмжих чиглэлээр цаашид ихийг хийх болно гэдгийг мэдэж байна, та бүхнийхээ хийсэн бүхэнд тань маш их баярлалаа гэж хэлмээр байна.

Манай салбарт, бидэнд тулгардаг сорилтууд маш олон. Үүний дотор дижитал технологийн хөгжлийн асар өндөр хурдац, тэр дундаа бидний бизнес хийх арга барил, ажлын дадал, арга барилыг ирээдүйд өөрчлөх бодит боломж бүхий хиймэл оюун ухааны хөгжил томоохон сорилт болж байна. Бид бүгдэд тулгардаг өөр нэг бэрхшээл бол үйлчлүүлэгчдийн өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээ, бидний хэрэгжүүлж буй төслүүдийн хүлээлт юм. Эдгээр төслүүдийн эцсийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ ч илүү их болж байгаа нь инженерүүд бидний өмнө тулгардаг хүлээлтийг нэмэгдүүлж байна. Магадгүй хамгийн чухал нь бид уур амьсгалын өөрчлөлтийн сорилттой тулгарч, ирээдүй хойч үедээ эх дэлхийдээ ээлтэй дэд бүтцийг бий болгох хэрэгцээ шаардлагатай тулгарч байгаа нь бид сорилтод бэлэн байхыг, засгийн газар болон бусад шийдвэр гаргагчдад инженер, архитектор, зөвлөхүүд бүхий л салбарт ажиллах шаардлагатай болно шүү гэдгийг сануулж байна.

ФИДИК нь олон улсын харилцаа холбооны 112 жилийн түүхээрээ бахархдаг. МБҮА ТББ шиг гишүүд ФИДИК-ийн үндэс суурь бөгөөд бид та бүхний тусламжгүйгээр олон улсын хэмжээнд хийж байгаа амжилтдаа хүрч чадахгүй билээ. Тийм учраас өнөөдөр танай байгууллагын 15 жилийн ойн арга хэмжээнд үг хэлэх завшаан тохиож байгаа нь миний хувьд нэр төрийн хэрэг юм.

Төгсгөлд нь, та бүхний өнөөдрийн арга хэмжээнд болон Монголын барилгын салбарт өөрийн дурсамжаа бүтээн оролцож байгаа та бүхнийхээ цаашдын ажил үйлсэд тань хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. ФИДИК-ийн үйл ажиллагааг үргэлж дэмжиж байдагт дахин талархал илэрхийлье, ойрын ирээдүйд та бүхэнтэй биечлэн уулзана гэдэгтээ итгэлтэй байна. 15 жилийн ойн мэнд хүргэе! Та бүхэн ойрын ирээдүйд биечлэн ирээрэй. 15 жилийн ойн мэнд хүргэе!

Сайн сайхныг хүсэн ерөөе.

Баярлалаа











ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ-ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТ-2024”-ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙЛЭЭ

МБҮА ТББ нь “Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх тухай” Засгийн газрын 2014 оны 08 дугаар сарын 07-ний 250 дугаар тогтоолын хүрээнд салбарын /7/ ТББ-ууд түншилж, 2018 оноос “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдэд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэж эхэлсэн нь салбартаа төдийгүй бусад салбарт төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны САЙН ЖИШИГ болж, Дэлхийн банкны 2019 оны “DOING BUSINESS” индексийн үзүүлэлтээр Монгол Улсын

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БҮАТЗ олгох үйл ажиллагаа нь дэлхийн 190 орноос 29-р байранд ЭРЭМБЭЛЭГДСЭН юм. Энэ нь БҮАТЗ олгох эрхийг ТББ-д шилжүүлснээр БИЗНЕСИЙН ОРЧИН сайжирсныг илтгэсэн үзүүлэлт болсон бөгөөд бид 2019 онд БҮАТЗ олгох үйл ажиллагааг хагас цахимжуулсан бол 2021 оноос бүрэн цахимжуулж төрийн үйлчилгээний ХУР, ДАН, И-МОНГОЛ системүүдтэй холбож, барилгын салбарын нэгдсэн мэдээллийн санг бий болгон холбосон. Энэ систем нь хүний оролцоогүй, ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээтэй, аливаа дундын зуучлалгүй, салбарын инженер, техникийн ажилтнуудын статистик тоон үзүүлэлтийг нэгтгэсэн, ХҮНД СУРТАЛ, АВЛИГААС АНГИЖРУУЛСАН СИСТЕМИЙГ Монгол Улсад нэвтрүүлснээрээ онцлог, давуу талтай болсон юм. Одоогийн байдлаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлт гаргах, хянах, шийдвэрлэх үйл ажиллагаа нь цаасан материал бүрдүүлэлт ихтэй, ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах, тодруулах, лавлагаа авах гэх мэт хүний оролцоо ихтэй, цаг хугацаа шаардсан үйл ажиллагаатайгаас гадна мэдээллийн үнэн зөв, баталгаат байдал хангалтгүй, бусад мэдээллийн сангийн цахим системүүдтэй холбогдох боломжгүй байсан зэрэг хүндрэл, дутагдалтай асуудлуудыг цахимд шилжсэнээр бүрэн шийдээд байна.

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛАГУУДАД БҮАТЗ-ИЙН ХҮСЭЛТ НЬ БУЦААГДАЖ БАЙГАА НИЙТЛЭГ ЯМАР ШАЛТГААНУУД БАЙГААГ ТОДРУУЛАХАД:

- ХАБЭА ажилтан шаардлага хангахгүй
- ХАБЭА-н гэрчилгээний хугацаа шаардлага хангахгүй
-ХАБЭА-н ажилтан бэлтгэх 124 цагийн сургалтад хамрагдсан байх (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/173 дугаар тушаал, "ХАБЭА-н сургалт явуулах болон шалгалт авах журам")
-Инженер техникийн мэргэжил боловсролтой, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх/
-Байгууллагын, тоног төхөөрөмжийн, гүйцэтгэсэн ажлын мэдээлэл, Нормчлолын сан төлөлтийн мэдээлэл дутуу оруулах
-ИТА давхцал, боловсролын мэдээлэл дутуу оруулах
- НДШ, тайлан дутуу оруулах
-ПРОГРАММ-д оруулсан мэдээллээ шууд засах, буцаах боломжгүй учир хүсэлт илгээсний дараа буцааж байж засдаг

-Үйлчилгээний хураамж төлөөгүй гэх мэт олон шалтгаануудаас буцаагддаг учир энэ талаар маш сайн нягталж байж мэдээллээ оруулдаг байвал та нэг удаагийн үйлдлээр бүртгэлээ албажуулж чадна.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГУУД ЯМАР ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭДЭГ ВЭ?

-Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох асуудлыг гэрээний үндсэн дээр хариуцагч, барилгын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хооронд байгуулсан гэрээ-ний үүргээ биелүүлээгүй бол хэрхэн хариуцлага тооцох нь тодорхой бус
-Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ -д хариуцлага тооцдоггүй
-Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн бус байснаар хууль дүрэм зөрчих, чанаргүй барилга барих, ИТА-аар ёс зүйгүй үйлдэл хийлгэх, ажилчдын цалин НДШ төлөхгүй байх, ХАБЭА дүрэм журам зөрчих зэрэг зөрчил гаргах
- Зарим ААНБ орон сууцны захиалга авч иргэдийг хохироох, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгчдийн төлбөр тооцоо барагдуулахгүй байх
- Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох тогтолцоо байхгүй гэх мэт түгээмэл зөрчлүүд гарч байна.

АСУУДАЛ ЮУН ДЭЭР ҮҮСЭЭД БАЙГАА ВЭ?

-БҮАТЗөвшөөрлийг шатлан олгох болсноор шинээр БҮАТЗ авч байгаа ААНБ-ууд дунд, өндөр төвөгшилтэй тусгай зөвшөөрөл авах боломжгүй болсон.
-Гадаадын ХО-тай томоохон төсөл хэрэгжүүлэгч дунд, өндөр төвөгшилтэй БҮАТЗ авах боломжгүй болсон.
-ИТА суурьтай ХАБЭА ажилтныг журам гарган шаардах болсон
-ИТА нь НДШ 1-3 сар төлсөн байх гэх мэт Барилгын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд заагаагүй материал журам гарган шаарддаг болсон нь бодит амьдрал дээр маш их асуудал үүсгэдэг.

ТИЙМЭЭС ДЭЭРХ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ОЛОН ТАЛУУДЫН САНАЛЫГ СОНСОЖ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ, ХУУЛЬ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА ТУЛГАРЧ БАЙНА.

-Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэгдэн хэрэгжсэн тул Барилгын тухай хууль, БҮАТЗ-ийн журамд өөрчлөлт оруулах
-БҮАТЗөвшөөрлийг шатлалгүй шаардлага хангасан ААНБ-д олгодог болгох
-ХАБЭА ажилтан барилгын инженер техникийн ажилтан суурьтай байхыг хасах, цаашид Барилгын ХАБЭА ажилтан бэлтгэдэг болох
-Бусад салбарын болон гадаадын мэргэшлийн зэргийг МУ-ын барилгын салбарын мэргэшлийн зэрэгт дүйцүүлэн тооцох
-Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын Гүйцэтгэх удирдлага мэргэжлийн биш бол Барилгын менежмент сургалтын 3 багц сургалтад хамруулах
- ИТА шилжилт хөдөлгөөн, ААНБ-ын тайлан хүлээн авах үйл ажиллагааг ТББ-д шилжүүлэх
- БҮАТЗ-ийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах, Гэрчилгээ, гэрээг цахимаар олгодог болгох
-Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам зөрчигчдөд хариуцлага тооцох тогтолцоог бий болгож хуулийн хэрэгжилтийг хангах
- Тусгай зөвшөөрлийн тоог бууруулах гэх мэтээр асуудлыг олон талаас нь харах, шийдвэрлэх нөхцөл байдал үүсээд байна.

БАРИЛГЫН КОМПАНИУДАД ГАЛЫН МАГАДЛАЛ ХИЙХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫГ ХЯЛБАРШУУЛАХААР МБҮА ТББ ОБЕГ-ЫН УДИРДЛАГУУДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Барилга бүтээн байгуулалтын салбарынханд төслийн ажлаа хийж гүйцэтгэх, ашиглалтад өгөх, техникийн нөхцөл авах, галын зөвшөөрөл авч эх загвар зураг (эскиз), иж бүрэн ажлын зураг батлуулах зэрэг үйл

ажиллагаанд маш олон асуудлууд гардаг бөгөөд уг ажлын хүрээнд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх ОБЕГ-ын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга хурандаа Д.Баян-Эрдэнэ, тасгийн дарга дэд хурандаа Б.Мягмаржав нартай цаг үеийн болон тулгамдсан асуудлын талаар 2024.11.13-ны өдөр уулзалт хийлээ.

Уулзалтаар барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийх, улсын комисст ажиллах, барилгын үйл ажиллагаанд явцын хяналт хийхэд гарч байгаа тулгамдсан асуудлыг ярилцаж, уг асуудлыг цаашид хэрхэн хялбаршуулах гарц шийдлийн талаар болон бусад цаг үеийн асуудлаар санал солилцож улмаар барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудтай 2024.12.03-ны өдөр ажил хэргийн уулзалт хийж хамтран ажиллахаар тогтлоо.

МЕГА ТӨСЛҮҮДЭД МОНГОЛЫН БАРИЛГЫН САЛБАРЫНХАН ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

Монгол Улсын Засгийн газрын зүгээс ирэх 2025 онд үндэсний орон сууцжуулалтын бодлого, хот төлөвлөлт, бүтээн байгуулалт, ипотекийн зээлийн хүрээнд томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхээр болж байгаа бөгөөд Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбооны зүгээс улс орны бүтээн байгуулалтад чухал үүрэгтэй гүйцэтгэгч байгууллагуудад тулгарч буй сорилтууд болон тус төслүүдийн хүрээнд төр болон хувийн хэвшил хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монгол Улсын хувьд нийт өрхийн 30 хувь нь орон сууцанд, 70 хувь нь инженерийн дэд бүтэцгүй байшин хороолол, гэрт амьдарч байна. Үүнээс Улаанбаатар хотод 273,736, аймгийн төвд 144,308, сумын төвд 295,775 өрх орон сууцгүй байна.

Монгол Улсын Засгийн Газар 14 мега төсөл хэрэгжүүлэхээр, Үндэсний орон сууцны хөтөлбөрийн хүрээнд 150,000 орон сууц барихаар, Нийслэл түгжрэлийг бууруулах төсөл, Хөшгийн хөндий - Шинэ Зуунмод хот, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэхээр болж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, гүйцэтгэгчдийг оролцуулахаар саналаа зарлаад, уулзалтууд хийгээд эхэлсэн байна. Иймд тус мега төслүүд хэрэгжихэд барилгын компаниуд хэрхэн оролцох вэ? Мега төслүүд хэрэгжүүлэхээр Гадаадын хөрөнгө оруулалт төслийн менежменттэй компаниуд орж ирэхэд Монголын компаниуд бэлэн байна уу?



Мега төслүүдийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчин, барилгын норм ба дүрэм стандартууд шаардлага хангах уу? Эрчим хүч, дэд бүтэц, хүний нөөц, барилгын материал, түүхий эд, тээвэр ложистик зэрэг нөөцүүдийг хэрхэн шийдвэрлэх вэ?зэрэг асуудлаар хэлэлцэж хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлаа. Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбооноос зохион байгуулсан энэхүү уулзалтад барилгын салбарын ТББ-ууд, ААНБ-ууд, экспертүүд оролцож санал солилцлоо.

Тус арга хэмжээнд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болон удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөллүүд оролцож саналаа солилцлоо.

БАРИЛГЫН САЛБАРЫН “НОГООН БАРИЛГЫН МАНЛАЙЛАГЧ” НАР ТОДОРЛОО



Улсын Их Хурлын 2014 оны 43-р тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого” баримт бичгийг баталж, энэ хүрээнд байгаль орчинд ээлтэй,



эрчим хүч болон байгалийн нөөцийн хэмнэлттэй барилга байгууламж төлөвлөх, барих зарчим, үзэл баримтлалыг баталсан. Үүний дагуу “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, “Алсын хараа 2050” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд ногоон хөгжлийг эх орондоо нутагшуулах, дагаад барилга, хот байгуулалтын салбарт уг чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн нөхцөл бололцоог нэмэгдүүлэх, холбогдох барилгын норм ба дүрмүүдийг шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсны дагуу “Ногоон барилгын хүрээлэн” ТББ (Green building council NGO) шинэчлэн байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлийг баталсан бөгөөд тус зөвлөлд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ багтдаг билээ. Энэ хүрээнд ногоон барилгын хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй хувь хүн, байгууллагуудын ажлыг олон нийтэд сурталчлах, урам зориг өгөх, Монголын

ногоон барилгын салбарын манлайлагчдыг тодруулж, тэдний бүтээлч санаачилга, хичээл зүтгэлийг үнэлэх зорилгоор "Ногоон Барилгын Манлайлагч" (Green Building Champion) шалгаруулах ёслолыг Ногоон Барилгын Хүрээлэнгээс 2024.12.05-ны өдөр Блю скай зочид буудалд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд УИХ, Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, УИХ-ын гишүүн А.Ундраа, Барилгын Хөгжлийн Төв ТӨААҮГ-ын захирал Т.Пүрэвхатан, Ногоон Барилгын Хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар оролцлоо.

Монгол улсад ногоон барилга, байгууламжийн талаарх мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, ногоон барилгын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, баталгаажуулах аргачлалыг хөгжүүлэхэд идэвхтэй оролцож, үнэтэй хувь нэмэр оруулсанд талархал илэрхийлж “Ногоон барилгын манлайлагч” -аар тодруулан, дараах байгууллагуудад батламжийг олгов.

- “Хүрээлэн буй орчин” бүлэг-т Н.Дорж
- “Эрчим хүч, дулаан” бүлэг -т Пассив хаус хүрээлэн Н.Ганбаа
- “Материал болон нөөц” бүлэг -т Монгол Базальт ХХК -ийн Ерөнхий захирал Л.Ариунболд
- “Усны хэмнэлт” бүлэг-т Ультрасоник ХХК захирал Б.Чимэгцэцэг
- “Дотоод орчны чанар” бүлэг -т МАК Евро Венти үйлдвэр
- “Тэсвэржилт” бүлэгт - Japan Internatinal Cooperation agency - Жайка Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Мияги Кэнсүеэ, В.Ойдов
- “Эрчим хүч ба усны хэмнэлт” бүлэгт Ж.Чинзориг нар тус тус шалгарлаа.



ТЕНДЕРТ ОРОЛЦОЖ БУЙ БАРИЛГЫН КОМПАНИУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА



Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт томоохон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу уг бүтээн байгуулалтад оролцох, хамтрах барилгын компаниудыг шалгаруулах хууль эрх зүйд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй нөхцөл үүсээд байгаа талаар Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд гишүүний Ажлын албаныхан барилгын салбарын төрийн бус байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийлээ.Уулзалтаар өнөөдрийн мөрдөгдөж байгаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд нийтлэг зарчмын дагуу явагддаг, хамгийн бага үнийн санал өгсөн компанийг шалгаруулах гэх мэтээр бүтээн байгуулалтад оролцож буй компаниудын шалгуур үзүүлэлтийн нөхцөл байдал тодорхой бус байдаг нь барилгын чанар болоод хугацаа алдагдах, гэрээний маргаан үүсэх гээд олон маргаан дагуулах болсон талаар санал солилцож, хуулийн хаана нь ямар зүйл заалтыг өөрчлөх, саналаа тусгах зэрэг дээр барилга бүтээн байгуулалтыг босгож буй компаниудын төлөөллүүдийг оролцуулж, санал бодлыг тусгаж ажиллах тал дээр ойлголцолд хүрлээ. МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх уулзалтад оролцож тендер шалгаруулалт шударга бус явагддаг, санхүүжилт авах гэж хүнд сурталтай тулгардаг, төсвийн үнэлгээг зах зээлийн үнээр тооцох, 1 барилгын санхүүжилтийг олон жил дамнуулан санхүүжүүлэхийг болих, бага үнээр биш чанарын шалгууруар үнэлэх, тендерт олон тусгай зөвшөөрөл шаардахгүй төслийн менежментийг хэрэгжүүлсэн санхүүгийн чадавхтай компанийг сонгох, цаашид тендерийн тогтолцоог өөрчилж олон улсын жишигт хүргэн хууль дүрэмдээ өөрчлөлт оруулж шинэчлэхийг санал болголоо. Мөн гишүүн байгууллагуудынхаа саналыг авч тендерийн хууль дүрэмд бичгээр санал өгөхөөр боллоо.

МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧДИЙН НЭРЭМЖИТ ДУРСАМЖ-15 УУЛЗАЛТ БОЛЛОО

МБҮА ТББ-ын үүсэн байгуулагдсаны 15 жилийн ой 2024 онд тохиож буй бөгөөд ирэх 2024.12.07-ны өдөр ойн арга хэмжээгээ тэмдэглэх гэж байна.



“ДУРСАМЖ ҮДЭШ – 15 ЖИЛ” арга хэмжээг гишүүдийнхээ хүрээнд зохион байгуулж анх байгууллагаа хэрхэн үүсэн байгуулагдаж байсан талаарх түүх, дурсамжуудаа хүүрнэж, жаргал зовлонгоо хуваалцсан халуун дулаан үдшийг өнгөрүүллээ.

Монгол Улсын томоохон барилга, бүтээн байгуулагчид, хөрөнгө оруулагчид, захиалагчид, үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгчид, барилга угсралтынхан, барилгын материалын үйлдвэрлэгчид болон ханган нийлүүлэгчид, зураг төсөл зохиогчид, архитекторуудыг компаниудыг эгнээндээ нэгтгэж, нийгэмдээ болон гишүүддээ үйлчилдэг, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэдэг, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг, салбарын мэргэжлийн, манлайлагч байгууллага болсон байна. Эдүгээ МБҮА ТББ нь “Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах” үйл ажиллагааг БХБ-ын Сайдын 2023 оны 14 дүгээр тушаалаар БХБЯ-тай салбарын бусад мэргэжлийн ТББ-уудын түншлэлийн хамтаар үргэлжлүүлэн гүйцэтгэх эрхээ авч “ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА”-ны хамгийн сайн туршлагыг салбартаа нэвтрүүлэн манлайлан ажиллаж байна.

Мөн Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг болох (IFAWPCA)-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг Барилга, хот байгуулалтын яам, IFAWPCA-тай хамтран Монгол Улсад анх удаагаа зохион байгуулж Монгол Улсын барилга бүтээн байгуулалтын салбарын ААНБ-уудыг гадаадын зах зээл дээр гарч ажиллах болон хөрөнгө оруулалтыг эх орондоо татах боломжийг олгосон билээ.

Түүнээс гадна хувийн хэвшлийн хамгийн том нэгдэл болох Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ын “XXI их хурал”-д оролцож, МҮХАҮТ-ЫН 5,000 гаруй гишүүдээс “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”, улмаар “ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН”-ээр сонгогдож, өөрсдийн дуу хоолойг бизнесийн талбарт улам хүчтэй хүргэн ажиллаж эхэллээ.

МБҮА ТББ нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо болох ФИДИК-ийн “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”-ээр 2023 онд болсон бөгөөд ингэснээр ФИДИК-ийг Монгол Улсад төлөөлөн барилга, хот байгуулалтын салбарт ФИДИК-ийн гэрээг хэрэгжүүлэх үйл явцыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган чадавхжуулах ажлыг зохион байгуулж, салбарын үйл ажиллагаанд оролцогч хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч нарын хоорондын харилцааг зохицуулж, эрх тэгш байдлыг хангаж, хамгаалан ажиллах үүргийг хүлээж, улмаар ФИДИК-ийн гэрээг түгээх Гишүүн холбоод, гишүүдийн нийтлэг мэргэжлийн эрх ашгийг хөгжүүлж, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН орчныг стандартын дагуу хэрэгжүүлж шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

МБҮА ТББ-ын үе үеийн Ерөнхийлөгчдийн нэрэмжит “ДУРСАМЖ ҮДЭШ – 15 ЖИЛ” арга хэмжээний үеэр байгууллагынхаа ойн арга хэмжээнд зориулан Цаст констракшн ХХК-Платинум, NBIK ХХК, Эрчим инженеринг ХХК, Буянпил ХХК Алтан багц, Грийн ресурс ХХК, Оргил Жим ХХК, Бодь интернэшнл ХХК нар дэмжигчээр оролцлоо. Мөн тус арга хэмжээнд оролцоогүй ч хандив өгөхөө илэрхийлсэн олон компаниуд ар араасаа мэдээллээ өгсөөр байна.

АЖИЛ ОЛГОГЧДОД ХҮНДРЭЛ УЧРУУЛЖ БУЙ ХУУЛИЙГ ЗАСАЖ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХАА ГБХНХ-ЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ИЛЭРХИЙЛЛЭЭ

Үндэсний баялгийн сан-Орон сууцжуулалтын Үндэсний хорооны анхны хурал удахгүй зохион байгуулахтай холбоотой Гэр бүл, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайд Л.Энх-Амгалантай МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар 2024.11.05-ны өдөр уулзаж орлогод нийцсэн орон сууцны бодлого, бизнес эрхлэгчдэд тулгамдаж байгаа асуудлын талаар санал солилцлоо. Үндэсний баялгийн сан-Орон сууцжуулалтын Үндэсний хорооны гишүүнээр сонгогдсон МБҮА ТББ нь амины орон сууцыг ипотек хамруулах, бага дунд орлоготой иргэдийг орон сууцанд оруулахад ямар бодлого баримтлах талаар саналыг боловсруулахад оролцож ажиллаж



байгаагаа дурдлаа.Мөн МБҮА ТББ-ын зүгээс “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 19.1.2-р заалтад “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс”-ийг даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд оруулж тооцон нийгмийн даатгалын шимтгэл авахаар заасан нь аж ахуйн нэгж байгууллагуудад болон гэрээгээр ажил гүйцэтгэж буй иргэдэд маш их хүндрэл, дарамт болж байгааг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгаллын Сайд Л.Энх-Амгаланд албан хүсэлт илгээсний дагуу уг хуулийн 19.1.2 заалтыг хүчингүй болгох, уул уурхайгаас бусад салбарын гадаадаас ажиллах хүчин авах квот, татварыг тэглэх, Хөдөлмөрийн хуульд байгаа заалтыг засаж сайжруулах талаар ажиллахаа ойрын хугацаанд шийдвэрлэнэ гэдгээ илэрхийллээ.

ШУТИС-ЫН БАС-ТАЙ ХАМТРАН "БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БА ГЕОТЕХНИКИЙН АСУУДЛУУД XVII" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ИВЭЭН ТЭТГЭЛЭЭ



судлаачид, инженерүүдийг дэмжих, барилгын салбарт нэвтрүүлэх шинэ санаа, дэвшилтэт технологийн шийдлийн төслүүдийг илрүүлэх зорилгоор ШУТИС-ын БАС-тай хамтран "БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БА ГЕОТЕХНИКИЙН АСУУДЛУУД XVII" сэдэвт эрдэм шинжилгээний Олон улсын хурлыг 2024.05.28-ны өдөр зохион байгууллаа. Энэ удаагийн Олон улсын хуралд АНУ-ын Калифорины Беркелегийн Их сургуулийн эрдэмтэн Julien Marty, Калифорины Геологийн Албаны эрдэмтэн Daniel Swensen, ОХУ-ын Санкт-Петрбургийн Архитектур Барилгын Инженерийн Их Сургуулийн профессор Р.А.Мангушев, Япон Улсын Тохоку Их сургуулийн дэд профессор Ohho Susumu, Дэд профессор Ryuta Enokida, Ямагата Их сургуулийн профессор Mitsuji Kazuya нар зочин илтгэгчээр оролцож өөрийн улс орны барилгын салбарын геотехникийн нөхцөл байдал, судалгаа, орчин үеийн шинэ дэвшил, туршлагын талаарх мэдээллээ хуваалцлаа. "БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БА ГЕОТЕХНИКИЙН АСУУДЛУУД” эрдэм шинжилгээний хурлыг анх 2007 онд Монгол Улсын Ардын багш, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, ШУА-ийн гишүүн, Академич Д.Дашжамц санаачлан зохион байгуулснаас хойш эдүгээ уламжлал болон зохион байгуулагдаж ирсэн бөгөөд жил бүр хүрээгээ тэлэн залуу инженерүүд, Олон улсын их сургуулиудын эрдэмтдийн судалгааны үр дүн, барилгын салбарын эрдэмтэн судлаачдын бүтээлүүдийг хэлэлцүүлэн туршлага солилцох шинэ мэдлэг түгээн дэлгэрүүлэхэд чухал алхам болж байгаа юм.

ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2009.04.24-ны өдөр үүсгэн байгуулагдан улсын бүртгэлд бүртгүүлж, 2009.04.29-НЫ өдөр АНХДУГААР ЧУУЛГАНАА зохион байгуулж байгууллагын ДҮРМИЙГ баталж, зохион байгуулалтыг хийж Ерөнхийлөгчөөр О.Чулуунбат, УЗГ-ээр Б.Ганзориг, Д.Баттөр, Н.Баярсайхан, Л.Ариунболд нарыг сонгож байжээ. Ийнхүү 15 жилийн өмнө (2009.04.29) МБҮА ТББ нь үүсгэн байгуулагдан, Монгол Улсын томоохон барилга, бүтээн байгуулагчид, хөрөнгө оруулагчид, захиалагчид, үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгчид, барилга угсралтынхан, барилгын материалын үйлдвэрлэгчид болон ханган нийлүүлэгчид, зураг төсөл зохиогчид, архитекторууд зэрэг 160 гаруй барилгын компаниудыг эгнээндээ нэгтгэж, нийгэмдээ болон гишүүддээ үйлчилдэг, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэдэг, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг, салбарын мэргэжлийн, манлайлагч байгууллага болсон байна.


МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009
15 ЖИЛ
ЗӨВ ЗҮГТ МАНЛАЙЛНА
ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД
ЦУВРАЛ№1
ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАН НЬ
2009.04.24-НЫ ӨДӨР МБҮА ТББ НЬ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЖ 04.29-НЫ ӨДӨР АНХДУГААР ЧУУЛГАНАА ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАА ХИЙЖ БАЙВ. 15 ЖИЛИЙН ХУГАЦААНД ТУС БАЙГУУЛЛАГААС МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН 1, АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН 3, ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН 13, ГАВЬЯАТ ТЭЗВЭРЧИН 1 ТӨРСӨН БАЙНА.
МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН 1
МБҮА ТББ-ЫН ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ, ЖИГҮҮР ГРАНД ГРУПП ХХК-ИЙН ТУЗ-ЫН ДАРГА Д.БАТТӨР
АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН 3
МБҮА ТББ-ЫН ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ, МАКС ГРУПП ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Д.ЦЭРЭНЖИГМЭД
МБҮА ТББ-ЫН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, МОНГОЛ БАЗАЛЬТ ХК-ИЙН ТУЗ-ЫН ДАРГА Б.АРИУНБОЛД
МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ЭӨЭС КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗӨВЛӨХ С.МӨНХБАТ
ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН 13
МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЦАСТ ГРУПП ХХК-ИЙН ТУЗ-ИЙН ДАРГА Н.БАЯРСАЙХАН
МБҮА ТББ-ЫН ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАГ ГРУПП ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б.НЭМЭХБАЯТАР
МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ЧМИ ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Х.ЧИНБАТ
МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ТИ ЭНД ЖИ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЦОГТӨӨ
МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ТҮМ АРВИЖИХ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.БОЛД
МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ЭС ДИ ИНЖЕНЕРИНГ ЭНД КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.БАСАНСҮРЭН
МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, БАТС ӨРГӨӨ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ж.БАТСАЙХАН
МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, БАГАНАТ ӨРГӨӨ ХХК-ИЙН ЗАХИРАЛ О.БАТСАЙХАН
МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, ХАР ЧОНОТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.БАЯНЦАГААН
МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, ИХ МОДУН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.ЦОГТСЭРГЭЛЭН
МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, НУТГИЙН БҮЯН ГРУПП ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л.БАТ-ОРШИХ
МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, ХУРД ГРУПП ХХК-ИЙН ИНЖЕНЕР М.ХҮРЭЛБААТАР
МБҮА ТББ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ САЛБАРЫН БОДЛОГО ХАРИУЦСАН ЭВЛӨХ Г.ЛОСОЛ
ГАВЬЯАТ ТЭЗВЭРЧИН 1
МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН, БОЛД ХХК-ИЙН ЗАХИРАЛ Х.БОЛДБААТАР


МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009
15 ЖИЛ
ЗӨВ ЗҮГТ МАНЛАЙЛНА
ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД
ЦУВРАЛ №2
2009 он
ЗТБХБ-ЫН САЙДХ.БАТТУЛГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАВ
ДУУСААГҮЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН СУДАЛГААГ ХИЙВ
САНГИЙН ЯАМТАЙ ЗӨВШИЛЦӨН ШИЙДВЭРҮҮДИЙГ ГАРГУУЛАВ
"БАРИЛГА БА АЖИЛГҮЙДЭЛ ЦУГЛААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА
Ерөнхийлөгч О.Чулуунбат, Тэргүүн Дэд ерөнхийлөгч Д.Баттөр болон гишүүдийн хамт УИХ-ын гишүүн, ЗТБХБ-ын Сайд Х.Баттулгатай уулзаж Ассоциацийн үйл ажиллагаа, Монгол Улсын макро эдийн засгийн орчин, барилгын салбарын хямралт байдлын талаар санал солилцож барилгын салбарт хөрөнгө оруулалт татах, Засгийн газраас санхүүжилтээр дэмжих шийдвэр гаргуулах үйл явцыг тэргэтгэх талаар хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав.
Ассоциаци нь ЗТБХБЯ-тай хамтран баригдаж дуусаагүй орон сууцны барилгуудын судалгаат хийж төрийн албан хаагчдын 4000 орон сууцны хөтөлбөр, ахмад дайчдад олгох 1500 орон сууцны баригдаг Засгийн газраас санхүүжилт өгөх шийдвэр гаргахад төл түлхэц болсон.
-Хямралын үед дуусаагүй байгаа барилгын санхүүжилтэд гадны орноос санхүүгийн эх үүсвэр татах талаар ажиллах
-Ахмадуудад олгох нэг удаагийн бүцалтүй тусламжийг нэг өрөө байраар олгох шийдвэр гаргаж 24 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдсэн.
-Барилгын компаниудын зээлийг Засгийн газар бонд гаргаж худалдан авч санхүүжилтийн эх үүсвэр бий болгох талаар судалсан.
Орон сууцны эрэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрхэн хийхийг судалж байгаа талаар ярилцав.
Салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийнхэн хамтран барилгачдын талбайд БАРИЛГА БА АЖИЛГҮЙДЭЛ цуглааныг зохион байгуулж, барилгын салбарт нүүрлэзд байгаа бодит хямрал, хүндрэлийн талаар нийгэм, төр засгийн газарт дуу хоолойгоо хүргэж Засгийн газарт мэдэгдэл хүргүүлэв.


МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
15 ЖИЛ
Зөв зүгт манлайлна
ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД
ЦУВРАЛ№6 2013 ОН
САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ САЙЖРУУЛАХАД НӨЛӨӨЛӨХ АЛХАМУУДЫГ ЗХЛҮҮЛЭЭ
ТӨРӨӨС БАРИЛГЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГЫГ ИЛ ТОД БОЛГОХОД НӨЛӨӨЛӨН ТОДОРХОЙ АХЛУУДЫГ ХИЙВ
БАРИЛГЫН САЛБАРЫН СУДАЛГААНЫ АХЛУУДЫГ ХИЙЖ ЭХЛЭВ
МОНГОЛ УЛСЫН 21 АЙМГИЙН ТӨВИЙН ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЛТИЙН СУДАЛГАА


МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
15 ЖИЛ
Зөв зүгт манлайлна
ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД
ЦУВРАЛ№3
2010 ОН
IFAWPCA-ТАЙ ХОЛБОО ТОГТООВ
Азийн ба Баруун Номхон Далайн Усанчдын Газрэзүйчдийн Ассоциацийн Олон Улсын Нийгэмлэгийн 41 дэх их хуралд оролцож холбоо хамтлаг тогтоох ахлалийг тавилаа.
(CHINCA)-ТАЙ ХОЛБОО ТОГТООВ
БНХАУ-ын Барилгын Ассоциаци (CHINCA)-тай ажил хэргийн холбоо тогтоож, цаашид хамтран ажиллахаар харилцан тохиролцов.
КАНАД УЛСТАЙ ХАМТРАВ
Монголын Компанууд Канадын толгой хамтрасан компани байгуулах замаар тасал санаачлан Канадын хөгжлийн ага этгагаас хөнгөлөлттэй зээл авах бүрэн боломжтой гэж мэдэгдсэн юм.
СИНГАПУР, ТАЙВАНЫ БАРИЛГЫН ГЭРЭЭЛЭГЧИДТЭЙ ХОЛБОО ТОГТООВ
Сингапур, Тайваны Барилгын Гэрээлэгчдийн Холбооны төрөлжсөн гишүүдтэй уулзаж санал бодлоо солилцов.


МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
15 ЖИЛ
Зөв зүгт манлайлна
ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД
ЦУВРАЛ№4 2011 ОН
АЗИ НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ОРОН СУУЦ САНХҮҮЖИЛТЫН ОЛОН УЛСЫН ХУРАЛ БОЛОВ
ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛДОД 100,000 АЙМАН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР САНАЛА СОЛИЛЦОВ
ШИНЭ БҮТЭЭГДЭЙГҮҮЛАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ХУУЛЬД ШИНЭЧЛЭЛТ ХИЙЖ ЭХЛЭВ
ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД МБҮА ТББ ОРОЛЦОВ
www.mnca.mn
info@mnca.mn
+(976) 7011 1515


МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
15 ЖИЛ
Зөв зүгт манлайлна
ТҮҮХИЙГ БҮТЭЭГЧИД
ЦУВРАЛ№10 2017 ОН
01 БХБ-ын Сайд Х.Баделхан төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын албанд айлчлав.
02 "Монгол Улс, БНХАУ-ын Барилга, хот байгуулалтын хөрөнгө оруулалт-2017" Чуулга-уулзалтыг БНХАУ-ын Бээжин хотноо амжилттай зохион байгуулав.
03 Барилгын салбарын мэргэжлийн төрийн бус байгуулагууд нэгдэн салбарт өрнөж буй үйл явдал, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх асуудлаар өөрсдийн байр суурийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр илэрхийлэв.
04 НЗДТГ-тай байгуулсан "Санамж бичиг"-ийн хүрээнд Улаанбаатар хотод ашиглалтад бүрэн орсон борлуулагдаагүй байгаа 1-2 өрөө орон сууцны дундаж үнийн болон тоо хэмжээний судалгааг 2017 онд боловсруулан НЗДТГ-т хүргүүлэв.
ЧУУЛГА УУЛЗАЛТ

MNCA
SINCE 2009
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
15 anniversary

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.1:

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖИЛ



+(976) 7011-1515

www.mnca.mn

МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРСАЙХАН ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН ЦОЛ ХҮРТЛЭЭ



Цаст констракшн ХХК-ын ТУЗ-ын дарга, МБҮА ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэг, Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь “МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН” цол тэмдгээр шагнууллаа.

Тэрээр 2008 онд барилгын салбарт бизнес эрхлэгч, тэргүүлэх зэргийн барилгын компанийн захирлуудтай хамтран салбарын бодлого боловсруулах, бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, дэлхийн улс орнуудын барилгын шинэ техник, технологи, стандартыг нэвтрүүлэх, нийслэлийн бүтээн байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтөд тулгамдаж буй хүндрэлийг шийдвэрлэх зэрэг асуудлаар төр засгийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, нэгдсэн санал санаачилга боловсруулах чиглэлээр Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ыг санаачлан, 2009 онд албан ёсоор бүртгүүлэн, үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ.

МБҮА ТББ үүсэн байгуулагдсан цагаас өнөөдрийг хүртэл Удирдах зөвлөлийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгчөөр сонгогдон 15 жилийн турш тууштай ажиллаж байна.

Н.Баярсайхан нь өөрийн аавын үүсгэн байгуулсан “Цаст импекс” ХХК-ийг 1998 оноос удирдан, бизнесийн салбарт хөл тавьсан бөгөөд өнгөрсөн 26 жилийн хугацаанд 7 жил дараалан “Топ 100 аж ахуйн нэгж”-ээр шалгаран ажиллаж байгаагаас гадна 2008, 2012 оны Олимпийн наадмын SILVER ивээн тэтгэгчээр ажиллаж байсан билээ. Улмаар тэрээр барилга угсралт, барилгын зураг төслийн чиглэлээр Цаст констракшн ХХК-ийг 2003 онд байгуулж Монгол Улсын анхдагч өндөр орон сууцны барилга, ОУ-ын оффис үйлчилгээний барилга International Commercial Center буюу ICC Tower нь Улаанбаатар хотын өнгө үзэмжийг нэмэн, үнэ цэн нь тогтвортой өсөн нэмэгдэж буй үйл хөдлөх болсон байна. Мөн Монгол улсад анхны таун хаус төсөл “Dream Land” хотхон, орон сууцны “Шинэ өглөө” төслүүдийг амжилттай хэрэгжүүлж уулын хотхон “Энх өглөө” болон хүүхдэд ээлтэй гэр бүлийн амралтын төслүүд дээр ажиллаж байна.

Харин нийгмийн хариуцлагын хүрээнд ЭМЯ-ны өргөтгөлийн барилга, Клиникийн 1-р амаржих газрын 6 давхар, 1 ээлждээ 150 эх хэвтэх боломжтой барилга, Гэмтэл Согог Үндэсний Төвийн харьяа Түлэнхийн төвийн барилгын ажил, Үндэсний оношилгоо, үйлчилгээний төв, Ерөнхий боловсролын сургуулиуд, хүүхдийн цэцэрлэгийн барилгуудын төслүүдийн Ерөнхий гүйцэтгэгчээр, авто зам, Хөшгийн хөндийн ОУ-ын нисэх буудлын төсөлд Самсунг корпорацын туслан гүйцэтгэгчээр шалгаран 17 байгууламжийн гадна фасад, дээвэр, дотор заслын ажлуудыг гардан гүйцэтгэж байсан туршлагатай билээ.

Н.Баярсайхан нь барилгын салбарт амжилттай ажиллахаас гадна үл хөдлөх хөрөнгийн менежментийн салбарыг хөгжүүлэх ажилд хувь нэмрээ оруулж байгаа ба “Цаст проперти” ХХК нь чанарын нэгдсэн удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 хэрэгжүүлэгч анхны компани болж ОУ-ын аудитын байгууллагаар баталгаажин ОХУ, БНХАУ, Хонг конг, ХБНГУ, БНСУ, Итали, АНУ-ын бизнес эрхлэгч түншүүдтэй холбоо тогтоон ажиллаж байна.


ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛЬ ХҮРТСЭН ГИШҮҮДЭД ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЭВ











Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Жигүүр гранд групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Халиун, Эрчим инженеринг ХХК-ийн захирал М.Батболд, “Алтан гадас” одонгоор шагнуулсан Хяналтын зөвлөлийн гишүүн, СЭЗИС-ийн багш Ж.Дэлгэрсайхан, МБҮА ТББ-ын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл хариуцсан менежер Б.Төвшинболор, Удирдах зөвлөлийн гишүүн, Алтан Жолоо Констракшн ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Болд, нартаа халуун баярыг хүргэж, эрүүл энх, аз жаргалыг хүсэхийн зэрэгцээ, хойч үедээ үлгэр дуурайлал нь байж, амжилт бүтээлийн оргил өөд улам тэмүүлэхийг хүсэн ерөөе.



МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР Г.БАТСҮХ ТОМИЛОГДЛОО

МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирлаар МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Barilga.mn сайт, Барилга.МН сэтгүүлийн үүсгэн байгуулагч Г.Батсүхийг томилон ажиллуулахаар боллоо.

МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь Нийслэлийн 22-р дунд сургууль, 47-р дунд сургууль, 1999 онд МУИС-ийг Эдийн засагч, мэдээлэл зүйч, 2011 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын мэргэжлээр тус тус төгссөн.

2007 онд Монголын барилгын нэгдсэн портал Barilga.mn сайт, 2010 онд Барилга.МН сэтгүүлийг үүсгэн байгуулсан. 2012-2014 онд БХБ-ын сайдын зөвлөлийн гишүүнээр, 2017 онд БХБ-ын сайдын орон тооны бус зөвлөхөөр, БХБЯамны дэргэдэх Ногоон барилгын зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байсан ба Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг зохицуулалттай болгох судалгаа болон хуулийн төсөл боловсруулах,

барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэгт ажилласан.
Тэрээр Барилгын норм дүрэм, стандартын үзлэг болон Барилгын материалын тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож, Барилгын материал үйлдвэрлэл, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн ажлын хэсгийн даргаар ажиллаж БХБЯамны захиалгаар хийгдсэн тусгай зөвшөөрлийн цахим программыг шинэчлэн сайжруулах ажилд оролцож ажилласан.
Өнгөрсөн хугацаанд барилгын салбартаа “Barilga expo”, “Барилга орон сууц” зэрэг үзэсгэлэн яармагууд, Барилгын ханган нийлүүлэгчдийн чуулган, Барилгын хөрөнгө оруулагчдын уулзалт, Барилгын маркетинг, Барилгын чанар аюулгүй байдал зэрэг олон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан бөгөөд салбарын мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж, тулгамдсан асуудлыг шийвэрлэхэд дуу хоолойгоо хүргэж ирсэн.

ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРТОЙ МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ УУЛЗЛАА



МБҮА ТББ-ын захирал Г.Батсүх нь Нийслэлийн Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэртэй уулзаж хот төлөвлөлт, зөвшөөрөл, стандартын талаар ярилцаж санал солилцлоо. Уг уулзалтаар Хот байгуулалт, стандартын газрын холбогдох дарга, албан тушаалтнуудын хамтаар барилгын компаниудтай хамтарсан уулзалт зохион байгуулж салбарт тулгамдаад байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх, гарц гаргалгаа болоод стандартыг хэрхэн мөрдүүлэх талаарх асуудлуудыг ярилцаж шийдвэрлэх нь чухал гэдэг дээр санал нэгдлээ.

Уг асуудлуудын хүрээнд энэ сардаа багтаж барилгын компаниудтай хамтран уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахаар тогтлоо.

МҮХАҮТ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛЛОО



Энэ сарын 30-ны өдөр МҮХАҮТ-ын Тэргүүлэгч гишүүдийн хурал болж хурлаар МҮХАҮТ-ын үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх тухай, Оны энтрепренёр шилдэг онцлох аж ахуйн нэгжийг шалгаруулах, зохион байгуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах, МҮХАҮТ-ын ээлжит бус их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулах, ээлжит бус их хурлын төсвийг батлуулах, дэгийг хэлэлцэх, комиссын бүрэлдэхүүнийг батлуулах талаар хэлэлцлээ. МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь МҮХАҮТ-ын тэргүүлэгч гишүүний хувьд байр суурия илэрхийлж оролцлоо.

МБҮА ТББ-ын ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРСАЙХАН: ГЭР ХОРООЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ГАЗРУУДАД “А” ДААЛГАВАР ӨГӨХӨӨ ЗОГСООЖ ХУУЛЬЧЛАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА

“Монголын орон сууцны ирээдүй 2024” олон улсын форумыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Дэлхийн банк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран энэ сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх өнөөгийн бодит боломж, санхүүжилтын бодлого, орлогод нийцсэн орон сууц, олон улсын туршлагыг нэвтрүүлэх арга зам юу байгааг хөндөж талууд байр суурия илэрхийллээ.
-Барилгын үнэ өндөр байгаа шалтгааныг тайлбарлаж өгнө үү.
Өнөөдрийн энэ хуралд бүх талуудын оролцоог хангаж, байр суурия илэрхийлэх боломжоор хангаж байгаад юуны өмнө талархал илэрхийлье. Байр орон сууцны үнэ нэмэгдэж байгаа асуудал нь биднээс хамаарах хамаарахгүй олон хүчин зүйлээс болж байна. Үнэд хамгийн их нөлөөлж



байгаа зүйл бол нэгдүгээрт газар, хоёрт ний нуугүй хэлэхэд авлигын үнэ байгаа. Хэвлэл мэдээллийнхэн их ирсэн байна. Хувийн хэвшлийн төлөөллүүд маань хэлж магадгүй байх гэж бодож байна. Өнөөдөр барилга эрхлэх зөвшөөрөл авах, А даалгавар авахад бүтэн 5 сар болж байгаа. Энэ тогтолцоогоос манай барилгын яам реформ хийж эхлэх болов уу гэж бодож байна. Үүнийг бүгд мэддэг. Томхон компаниуд үүнийг үл тоож зөвлөх үйлчилгээний зардалдаа оруулж явдаг. Дунд зэргийн компаниуд үүнийг нэлээн зовж байж авдаг. Гэхдээ үүнийгээ олон компани хэлдэггүй. Тухайлбал галын зөвшөөрөл авах гэж хоёр сар болж байна, жишээг цааш нь хэлж болно. Наадам боллоо, 100 жил боллоо, өнөө галын газар өгөхгүй. Нөгөө зөвшөөрөл өгөх болоход хоёр нь зэрэгцээд амраад алга болдог. Том асуудлуудаа цэгцлэхийн тулд суурь асуудлуудаа бэлдэх хэрэгтэй байна. Цаашаа явахын тулд хувийн хэвшлүүдээ түлхүү оруулж хамтарсан төсөл хэлбэрээр төсөлжүүлэх маягаар явах хэрэгтэй болов уу. Үүнийг дагаад авлига хээл хахууль манай барилгын салбарт байгаа.

Гэр хорооллын дахин төлөвлөлтөд барилгын компаниуд ямар суурьтай оролцох сонирхолтой байгаа вэ?

-Зах зээл дээр компаниуд том жижиг дунд гэвэл олон төрлийн байгаа. Мэдээж энэ төслүүдэд бүх л компаниуд оролцохыг сонирхож байгаа. Юуны түрүүнд гэр хорооллолд байгаа иргэдэд бүсчилсэн ерөнхий төлөвлөлтийг тодорхой болгох хэрэгтэй байна. Мэргэжлийн судалгаа хийгээд хаана хаана, орлогод нийцсэн орон сууцаа барих хэрэгтэй байна. Тийм бишээс болоод газрын наймаа, ухаандаа 2 буудлын зайд газар аваад барилгын компанид зардаг, тэгэхээр үнэ өсөх нь тодорхой. Хэрэв бүсчлэлээ тодорхой болгочих юм бол аль барилгын компани хаана орох нь тодорхой болно. Бас нэг юм нэмээд хэлэхэд гэр хорооллын газрууд гараад байхад, тэр газар дээр яагаад А даалгавар өгөөд байна аа. Үүнийг хуульчилж зогсоохгүй бол нөгөө төлөвлөлт хийгээд томоор хийх гэж байгаа газруудын үнэ цэнийг бууруулаад байна. Нөгөө үнэтэй авсан газраа компаниуд хүн амьдрах орчингүй, газраа дүүртэл нь төлөвлөж байна. Тиймээс үүнийг яаралтай хуульчлах хэрэгтэй. Мөн гэр хорооллолд эрчим хүчний хэмнэлттэй амины нам давхрын орон сууцууд хашаанд нь барих хөтөлбөр хэрэгжүүлэхэд нэг анхаарах зүйл бий. Улсаас дэд бүтцийн нь тавиад эхлэнгүүт тэр хэсгийн газрын үнэ шууд өсдөг. Энэ тохиолдолд айлууд бас л барилгын компаниудад газраа өндөр хүргэж зарах сонирхол бий болно. Энд бас дээрх гажуудал давтагдана. Олон улсын туршлага, тухайлбал Холбооны Бүгд Найрамдах Герман улсад давхрын тоог заахаас гадна байшингийн өндрийн хэмжээг заадаг, тэдэн метр өндрөөс дээш хэтрүүлж болохгүй гээд. Зарим нэг хотод дээврийн налуугийн градусыг хүртэл заадаг. Энэ мэтчилэн стандартуудыг хатуу хуульчлахгүй бол айлууд газраа зараад нөгөө сайхан төлөвлөлтүүд нь үгүй болж бие биеэ хаасан өндөр барилгууд баригдана. Жишээлбэл Гандан, Зайсан, Нэхмэлийн шарууд,100 айл, Яармаг ,Натур төвийн ойролцоох газруудад барилгажсан алдааг давтахгүй байя.

ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО ОЛОН УЛСЫН ФОРУМД БАРИЛГЫН САЛБАРЫНХАН БАЙР СУУРИА ИЛЭРХИЙЛЛЭЭ

“Монголын орон сууцны ирээдүй 2024” олон улсын форумыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Дэлхийн банк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран зохион байгуулсан тус хэлэлцүүлэгт орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх өнөөгийн бодит боломж, санхүүжилтын бодлого, орлогод нийцсэн орон сууц, олон улсын туршлагыг нэвтрүүлэх арга зам юу байгааг хөндөж байлаа.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь:

“Ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2025 онд 1.2 их наяд төгрөгт хүргэх бөгөөд жил бүр тус эх үүсвэрийг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2028 он гэхэд 60 мянган айл өрхийг ипотекийн зээлд хамруулна. Мөн ипотекийн зээлийн 50-иас дээш хувийг орон нутагт олгохоор төлөвлөж байна. Ирэх 4 жилд 150 мянган айлын орон сууцыг

ашиглалтад оруулна. “Монголын Ногоон Санхүүгийн Корпораци”-тай хамтран олон улсын санхүүгийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалт босгож, амины орон сууцаа дулааны алдагдалгүй болгосон иргэдэд хөнгөлөлттэй зээлийг олгох, дэд бүтцээ бүрэн шийдвэрлэсэн өрхөд төрөөс 30 хүртэлх сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэдгийг тодотголоо.
Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө иргэдийг орон сууцжуулах тодорхой зорилтуудыг тусгасан бөгөөд

- Үндэсний баялагын сангаар дамжуулан орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх
- Ипотекийн зээлийг өрхийн орлогын түвшинтэй уялдуулах
- Үндэсний орон сууцны корпораци байгуулж, орон сууцжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, амины орон сууцыг нэмэгдүүлэхэд хөнгөлөлттэй зээл, урамшууллын механизмыг нэвтрүүлэх
- Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор “Шинэ зуунмод”, “Шинэ Хархорум” зэрэг хотуудыг шинээр байгуулах
- Аймаг, сум, орон нутагт орон сууцжуулалтын үйл ажиллагааг бодлогоор дэмжих зэрэг болно.

Улсын Их Хурлын намрын чуулганаар Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл зэрэг Барилгын салбарын багц хуулийн төслүүдийг боловсруулан, өргөн барьж, батлуулахаар ажиллаж байгааг бодлого боловсруулагчид хэлж байна. Хэлэлцүүлэгт Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Дэлхийн банкны орон сууцжуулалтын ахлах мэргэжилтэн Дао Харрисон, Дэлхийн банкны санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн Оливье Видал, Дэлхийн банкны хот төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Палави Сенгупта, Египетийн түрээсийн орон сууц, Ипотекийн санхүүжилтийн сангийн Ерөнхийлөгч Мэй Абдель Хамид Ахмед, Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын яамны Орон сууцжуулалтын хэлтсийн дарга Э.Батболд болон Монголын Ногоон Барилгын Хүрээлэн ТББ-ын Гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл нар илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүллээ.

ФИДИК-ИЙН ГЭРЭЭНИЙ СУУРЬ ОЙЛГОЛТЫН ТАЛААР САЛБАРЫНХАНД ТАНИУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА



Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК) нь МБҮА ТББ-ыг “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”-ээр элсүүлэх шийдвэрийг өөрийн Удирдах зөвлөлийн хурлаараа дэмжиж, улмаар 2023.09.10-ны өдрийн Сингапур Улсад болсон ФИДИК-ийн Ерөнхий Ассамблейн Хурлаар (GAM) оруулан соёрхон баталлаа. ФИДИК нь Швейцарын Женев хотноо 1913.07.22-ны өдөр үүсэн байгуулагдаж, эдүгээ дэлхийд 100 гаруй гишүүн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, олон улсад Барилга, бүтээн байгуулалтын жишиг гэрээ (Suite of Contracts), Сургалт, судалгаа (ФИДИК-ийн Академи, Гэрчилгээжүүлэлт), Маргаан шийдвэрлэлт, Эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. **Дэлгэрэнгүйг дараах линкээс уншина уу.** МБҮА ТББ-ын УЗГ Баасансүрэнгийн ярицлага-final.pdf

НАМУУДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ БАРИЛГЫН САЛБАРТ ХИЙХ ШИНЭЧЛЭЛ, САНАЛУУДАА ТУСГУУЛЛАА







Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо ТББ, Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын Холбоо ТББ, Хөгжлийн Төлөө Барилгачдын Нэгдэл ТББ зэрэг нь хамтран МАН, АН, ХҮН намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт барилгын салбарт тулгамдаж буй асуудлуудыг тусгуулахаар саналаа боловсруулан хүргүүлэв. Барилгын компаниуд нь салбарын хөгжлийн асуудлууд болон хот төлөвлөлт рүү илүү анхаарч Хот суурин газрууд болон дагуул хотуудын бүтээн байгуулалт, Дэд бүтцийн бүтээн байгуулалт, Гэр хорооллын дахин төлөвлөлт, зохион байгуулалтын хүрээнд төр, засаг, орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага үүсэж байна. Тиймээс барилгын салбарыг цаашид хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зарчмын саналуудыг нэгтгэн намуудын ирэх сонгуульд дэвшүүлэх мөрийн хөтөлбөрт нь оруулж болохуйц 3 зорилт бүхий 44 зүйл заалттай саналыг боловсруулсныг МАН, АН, ХҮН намын удирдлагуудад хүргүүлэв. Монголын эдийн засгийн томоохон төлөөлөл болсон энэ салбарт өнөөдөр барилгын үйл ажиллагаагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Барилга угсралтын 4,230, Зураг төслийн 818, барилгын материалын үйлдвэрлэлийн 292 ААНБ-ууд тус тус үйл ажиллагаагаа эрхэлж, тэдгээрт 150,000 гаруй иргэн ажиллаж байна. Сүүлийн 20 жилд Улаанбаатар хот нь хэт төвлөрсөн, хот төлөвлөлт эмх замбараагүй болсон, барилгын чанар муудсан, мэргэжлийн ажиллах хүчин хомсдсон зэргээс улбаалж салбарын хөгжил саарч, тулгарч буй олон асуудлууд үүсэж байгаа учраас цаашид энэ салбарт:

- Шинэ техник, технологийг нэвтрүүлэх,
- Өнөөдөр даган мөрдөгдөж буй дүрэм журмыг шинэчлэх, илүү боловсронгуй болгох, ингэхдээ төрийн олон чиг үүргийн заримыг мэргэжлийн холбоодод өгч хэрэгжүүлэх,



Үнэ тарифыг чөлөөлөх зэргээр төртэй хамтарч ажиллан салбарт тулгамдаад буй асуудлыг дорвитой шийдвэрлэх шаардлагатай байгаа талаарх асуудлыг ярилцаж мөрийн хөтөлбөрт нь тусгаж цаашид хэрэгжүүлэн ажиллах талаар саналаа солилцлоо.

БНСУ-ЫН ФИДИК-ИЙН ГЭРЭЭ, БАРИЛГЫН МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ СУРГАЛТАД ОРОЛЦЛОО

МБҮА ТББ нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-ны “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”-ээр батламжлагдсанаас хойш Монгол Улсын барилга, хот байгуулалтын салбарт ФИДИК-ийн гэрээг хэрэгжүүлэх үйл явцыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган чадавхжуулах зэрэг ажлыг зохион байгуулж, салбарын үйл ажиллагаанд оролцогч хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч нарын хоорондын харилцааг зохицуулах, эрх тэгш байдлыг хангах, хамгаалан ажиллах үүргийг хүлээх, улмаар Монгол Улсад ФИДИК-ийн гэрээг түгээх, Гишүүн холбоодын нийтлэг мэргэжлийн эрх ашгийг хөгжүүлэх, салбарт Олон улсын гэрээ, эрх зүйн орчныг стандартын дагуу хэрэгжүүлэх шинэ дэвшил, эргэлтийг авчрах хүрээнд ажиллаж байгаа билээ. Уг ажлын хүрээнд МБҮА ТББ-ын УЗГ, Монгол Улсын Зөвлөх инженер, Гавьяат барилгачин, Эрх зүйч Б.Баасансүрэн нь БНСУ-ын ФИДИК-ийн гэрээ, барилгын

маргаан шийдвэрлэлтийн талаар мэргэшсэн, албан ёсны эрхтэй сургагч багш Ph.D.Hyun Hakbong-тай уулзаж, Ассоциацийн Гишүүн байгууллагуудыг сургалтад хамруулах, хамтран ажиллах тухай ярилцаж, санал бодлоо солилцов. БНСУ-д ФИДИК-ийн гэрээ, барилгын маргаан шийдвэрлэлтийн талаар мэргэшсэн, албан ёсны эрхтэй сургагч багш Ph.D.Hyun Hakbong нь сүүлийн 10 гаруй жил Азийн улс орнуудад ФИДИК-ийн гэрээний талаар сурталчлан түгээж дэлгэрүүлэх ажлыг хийж буй хүн болно. Тэрээр ФИДИК-ийн “Улаан ном”-ыг Солонгос хэлнээ хөрвүүлэх ажлыг гардан хийж, номуудыг эх хэл рүү нь хөрвүүлэх бол заавал Англи хэлтэй нь дагуулж орчуулах хэрэгтэйг, энэ нь хожмын үл ойлголцол, маргаан дагуулахгүй байх давуу талтайг онцлов. Мөн ФИДИК-ийн гэрээний ахисан түвшний сургалтад гэрээг эх хэл дээр заах, ойлгуулах нь чухал гэдгийг зөвлөсөн байна.

“БАРИЛГЫН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024”-Д МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД ОРОЛЦЛОО



Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 98 жилийн ойн хүрээнд “БАРИЛГЫН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024” арга хэмжээг “Аюулгүй барилга, аюулгүй орчин, аюулгүй ажиллагаа“ уриа дор 2024.04.05-ны өдөр Орхон аймгийн Уурхайчин соёлын ордонд зохион байгууллаа. Уг зөвлөгөөнөөр барилгын салбарт төрөөс баримталж буй бодлого, бүсчилсэн хөгжил, төсвийн хөрөнгө оруулалт, аюулгүй барилга, аюулгүй орчин, аюулгүй ажиллагааны олон улсын туршлага, салбарын хууль эрхзүйн баримт бичгийн шинэчлэлт, бүтээн байгуулалтын чанар, аюулгүй байдлыг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх юм байна. Энэ удаагийн зөвлөгөөнд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, УЗГ, Эс Ди Инженеринг Энд Констракшн ХХК-ийн Захирал Б.Баасансүрэн, Гишүүн Легал Линк Эм Эн ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Уянга, нар оролцлоо.

ДОТООД ОРЧНЫ БОХИРДОЛ БА БОХИРДУУЛАГЧААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД САЛБАР ХООРОНДЫН УЯЛДААГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ ПАНЕЛИСТААР ОРОЛЦЛОО



Дотоод орчны бохирдол ба бохирдуулагчаас урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдааг сайжруулах тухай хэлэлцүүлэг Төрийн ордонд болж Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны сайд Ж.Батсуурь, УИХ-ын гишүүн А.Ундраа, УИХ-ын дэргэдэх Ногоон хүртээмжтэй орон сууцны тогтолцоо, санхүүжүүлтийг бүрдүүлэх “Ажлын хэсэг”-ийн ахлагч, УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц, барилгын салбарын ТББ-ын төлөөлөл болж панелистаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болон бусад оролцогчид оролцож барилгын дотоод орчны бохирдол, тулгамдаж байгаа асуудал шийдлийн талаар санал бодлоо солилцлоо.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад Үндсэн хууль, Барилгын тухай хууль, 422 барилгын норм, дүрэм, 498 стандарт, барилгын материалын техникийн зохицуулалт гээд дотоод орчны бохирдол ба бохирдуулагчаас урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчин хангалттай байгаа ч хэрэгжилт хангалтгүй байна. Мөн хууль, норм дүрэм зөрчсөн этгээдэд Барилгын тухай, Зөрчлийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудын холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдаг ч хариуцлагын тогтолцоо байхгүй байгаа нь хууль дүрэм хэрэгжихгүй байгаагийн гол нөхцөл болоод байна гэдгийг хэлэлцүүлгийн үеэр онцолж байсан юм. Өндөр хөгжилтэй

дэлхийн улс орнууд гаднаас оруулж ирж буй импортын барилгын материалуудад тохирлын гэрчилгээ, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэхийг шаардаж, хэрэгжүүлдэг бөгөөд стандарт бус хулхи, хуурамч барилгын материал борлуулбал эрүүгийн хариуцлага хүлээх хариуцлагын тогтолцоотой байдаг нь барилга байшингийн чанар болоод хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж байдгийн тодхон жишээ юм.

Өнөөдрийн хэлэлцүүлгийн гол агуулга нь дотоод орчны бохирдол ба түүнээс урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдааг сайжруулах тухай асуудал бөгөөд дотоод агаарын чанарын суурь нөхцөл болох гаргасан хууль тогтоомж, дүрэм журмыг төр дангаараа хэрэгжүүлэхэд хүчин дутмаг байгаа учир төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн бус байгуулага, хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох шаардлага зүй ёсоор урган гарч ирж буйг тодорхой жишээ баримтуудаар асуудал дэвшүүлэн ярилцлаа.

Тухайлбал зөвшөөрөл авч зураг төсөлтэй баригдаж байгаа орон сууц, сургууль цэцэрлэгийн барилга нь гүйцэтгэлийн чанар, материалын чанар, агаар сэлгэлт зэрэг мэргэжлийн үйл ажиллагаатай явагдаж байгаа ч хэрэглэж байгаа барилгын материалын чанар хангалтгүй байх нь түгээмэл байдаг. Гэтэл зөвшөөрөлгүй баригдаж байгаа гэр хорооллын барилга, нийтийн байр, амины орон сууцнууд нь зураг төсөлгүй баригдсан учир эрчим хүчний алдагдалтай, газар хөдлөлт байгалийн гамшигт тэсвэргүй, дотоод орчны агаарын бохирдолтой байгаа ба формальдегид, бензол зэрэг хорт бодис ялгаруулдаг барилгын материал хэрэглэж барьж байгаагаас иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгааг тодорхой тоо баримтад тулгуурлан танилцуулж байсан юм.

Тус хэлэлцүүлгээр:

- Барилгын тухай хуулийн дагуу тохирлын гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан барилгын материалыг импортоор оруулж ирдэг болгох
- Ямар ч зөвшөөрөл, хяналтгүй баригдаж байгаа бага төвөгшилтэй барилга, нийтийн байр, амины орон сууцыг зохих бүртгэлтэй болгож, Барилгын тухай хуулийн дагуу зураг төсөлтэй баригдах эрх зүйн орчныг бүрдүүлэх (гэр хороолол, орон нутагт баригдсан амины орон сууцнууд Барилгын тухай хуулийг давсан журмаар бага төвөгшилтэй ангилалд багтаж байгаа учир 99,9 % зураг төсөлгүй баригдсан нь хууль, норм дүрэм зөрчсөн барилга байгууламж болж ногоон зээл, ипотекийн зээлийн шаардлага хангах боломжгүй болсон.)
- Барилгын материалын шинжилгээний лаборторийн хүчин чадал, чадавхыг сайжруулах
- Төрийн бус байгууллагууд тус асуудалд идэвхтэй оролцохыг уриалж зөвлөмж гаргасан ба нэн даруй барилгын материал импортлохдоо олон улсын эсвэл үндэсний чанар, стандартын шаардлага хангасан барилгын материалыг урьдчилан бүртгүүлэн улсын хилээр импортлон оруулж ирдэг тогтолцоог бий болгох шаардлагатай байгааг онцоллоо. Ингэснээр иргэд ямар барилгын материал нь тохирлын гэрчилгээтэй, эрүүл мэндэд хор хөнөөлгүй гэдгийг судлах боломжтой болох бөгөөд шаардлага хангасан барилгын материалыг аль ч дэлгүүр, лангуунаас эргэлзэхгүйгээр авдаг болгох нь чухал байна. Уулзалт хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц олон зөв зүйтэй саналуудыг гаргаж улмаар уг асуудлын хүрээнд МБҮА ТББ-тай нягт хамтран ажиллахаа илэрхийллээ.

МНХ-НЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААН 5 УДАА БОЛЛОО



Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль нь 2025.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурлаас 2024.09.12-ны өдөр “Ажлын хэсэг”-ийг Дэд ерөнхийлөгч, НБИК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Баяраа, Дэд ерөнхийлөгч, Номин констракшн девелопмент групп -ийн гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү, УЗГ, Эс Ди Инженеринг Энд Констракшн ХХК-ийн захирал Б.Баасансүрэн, Н ЭЙ БИ ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Б.Амарсанаа нарын

бүрэлдэхүүнтэй байгуулсан ба 2024.12-р сарын байдлаар 7 удаа хуралдаад байна.

ТҮНШЛЭГЧДИЙН ХУРАЛ 2024 ОНД 3 УДАА БОЛОВ



Салбарын мэргэжлийн ТББ-ууд болох МБЗТЗХ ТББ, МБГБХ ТББ, МБИХ ТББ, ӨТМТҮХ ТББ, БТХ ТББ, МБИГХ ТББ зэрэг түншлэгч байгууллагуудтай хамтран Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж буй бөгөөд 2024 онд Түншлэгч байгууллагуудын удирдлагуудын хурлыг 3 удаа зохион байгуулж холбогдох асуудлыг шийдвэрлэв.

Н.БАЯРСАЙХАН: **Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хурдыг ажиллах хүчний нийлүүлэлт хангаж дийлэхгүй боллоо**



-Сошиал, жагсаал хоёроос болж төр засаг нь шийдвэрээсээ буцаад байвал бид хөгжил дэвшил ярихад хэцүү-

Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхантай Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой үүсээд байгаа нөхцөл, өрнөж буй асуудлаар ярилцлаа.

-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Монголын Барилгын Үндэсний ассоциац ТББ дэмжиж байгаа харагдаж байна. Гэтэл бас эсэргүүцэгчид ч байна. Үүнийг та юу гэж харж байна?

-Гадаадаас ажиллах хүч авах эрх зүйн тухай хуулийн төсөл нэг талаас Хамтарсан Засгийн газар мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээндээ, нөгөө талаас Танхим болон МБҮА тэргүүтэй ТББ-уудын санал санаачилгаар өргөн баригдлаа. Хатуухан хэлэхэд ажил хөдөлмөр, бизнесийн зовлон бэрхшээлээс хол хөндий, сошиал, шантаажаар амьдардаг зарим популист улстөрчид үүнийг улстөржүүлэх шинжтэй харагдаж байна. Мэргэжилтэй ажиллах хүчний хомсдолд барилга, дэд бүтцийн болон бусад олон салбар орж, түүнээс үүдсэн хүндрэлүүдийг даван туулж яваа. Галт тэргээр зүйрлэвэл зүтгүүрийг маань ажиллуулах машинист, ажилчидгүй таг зогслоо. Утаа, тоос, түгжрэл, орон байрны үнийн өсөлт, энэ олон хүндрэлээс бид барилга орон сууц, дэд бүтцийн тэлэлт, түүнийг дагасан шинэ суурьшил гээд олон арван бүтээн байгуулалтын төслүүдийг урагшлуулж байж бид сална. Бүтээн байгуулалтын нөр их ажлыг ганц хүн цалинжуулж, ганц тоосго өрөөгүй поп улстөрчид, уран бүтээлч нэртэй шантаажчин, мэргэжлийн онцлогоо мөнгөөр үнэлсэн зарим сэтгүүлч ирж хийх үү. Орон сууцны өртөгт нөлөөлж байгаа хамгийн том нөлөөлөл болсон энэ суурь хүчин зүйлүүдийн нэг ажиллах хүчний хомсдолыг шийдэж, төсөл хөтөлбөрүүдээ хөдөлгөлгүйгээр бид эдийн засгаа өсгөж, солонгоруулж, хүн амыг орон сууцжуулах хөтөлбөрөө хэрэгжүүлж, ядуурал, хүндрэлээс гарч чадах уу. Гадаадад гарсан мэргэжилтэй ажиллах хүчнээ эргэн ирэхүйц хэмжээнд цалин хөлс өгдөг нөхцөлийг бүрдүүлсэн улс орон болж чадах уу. Энэ хүндрэлүүдийг манай улсаас хэдэн арав дахин их хүн амтай хөгжингүй болон хөгжиж

буй бүх орнууд гаднаас ажиллах хүч оруулах замаар шийдэж, бүтээн байгуулалтаа хийж, улс орноо хөл дээр нь босгож, тулгамдсан асуудлуудаа шийдвэрлээд явж байна. Тиймээс бид энэ үед Засгийн газраас санаачлан өргөн барьж байгаа уг хуулийн төслийг нэгдмэл дуу хоолойгоор дэмжих нь улс орны эдийн засгийн эргэлтийн тогтвортой байдлыг хангах энэ цаг үеийн зангилаа болсон шийдэл гэж үзэж байна.

-Барилга гэлтгүй бүх салбарт ажиллах хүч дутагдалтай байгаа гэж та хэллээ. Гэтэл нөгөө эсэргүүцэгчид маань "Хятадаас баахан ажилтан ороод ирнэ" гэсэн юм яриад байгаа...

-Бизнесийнхэн хаанаас ямар ажиллах хүч авахаа маш сайн шийдэж чадна. Гадаадаас ажиллах хүч авна гэхээр зөвхөн БНХАУ-аас ажилтан авах тухай ойлголт биш. Тийм зорилго байхгүй. Үндэсний аюулгүй байдлын асуудал хөндөгдөх талаар ярьж байгаа бол тоо хэмжээгээ заагаад, хяналтаа тавиад явахад асуудал байхгүй. Хятад ажилчид орж ирээд Монголын зах зээлийг эзлээд авчих гэж байгаа юм шиг ярих нь хэтэрхий өрөөсгөл. Сошиал хөөсрөл, жагсаал хоёроос болж төр засаг нь шийдвэрээсээ буцаад байвал бид хөгжил дэвшил ярихад хэцүү. Засгийн газар яг юуг хийх вэ гэдгээ танилцуулснаас яаж хийх вэ гэдгээ олон нийтэд тодорхой танилцуулаагүйгээс буруу ойлголт бий болголоо гэж бид харж байна. Тэрнээс аж ахуйн нэгжүүдэд ажиллах хүчин шиг хэрэгтэй юм алга. Улс орны хөгжлийн том төслүүдээс хувийн компаниудын орон сууцны төслүүд хүртэлх амжилттай байх гол суурь нь төслийн бэлтгэл ажил хангах явдал. Үүний дотор хүний нөөцийн хангалттай бэлэн байдал чухал.

-Хууль батлагдвал аж ахуй нэгжүүдэд ямар ашиг тустай вэ. Миний мэдэхээр гадаадаас ажиллах хүч оруулж ирнэ гэдэг тухайн аж ахуй нэгждээ ч амаргүй л байдаг...

-Нэг гадаад ажилтан ажиллуулахад "Хөдөлмөр дэмжих сан"-д цалингийн доод хэмжээг хоёр нугалснаар бид 1320 000 төгрөгийн татвар төлдөг. Ийм татвар төлөөд хямд ажиллах хүч оруулж ирэх нь аж ахуй нэгжид хүндрэлтэй байдаг. Хөдөлмөр дэмжих санд төлж байгаа суурь хураамж ажил олгогчдоо маш их дарамт болдог. Гаднаас ажиллах хүч авч ажиллуулж байсан аж ахуй нэгжүүд бүгд мэднэ. Гадаад ажилтан сард 29 өдөр буюу 26 өдөр байрлан ажиллах нь бүтээмжийн хувьд илүү байдаг. Хүн цаг, ажлын бүтээмжээр яривал бид бүтээн байгуулалтаа богино хугацаанд хийж чадна л гэж харж байгаа.

-Гадаадаас мэргэжилтэй ажиллах хүч авахад тулгардаг хүнд суртлыг арилгах, хураамжийг нь тэглэе гэсэн саналыг 43 салбарын холбоод гаргасан талаар Л.Энх-Амгалан сайд ярьсан. Нэлээд хүнд суртал туулж байж гаднаас ажиллах хүч авдаг юмаа даа..

-Гаднаас ажиллах хүч оруулах зөвшөөрөл авахад доод тал нь хоёр сар хүлээж байж шийдвэрлүүлнэ. Хүнд суртал, дарамт. "Хөдөлмөр дэмжих сан"-д төвлөрүүлсэн мөнгөө дараа нь юунд яаж ашигладаг, ямар үйл ажиллагаа явуулдаг нь тодорхой бус. Аж ахуйн нэгжүүд хүн ажиллуулмаар байдаг. Монгол ажилчдынхаа ур чадварыг сайжруулмаар байдаг. Гэвч бодит байдал дээр ажиллах хүн олдохгүй байна шүү дээ. Гадаадаас ажиллах хүч авахын хувьд давуу тал бий бөгөөд нэгээс хоёр жилийн гэрээгээр ажиллаад л буцдаг. Тэд ч гэсэн амьдрал ахуйдаа нэмэр болох гэж тогтвортой, сайн ажиллах гэж л хүний газар ирж ажилладаг. Манай нарийн мэргэжлийнхэн бүгд гараад явсан гэхэд хилсдэхгүй.

-Монголчууд гадаадад очоод маш сайн ажилладаг гэлцэх юм. Тэгэхээр Монголдоо ажиллах хөшүүрэг нь дутуу байгаа юм биш үү. Энэ тал дээр манай мэргэжлийн холбоод юу бодож санаачилж байдаг нь сонин байна?

- Нэг тэрбумын орлоготой аж ахуй нэгж нэг хувийн ААНОАТ төлж байхад хувь хүн нэг сая төгрөгийн цалингаас ХХОАТ 10 хувь, нийгмийн даатгалын 12 хувийг төлөөд дээр нь НӨОАТ 10 хувийг худалдан авалт болгон дээрээ төлж байхад дотоодын ажиллах хүч гадаадад ажиллаж, өндөр орлоготой байхыг ямагт хүснэ. Зөвхөн цалингийн түвшин, татварын дарамтаас гадна, чанартай сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ амьдрах орчны чанар, агаарын бохирдол, замын түгжрэл, авлига хүнд суртал бизнесийн орчин гээд олон хүчин зүйлсээс хүмүүс, ялангуяа чадвартай боловсон хүчин гадагшаа гарч байна. Хаа сайгүй ажиллах хүч, боловсон хүчний дутагдалд орсон.

-Ирэх оноос мега төслүүд хэрэгжиж эхэлнэ. Мэргэшсэн мэргэжилтнүүд, инженерүүдийн хомсдолд орсон өнөөгийн байдлаар бид энэ ажлыг хийх боломж бий юу?

-Монгол Улс 14 мега төслийг бодлогын төвшинд хэрэгжүүлэхээр болсон. Мөн төрийн болон хувийн бүтээн байгуулалтын ажлууд байна. Үүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц дутна. Эдгээр томоохон төслүүд хэрэгжүүлэхээс өмнө одоогийн нөхцөл байдалд ч ажиллах хүч дутагдалтай байна. Нэг үгээр хэлбэл Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурдыг дотоодын ажиллах хүчний хангалт гүйцэхгүй байна.

-Манайд татварын дарамт асар их нь хувийн хэвшилд ч, хувь хүнд ч шууд

нөлөөлдөг. Танхим, холбоод энэ тал дээр санал болгож сайжруулж байгаа юм бий юу?

-МҮХАҮТ-ын хуулийн шинэчилсэн найруулгад улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, гишүүдийнхээ болон гадаад, дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шинэчлэн батлах шаардлагатай болсон. Бид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд гадаадын ажиллах хүчний квот, ажлын байрны төлбөр хураамжийг хөнгөлүүлэх талаар нийт бизнес эрхлэгчдийн хамт танхимаараа дамжуулан төр засагт дуу хоолойгоо хүргэдэг. Асуудлыг нааштай шийднэ гэдэгт итгэлтэй байгаа. Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Барилгын инженерүүдийн холбоо ТББ, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо ТББ, Хөгжлийн төлөө барилгачдын нэгдэл зэрэг ТББ нь хамтран МАН, АН, ХҮН намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт барилгын салбарт тулгамдаж буй асуудлуудыг тусгуулахаар саналаа боловсруулан хүргүүлсэн. Салбарын хөгжлийн асуудлууд болон хот төлөвлөлт рүү илүү анхаарч, хот суурин газрууд болон дагуул хотуудын бүтээн байгуулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, гэр хороолын дахин төлөвлөлт, зохион байгуулалтын хүрээнд төр, засаг, орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага үүсэж байна. Сүүлийн 20 жилд Улаанбаатар хот нь хэт төвлөрсөн, хот төлөвлөлт эмх замбараагүй болсон, барилгын чанар муудсан, мэргэжлийн ажиллах хүчин хомсдсон зэргээс улбаалж салбарын хөгжил саарч, тулгарч буй олон асуудлууд үүсэж байгаа учраас энэ салбарт: Шинэ техник, технологи нэвтрүүлэх, өнөөдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмыг шинэчлэх, илүү боловсронгуй болгох, ингэхдээ төрийн олон чиг үүргийн заримыг мэргэжлийн холбоодод өгч хэрэгжүүлэх, үнэ тарифыг чөлөөлөх зэргээр төртэй хамтарч ажиллан, тухайн салбарт тулгамдаад буй асуудлыг дорвитой шийдвэрлэх шаардлагатай байгаа талаарх асуудлыг ярилцаж, мөрийн хөтөлбөрт нь тусгуулж, цаашид хэрэгжүүлэн ажиллах талаар саналаа солилцсон.

-Хуулийн төсөлд гадны ажиллах хүчнийг татвараас хөнгөлнө гэсэн байх юм. Энэ нь аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг болно. Гэхдээ өмнө нь зөвхөн тодорхой компаниуд л ийм хөнгөлөлт эдэлж байсан, одоо бүгд хөнгөлөлт эдэлнэ гэж ойлгох нь зөв үү?

- Одоогийн байдлаар Засгийн газрын төслүүдэд гаднаас ажиллах хүч авахад хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлж байсан нь зах зээлийн тэгш байдлыг алдагдуулж ирсэн. Өргөн утгаар харвал гаднаас мэргэжилтэй ажиллах хүч авч байгаа нь Монгол Улс хөгжиж байгаа, эдийн засаг тэлж мэргэжилтэй ажиллах хүчний нийлүүлэлт хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа үйл явц юм. Нөгөөтэйгүүр татварын энэ хөнгөлөлт нь гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхэд бас нэг таатай нөхцөл бүрдүүлнэ гэдгийг бид тооцож үзэх ёстой.

-Барилгын үнэ байнга өсөж байна. Гадаадаас хямд ажиллах хүч орж ирвэл орон сууцны үнэ буурахад нөлөөлөх үү?

-Зөвхөн барилга гэлтгүй бизнесийн бусад салбарт ашиг тусаа үзүүлнэ.

-Ер нь бусад орнууд гадаадаас ажиллах хүч оруулах нь түгээмэл байдаг. Гадаадаас ажиллах хүч авснаар ямар давуу тал гарсан байдаг вэ. Нэгэнт хуулийн төсөл өргөн баригдсан учир гадаад улсуудын туршлагыг судалсан л байх...?

-Европын ихэнх орнууд Киргиз, Узбекстан, Туркээс, мөн Азийн хөгжиж байгаа, хөгжсөн орнууд сүүлийн үед ажиллах хүчээ Мьянмар, Энэтхэгээс авч байгаа. Ялангуяа барилгын салбарт узбек, туркууд ажиллах хүч болж гадаад улс орнуудад ажиллаж байна. 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг Засгийн газраас 2023 оны есдүгээр сард баталсан. Барилгын салбарт гадаад ажилтан авчрах боломжтой тоо 5000 байдаг. Гадаад ажилтан нь Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа тул Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөх ёстой бөгөөд олсон орлогоосоо татвар болон нийгмийн даатгалын шимтгэлд 34 хувийг төлдөг. Нөгөө талаар бид гадаадын мэргэжилтэй ажиллах хүчнээс дотоодын ажиллах хүчээ сургаж дадлагажуулаад авах сайн талыг харах хэрэгтэй. Монгол Улсын салбар бүр хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөгөө эргэн харж, Төр, Хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарч байна. Дунд, урт хугацаандаа энэ нь гадагшаа гарч байгаа урсгалыг тогтоон барих, нөгөө талаар аль ч салбарт ажиллах хүчээ цаашдаа хэрхэн хангаж явах бодлогын бичиг баримтаа эргэн харах цаг болсныг илтгэж байна.

Д.Мөнгөндалай

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.2

ГИШҮҮДЭД

ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛЭН АЖИЛЛАВ

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилтын хүрээнд холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд ӨМНӨГОВЬ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ, НЬЮГОР ХХК, Э ЭЙ БИ ХХК, Н ЭЙ БИ ХХК, ЭМ АЙ АР СИ ХХК, ПАРКОФАСАД ХХК, ЭЙ ЭНД БИ ЭЛИТ КОНСТРАКШН ХХК, ЭМ ЭМ ЭС ИНЖЕНЕРИНГ ХХК, ЭНХ МӨНХ ХҮЧ ХХК нь гишүүнээр элслээ. Мөн “Дулаан шийдэл-2 төсөл”-д чадавхжиж буй бригадын ахлагч Л.Цээрэгзэнг Дэд гишүүнээр элсүүллээ.

МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА МАКС ӨРГӨӨ ХХК, НБИК ХХК ШИЛДЭГЭЭР ШАЛГАРЛАА



“Барилгачдын өдөр 2024” өдөрлөгийн үеэр “ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖҮҮД”-ээр:
-Барилга угсралтын чиглэлээр: **Макс Өргөө ХХК,** Нью Тур ХХК
-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр: **НБИК ХХК** нар шалгарлаа.
Дашрамд дурдахад Макс Өргөө ХХК, НБИК ХХК нар МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүд бөгөөд барилгын салбарт шинэ техник, технологийг нэвтрүүлж байгаагаараа түүчээлж байгаа билээ. Уг арга хэмжээний үеэр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь барилга, хот байгуулалтын салбарынхан, инженер, техникийн ажилтнууд, үе үеийн ахмадуудаа баяр хүргэн амжилт бүтээлийн дээдийг хүслээ. “Монголын барилгачдын өдөр 2024” арга хэмжээний үеэр МБҮА ТББ-ын Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хэлтэс, “Дулаан шийдэл-2” төслийн баг нь нийт 300 гаруй хүнд төслийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэж, хэвлэмэл материалыг тараан ажиллалаа.

“OPEN WEEK” АЯНААР “ТАВАН ТОЛГОЙ-ГАШУУН СУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА





МБҮА ТББ нь Гишүүн байгууллагуудынхаа үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, гишүүн байгууллагууд хоорондын харилцаа холбоог үүсгэх хүрээнд “OPEN WEEK” буюу “Байгууллагын 7 хоног” аяныг зохион байгуулдаг бөгөөд энэ удаагийн арга хэмжээг “БОДЬ ИНТЕРНЭШНЛ” ХХК-тай хамтран “ТАВАН ТОЛГОЙ-ГАШУУН СУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ЦОГЦОЛБОР” төслийг танилцууллаа. МҮХАҮТ-аас Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй оны онцлох аж ахуйн нэгж, байгууллагаар салбарт оруулсан хөрөнгө оруулалт, улсад төлсөн татварын хэмжээ, ажиллагсдын тоо тэр дундаа шинээр ажлын байр бий болгосон зэргийг харгалзан үзэж "Entrepreneur 2023" шалгаруулалтад МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудаас БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ, ИННОВАЦИ НЭВТРҮҮЛЭГЧ

ЭНТРЕПРЕНЕР-ээр буюу хоёр номинацид “Бодь интернэйшнл” ХХК шалгарсан юм. “Бодь интернэйшнл” ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн ерөнхий гүйцэтгэгч бөгөөд Монгол Улсад АНХ УДАА 1-Р ЗЭРЭГЛЭЛИЙН, ХҮНД ДААЦЫН, УУЛЗВАРГҮЙ ТӨМӨР ЗАМ-ыг Монгол инженерүүд өөрсдөө барьж байгуулсан нь үндэсний хэмжээнд нэвтрүүлсэн цоо шинэ бүтээн байгуулалтын ажил болсон тэдийгүй улсынхаа төмөр замын хөгжлийг олон арван жилээр урагшлуулж чадлаа. Тус хүнд даацын 233.6 километр гол замын урттай төмөр замын бүтээн байгуулалт нь:

- Дээд, доод бүтэц
- Дохиолол холбоо
- Барилга байгууламж
- Эрчим хүч
- Хөдлөх бүрэлдэхүүн

Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж гэсэн (6) багц ажлаас бүрдсэн, багц бүртээ техник, технологийн өндөр үр ашигтай, дэвшилтэт, олон инновацтай шийдлийг нэвтрүүлсэн болно.

МБҮА ТББ-ЫН НИЙТ ГИШҮҮДИЙН “**САНАЛ, ХҮСЭЛТИЙН СУДАЛГАА**”-Г ГҮЙЦЭТГҮҮЛСЭН БИЛЭЭ

МБҮА ТББ-ын Ажлын алба нь өөрийн гишүүн байгууллагуудынхаа үйл ажиллагаанд тус нэмэр, дэмжлэг болгон ажиллах зорилготойгоор жил бүр явуулдаг бөгөөд Таныг 2023 онд бидний явуулсан үйл ажиллагаанд үнэлгээ-дүгнэлтийг өгөхийн зэрэгцээ 2024 онд ямар үйл ажиллагааг явуулбал танай байгууллагад хэрэгцээтэй байгаа талаарх өөрийн бодит санал, хүсэлтийг илгээж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. Уг судалгааг хөндлөнгийн байр сууринаас гүйцэтгэх боломжийг МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагууд болох “Инвескор проперти” ХХК болон “Тэнхлэг зууч” ХХК-дад хүсэлтийг тавьж, үнийн санал авсны дагуу “Инвескор проперти” ХХК-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр 2023 оны МБҮА ТББ-ын Нийт гишүүдийн “**САНАЛ, ХҮСЭЛТИЙН СУДАЛГАА**”-г гүйцэтгүүлсэн билээ. МБҮА ТББ-ын УЗГ, Инвескор проперти ХХК-иас 2 дахь жилдээ эрхлэн гаргаж буй “УЛААНБААТАР ХОТЫН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-ЖИЛИЙН ТАЙЛАН 2023-2024”-ийн шинэ дугаар харилцагч уншигчдад хүрэхэд бэлэн боллоо. Энэхүү тайлан нь нийт 9 агуулгын хүрээнд Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн салбарыг бүрдүүлж буй зах зээлийн чиг хандлага, шинэ төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, экосистемийн оролцогч нарт хамаарах төрөөс баримталж буй шинэ бодлого зохицуулалт, бусад оролцогч нарын тус салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тулгарч буй сорилт, боломжуудын талаар үнэ цэнтэй ойлголтыг агуулсан цогц дүн шинжилгээ бүхий мэдээллийг өгөх зорилготой юм. **ТАЙЛАН УНШИЖ, ТАНИЛЦАХ БОЛ:**

Тайлангийн хураангуй хувилбарыг цахимаар үзэх бол: https://bitly.ws/3gxtU

Тайлангийн бүтэн хувилбарын хэвлэмэл хувийг худалдан авах бол: https://bitly.ws/3eoVd





МБҮА ТББ нь Гишүүн байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчилж, гишүүн байгууллага хоорондын харилцаа холбоог сайжруулан, өргөжүүлэх зорилгоор “OPEN WEEK” буюу “Байгууллагын нээлттэй 7 Хоног” аяны хэмжээг зохион байгуулдаг билээ. Энэ



удаагийн аянд МБҮА ТББ-ын УЗГ, Юни Стийл Констракшн ХХК нь 2024.04.22-26-ний өдрүүдэд зохион байгуулан оролцлоо. Юни стийл Констракшн ХХК нь барилга угсралт, барилгын материалын худалдаа, хэв хашмалын түрээсийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулаад 10 орчим жил болж байгаа компани бөгөөд тус байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулахыг нийт гишүүн байгууллага болон олон нийтэд сурталчлан хүргэн ажиллаа. Мөн түүнчлэн, жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Build Mongolia 2024” Олон улсын үзэсгэлэнд оролцож буй дараах гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилготойгоор богино хэмжээний сурвалжлага, ярилцлагыг ведиожуулан олон нийтэд хүргэн ажиллаа.



Үүнд:

- Топологи ХХХ https://youtu.be/1P_P7QUGpSw
- Нутгийн Буян Групп ХХК
- Монгол Базальт ХК
- НБИК ХХК https://www.youtube.com/watch?v=esu0XERQuDc
- Юни Стийл Констракшн ХХК https://www.youtube.com/watch?v=vudMp9jrSnE

зэрэг болно.

МБҮА ТББ, УГЗ, БАРИЛГА МН ХХК БОЛОН БАРИЛГЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЗӨВЛӨЛТЭЙ ХАМТРАН БНХАУ-ЫН ЭРЭЭН ХОТНОО “МОНГОЛ, ХЯТАДЫН БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС УУЛЗАЛТ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улс, БНХАУ-ын барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, чөлөөт бүс болон хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл солилцох, хоёр орны барилгын бизнес эрхлэгчид санал солилцох, бизнесийн гэрээ хэлэлцээр хийх, хөрөнгө оруулалтын боломжуудаа нэмэгдүүлэх, барилгын салбарын эдийн засгийн өсөлтийн тогтвортой орчныг бүрдүүлэх зорилготойгоор МБҮА ТББ, УГЗ, Барилга МН ХХК болон Барилгын Ханган Нийлүүлэгчдийн Зөвлөлтэй хамтран БНХАУ-ын 2024.04.19-ний өдөр Эрээн хотноо “Монгол, Хятадын барилгын салбарын бизнес уулзалт”-ыг зохион байгуулаа. Уулзалтын үеэр Монгол Улсын талаас барилгын салбарын зах зээлийн талаар танилцуулсан бол БНХАУ-ын талаас чөлөөт бүсийн бодлого, бизнесийн боломж болон хамтын ажиллагааны талаар хэлэлцэж B2B уулзалт, бизнес аялал зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд БНХАУ талаас барилгын салбарын 60 гаруй компанийн төлөөлөл, Монголын талаас 50 гаруй барилгын салбарын аж ахуй нэгжийн удирдлагууд оролцож бизнесийн гэрээ хэлэлцээрүүд хийгдлээ.

КАНАД УЛСЫН ЭСЯ-ТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН “ИННОВАЦ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН”-Д ГИШҮҮДЭЭ ХАМРУУЛЛАА



МБҮА ТББ нь Канад Улсын ЭСЯ-тай хамтран зохион байгуулж буй “Инновац, Сэргээгдэх Эрчим Хүч, Эрчим Хүчний Үр Ашгийн Олон Улсын Үзэсгэлэн”-ийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй технологи танилцуулах, компаниудын танилцуулга, B2B уулзалтыг 2024.05.17-ны өдөр Мишээл экспо төвд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй технологи бүхий Канад Улсын 4 компанийн үйл ажиллагааг цахимаар танилцууллаа. Мөн Канадын компаниудтай хамтран ажиллах, B2B уулзалтад оролцох хүсэлтэй гишүүдийг Канад Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Худалдааны төлөөлөгчтэй холбох, зуучлах ажлыг хийснээр Сэрүүн ХХК нь SolarWall -ын үйл ажиллагаатай танилцсан юм. Уулзалтад М Си Эс Проперти ХХК, Динамик Тауэр ХХК, Дабль Пирамид Констракшн ХХК, Ричвелл Инженеринг ХХК Сэрүүн ХХК, Глобал Телеком Инженеринг ХХК, Топологи ХХК, Эрчим Инженеринг ХХК-ууд оролцлоо.

НБИК ХХК, М СИ ЭС ПРОПЕРТИ ХХК, МОНКОН ГРУПП ХХК, БОДЬ ПРОПЕРТИЗ ХХК-ИУД НЬ “НИЙТ УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСӨЛД ОРОЛЦОН АЖИЛЛАЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын МСК-ийн хооронд байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор





нэмэгдүүлэхэд чиглэсэн “НИЙТ УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” хөтөлбөр хэрэгжиж байгаа билээ. Уг хөтөлбөрийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр, урт хугацаанд тогтвортой хангах зорилгоор газрын доорх усны Баруун эх үүсвэрийг байгуулахаар Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн шинэ эх үүсвэрүүдийг байгуулж, дэвшилтэт технологи бүхий ус гүн цэвэршүүлэх байгууламжид ундны усны стандартад нийцүүлэн цэвэршүүлж хотын ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх юм байна. Барилга, хот байгуулалтын яамны Хяналт Шинжилгээ, Дотоод Аудитын Газар МБҮА ТББ-ын хамт тус төсөлд ажиллаж буй аж ахуйн нэгжүүд, барилгын компаниудын ажиллагсдын ажлын орчин нөхцөл, жендэрийн мэдрэмжийг хэрхэн бүрдүүлж буй эсэх дээр үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт, туршилт, үнэлгээний ажлыг хийлээ. Тус төсөл хөтөлбөрийн бүтээн байгуулалтын ажилд МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болох НБИК ХХК, М Си Эс Проперти ХХК, Монкон групп ХХК, Бодь пропертиз ХХК-иуд оролцож байгаа бөгөөд шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

ФИДИК ГЭРЭЭНИЙ ОЙЛГОЛТЫН ТАЛААРХ СУРГАЛТЫГ ХИЙЛЭЭ

Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-ийн “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН” болсон МБҮА ТББ нь МБИХ-той хамтран Гишүүн байгууллагуудын хүрээнд ФИДИК байгууллагын үйл ажиллагааны тухай,



ФИДИК-ийн жишиг гэрээнүүд, тэдгээрийн ялгаа, жижиг гэрээнээс хэрхэн сонгох тухай, Улаан, Шар болон Мөнгөлөг гэрээнүүдийн ялгаа, бүтэц, тусгай нөхцөл, зааварчилгаа, алтан зарчмуудын талаар ойлголтыг өгөх сургалтыг хийлээ. Уг сургалтын хүрээнд гэрээний талууд, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагын зохицуулалт, захиалагч болоод Инженер, Гүйцэтгэгчийн эрх үүрэг, хариуцлага, ажил эхлүүлэх, хойшлох, түр зогсоох гэрээ цуцлах үеийн зохицуулалт болоод гэрээний үнэ, төлбөр, баталгаа, даатгалын талаарх үндсэн ойлголтуудыг өглөө. Мөн барилгын төслүүдэд түгээмэл тохиолддог маргаан шийдвэрлэлтийн асуудлыг уг гэрээгээр хэрхэн зохицуулалт хийдэг талаарх ойлголтыг төсөл хэрэгжүүлэгч нарт өгсөн юм. МБҮА ТББ нь ФИДИК-ийг Монгол Улсад төлөөлөх “Түншлэгч гишүүн” болж, барилга, хот байгуулалтын салбарт ФИДИК-ийн гэрээг хэрэгжүүлэх үйл явцыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган чадавхжуулах зэрэг ажлыг зохион байгуулж, салбарын үйл ажиллагаанд оролцогч Хөрөнгө оруулагч, Захиалагч, Гүйцэтгэгч, Зураг төсөл зохиогч нарын хоорондын харилцааг зохицуулах, эрх тэгш байдлыг хангах, хамгаалан ажиллах үүргийг хүлээх, улмаар Монгол Улсад ФИДИК-ийн гэрээг түгээх Гишүүн холбоодын нийтлэг мэргэжлийн эрх ашгийг хөгжүүлэх, Өөрийн гишүүн, үндэсний хэмжээний холбоодод мэдээллийг түгээх зэрэг Монгол Улсын барилгын салбарт ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ СТАНДАРТЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

“ШИНЭ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГДСЭН УУЛЗАЛТ & B2B” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудын хоорондын харилцаа холбоог сайжруулж хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “ШИНЭ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН





НЭГДСЭН УУЛЗАЛТ & B2B АРГА ХЭМЖЭЭ”-г 2024.08.29-ний Пүрэв гаригт, МН Тауэр, МБҮА ТББ-ын Ажлын албаны оффисын хурлын өрөөнд зохион байгууллаа. Энэ удаагийн арга хэмжээнд Н Эй Би ХХК, Хотол архитекторс ХХК, Хархорин-өргөө, Эм Ай Ар Си ХХК, Парко фасад ХХК, Топологи ХХК, Бульдорс мон ХХК нарын 10 гаруй компанийн төлөөллүүд оролцлоо. Уулзалтын үеэр шинэ гишүүн байгууллагын төлөөллүүдэд МБҮА ТББ-ын Ажлын албаны Гишүүнчлэл, маркетингийн менежер Х.Намуун, БҮАТЗ-ийн үйл ажиллагааг тус хэлтсийн мэргэжилтэн П.Батзаяа, “Дулаан шийдэл-2 төсөл”-ийг Төслийн менежер Г.Мөнхтуяа нар тус тус танилцууллаа. Арга хэмжээний үеэр шинэ гишүүн компаниудаас ТОПОЛОГИ ХХК, Монгол Улсад анх удаа фасадны үйлдвэрийг нээж үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа Парко фасад ХХК-ийн төлөөллүүд байгууллагынхаа үйл ажиллагаа, шинэ бүтээгдэхүүний талаар танилцуулж, гишүүн байгууллагууд хоорондоо харилцаа холбоог үүсгэж, танилцаж, чөлөөт санйй бодлоо солилцсон үр дүнтэй уулзалт боллоо. Мөн арга хэмжээний үеэр шинэ гишүүн байгууллагаар элссэн Гишүүн компаниудтайгаа гэрээг байгуулж, гэрчилгээг нь гардуулан өглөө.

“БАРИЛГА, ОРОН СУУЦ 2024” ҮЗЭСГЭЛЭНД БАРИЛГЫН САЛБАРЫН ШИЛДЭГ ТЕХНОЛОГИ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ШИНЭ ТӨСЛҮҮДИЙГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА





Шинэ үеийн барилгын салбар үүсэж хөгжсөний 98 жилийн ой, барилгачдын баярын өдрөөр “Барилга орон сууц 2024” үзэсгэлэн нь нээлтээ хийж барилгын компаниудын шилдэг технологи, шинэ бүтээгдэхүүн, шинэ төслүүдийг танилцууллаа. “Барилга орон сууц 2024” үзэсгэлэнгийн нээлтийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд С.Одонтуяа болон барилгын салбарын төрийн бус байгууллагуудын тэргүүнүүд нь оролцож, салбарын хөгжил дэвшил, бодлого шийдвэрийн талаар танилцуулж, барилгачдын баярын мэндчилгээг дэвшүүллээ.

Уг үзэсгэлэн нь 2024.09.06-08-ны өдрүүдэд Буянт Ухаа спорт цогцолборт зохион байгуулагдаж байгаа бөгөөд эдгээр өдрүүдэд шинэ орон сууцыг сонирхож буй иргэд, хэрэглэгчид нь ипотек, компанийн болон хувь лизингд хамрагдах боломжтой төдийгүй дундын зуучүйгээр 30 хүртэлх хувиар шинэ орон сууцаа хямдруулан авах нөхцөлийг олгож байлаа. “БАРИЛГА, ОРОН СУУЦ 2024” үзэсгэлэнд шинэ орон сууцны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид, амины орон сууц, хаусны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчид, барилгын материал үйлдвэрлэгчид, барилгын ханган нийлүүлэгчид, барилгын тоног төхөөрөмж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэгчид, Олон улсын оролцогчид (Хятад, Орос, Итали), Зураг төсөл, Интерьер дизайн, Ландшафт, Халаалт, агааржуулалтын шийдэл, Сэргээгдэх эрчим хүч гэх мэт чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг 200 орчим аж ахуйн нэгж, байгууллагууд оролцлоо. Тухайлбал, МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болох Монгол базальт ХК, Эко констракшн ХХК, Ти энд жи ХХК, Барилга мн ХХК, Оффис партнер ХХК, Эрин интернэшл ХХК, Парко фасад ХХК, Топологи ХХК, Модун ХХК-иудын байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнүүд нь хэрэглэгчдийн сонирхлыг маш ихээр татаж байлаа. Мөн үзэсгэлэнгийн өдрүүдэд барилгын салбар дахь төрийн бодлого, шийдвэрүүд, Үл хөдлөх хөрөнгийн зах зээл, үнэ ханш, ипотекийн зээл, дэвшилтэт технологиуд болон Шинэ Орон Сууцны төсөл хэрэгжүүлэгч төлөөллүүд, салбарын мэргэжилтнүүдийн илтгэл семинарууд үнэ төлбөргүй тавигдаж байна.

ОЛОН УЛСЫН МАСТЕР БАГШ Э.ЧИНЗОРИГ МБҮА ТББ-ЫН ЗАХИРЛУУДАД СУРГАЛТ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ нь 15 жилийн ойн хүрээнд гишүүн байгууллагын захирал, удирдах ажилтнуудад зориулж МАНЛАЙЛАГЧ БА МЕНЕЖЕР-ийн ялгаа сэдвээр сургалтыг Монгол дахь Далье Карегийн Монглд дахь салбарын үүсгэн байгуулагч, Олон улсын мастер трейнер Э.Чинзориг-оор илтгэл хийлгэлээ. Монгол Улсад ажил олгогчид, компанийн захирлууд бизнесээ хойшид санаа зовохгүйгээр үргэлжлүүлэх, залуу менежерүүдэд ямар үлгэр дуурайлал, боломжийг олгох талаарх ойлголтыг өгсөн уг сургалт нь барилгын салбар гэхгүй олон бизнесмэнүүдэд цаашид хэрхэн ажиллах талаарх ойлголтыг өглөө.



2024



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.8

ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД Ж.БАТСУУРЬ САЛБАРЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ





Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь 2024.07.25-ны өдөр барилга, бүтээн байгуулалтын салбарт үйл ажиллагаагаа явуулж буй нийт 30 гаруй төрийн бус байгууллагуудын удирдлагуудыг хүлээн авч уулзан барилгын салбарт тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлүүд, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо. Уулзалтын үеэр төрийн бус байгууллагуудын удирдлагууд нь барилгын салбарын түншлэл нь өргөжин тэлж, ил тод, шуурхай болсоор байгаа ч хууль эрх зүйн хувьд улам боловсронгуй болгох, сайжруулах, өөрчилж шинэчлэлтийг хийх, мөн төр болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, цаашид яамнаас хэрэгжүүлэх арга хэмжээ болон барилгын материалын чанарыг сайжруулах, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх, норм дүрмийн бодлогыг шинэчлэн сайжруулах зэрэг асуудлууд байгааг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад уламжилж, шийдвэрлэх тал дээр анхаарч ажиллахыг хүссэн бол Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын зүгээс Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь дараах саналыг уламжлав. Үүнд:

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, төр-хувийн хэвшил, салбарын ТББ-уудын 2 талын хамтын ажиллагааны байнгын бүтцийг бий болгох.
- Шинээр эмхлэн байгуулагдсан Засгийн газрын хувьд хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 4 жилийн Стратеги төлөвлөгөөг салбарын ТББ-уудтай хамтран шинэчлэн баталж, салбарт тулгамдаж буй асуудлуудын чухлын эрэмбэ гарган төсөл, хөтөлбөржүүлэх замаар ажил хэрэг болгох
- Ирэх 4 жилийн хугацаанд барилгын салбарыг авилгагүй салбар болгохын тулд системийн шинэчлэлийг хийсэн он жилүүд болгох зэрэг саналууд байв.

МОНГОЛ УЛС-БНСУ-ЫН БАРИЛГА, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АССОЦИАЦИУДЫН БОЛОН КОМПАНИУДЫН БИЗНЕСИЙН ФОРУМ” -ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ (МБҮА ТББ), БНСУ-ын Барилгын Ассоциаци (САК) хамтран, Эдийн Засаг, Хөгжлийн яам, Хот Байгуулалт, Барилга, Орон Сууцжуулалтын яамдын дэмжлэгтэйгээр “МОНГОЛ УЛС-БНСУ-ЫН БАРИЛГА, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН “БИЗНЕСИЙН ФОРУМ”-ыг зохион байгууллаа. Энэ жил Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын үүсгэн байгуулагдсаны 15 жилийн ой тохиож байгаа ба одоогоор Монгол Улсын барилга, хот байгуулалтын салбарт үйл ажиллагаагаа явуулж буй 200 гаруй гишүүн компаниудыг эгнээндээ нэгтгэсэн, тэдгээр нь манай улсын 70-80%-ийн бүтээн байгуулалтыг барьж гүйцэтгэсэн томоохон компаниудын нэгдэл байдаг юм. Харин БНСУ-ын Барилгын Ассоциаци (САК) нь 1945 онд үүсгэн байгуулагдсан, 70 гаруй жилийн түүхтэй, нийт 7,000 гаруй гишүүн компаниудыг

эгнээндээ нэгтгэсэн, 16 муж дахь салбар дээрээ тулгуурлан өөрийн үйл ажиллагаагаа явуулж буй томоохон мэргэжлийн ассоциаци юм.





Уг “Бизнесийн форум” нь хоёр улсын хоорондын эдийн засгийн харилцааг өргөжүүлэх талуудын хөрөнгө оруулалт болон хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх боломжуудыг эрэлхийлэх, салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага, орчин үеийн дэвшилтэд техник технологи, эрх зүйн орчныг чиглэлийн мэдээ мэдээллийг солилцох “платформ”-ыг бий болгож байгаадаа оршиж байгаа юм. Энэхүү “Бизнесийн форум”-д БНСУ-ын Барилгын Ассоциацийн Кёнбүк салбар мужийн удирдлагууд болон барилга, бүтээн байгуулалт, бусад бизнесийн салбарын 70 орчим компаниудын төлөөллүүд, МБҮА ТББ-ын гишүүн компаниуд, барилга, бүтээн байгуулагчид, мэргэшсэн зөвлөхүүд, инженерүүд, экспертүүд, мөн салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүд оролцож Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, томоохон төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломж, хөрөнгө оруулалт, худалдааны орчин; Барилга, хот байгуулалтын салбарт баримталж буй бодлого төлөвлөлт; Монгол-Солонгосын Барилгын Ассоциациудын явуулж буй үйл ажиллагааны талаарх илтгэлүүдийг танилцуулж, улмаар энэ хоёр Ассоциациудын цаашдын хамтын ажиллагаа, хамтран ажиллах боломжит төслүүдийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг хийх боломжийг судлах зэрэг асуудлуудыг хөндлөө.



“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААР ТАЙЛБАР ХИЙЛЭЭ

“Хөрөнгө оруулалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцэх гэж байгаа энэ цаг үед “АмЧам Монгол” ТББ-ын Гүйцэтгэх захирал О.Адьяа, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин, "АмЧам Монгол” ТББ-ын Бодлого хариуцсан захирал Г.Жавхлантөгс, Их Британийн Худалдааны танхимын төлөөлөл Тоби Филпотт, Их Британи-Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо, Монголын Бизнесийн Форум, Европ-Монголын хамтарсан ХАҮТ, Улаанбаатар хотын Худалдааны танхим төлөөллүүд 2024.01-р сард байр сууриа илэрхийлэв. МҮХАҮТ-ын зүгээс 60 орчим саналыг хүргүүлсний зарим санал нь хуулийн төсөлд тусгагдан орсон ба бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаагаар хууль, эрх зүйн орчин тогтвортой байх тухай ойлголт бөгөөд урт хугацааны хөрөнгө оруулалтыг хийдэг ААНБ-дад хүндрэлтэй байдал үүсгэдэг. Дээрх саналыг хуулийн 6.1.2, 6.1.3-т өөрсдийн эрх ашиг, хөрөнгө оруулагчдын эрх ашигтай холбоотой хөндсөн асуудлыг оновчтой болгож, гадаадын хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангадаг, хэлэлцүүлэгт оролцох боломжийг бүрдүүлэх талаарх эдийн засгийн холбогдолтой заалтууд нь анх удаа орсон байгаа. Мөн төрийн байгууллагуудын уялдаа холбоо, Засгийн газар болон орон нутгийн түвшинд гаргасан шийдвэрээ ойлголцдоггүй, уялдаагүй байдал нь хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагааг хийх орчныг тогтворгүй болгодог. Мөн “Гадаадын хөрөнгө оруулалтуудын хувьд татварын хувь хэмжээ, шимтгэлээс гадна маргаан үүсэхэд шийдвэрлэх арга зам нь ямар байх нь

хамгийн чухал асуудал бөгөөд “Маргаан гомдлыг шийдвэрлэх зөвлөл”-ийг байгуулахаар заасан нь онцлог байна.

Их Британийн худалдааны танхимын төлөөлөл Тоби Филпотт: Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд шийдвэрлэх шаардлагатай сүүлийн 10 жилд байгаа асуудлуудыг энэ хуулиар шийдвэрлэх болов уу гэсэн найдлага тавьж байгаа. Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж буй байдлыг бусад улстай харьцуулсан олон улсын статистикаас нэлээд хойгуур жагсаж буйг харж болно. Би 7 жилийн өмнөөс Монгол Улсын эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхийн тулд ирсэн. Долоон жилийн дараа ч бид эдийн засгийн төрөлжилт гэдэг сэдвийг ярьсаар байна. Хөрөнгө оруулалтын хууль батлагдсанаар эдийн засгийн төрөлжилт илүү идэвхжиж, зөвхөн уул уурхайн салбарт бүх хөрөнгө оруулалт татагдах бус уул уурхайн бус салбарт ч хөрөнгө оруулалтыг оруулж ирэх боломжийг нээгдэх байх гэж бодож байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирснээр ажлын байр нэмэгдэх, технологи, ноу-хау нэвтрэх зэрэг олон давуу талыг эдийн засагт бий болгоно. Их Британийн худалдааны танхимын зүгээс онцгойлон хэлэхэд Америк-Монголын хооронд байгуулагдсан “Ил тод байдлын хэлэлцээр”-ийг бүрэн хэрэгжүүлэх ажил чухал байна. Аливаа бизнесийн гэрээ, хэлэлцээр нь бүрэн хэрэгжиж, аль аль тал нь гэрээний хэрэгжилтийг хүндэтгэх нь чухал. Бизнесийн ямар нэг маргаан гарсан тохиолдолд шударга, шуурхай шийдвэрлэдэг байх хэрэгтэй. Хөрөнгө оруулагчдын хүсдэг зүйл нь тогтвортой байдал. Бидний хувьд валютын ханш, хууль эрхзүйн орчин тогтвортой байх нь чухал талаар байр сууриа илэрхийллээ.

МҮХАҮТ НЬ ЗГХЭГ, ЭЗХЯ, ХЗДХЯ-ТАЙ ХАМТРАН “ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ” ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХИЙЖ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛҮҮДИЙГ АРИЛГАХААР АЖИЛЛАЛАА

МҮХАҮТ нь ЗГХЭГ, ЭЗХЯ, ХЗДХЯ-тай хамтран “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөө” хэлэлцүүлгийг 2024.02.27-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн



төлөөллүүд оролцож, тус хуулийн хэрэгжилт, үр нөлөө, тулгамдаж буй асуудлыг ярилцав. Хэлэлцүүлэгт ЭЗХ-ийн Дэд сайд Г.Түвдэндорж нь “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар”, МҮХАҮТ-ын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийн дарга, “Зөвшөөрлийн зөвлөл”-ийн гишүүн Ө.Жамбалсүрэн нь “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад бизнест тулгамдаж буй асуудлын талаар” илтгэлдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойш 7 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан нь хуулийн тогтворгүй байдлыг үүсгэж, улмаар бизнест эрхлэгчдэд учрах сөрөг үр дагавартай байгаа талаар онцлов. Хэлэлцүүлгийн үеэр хуулийн хэрэгжилт, хууль хоорондын давхцалын талаар хэд хэдэн асуудлуудыг хөндсөн бөгөөд “Зөвшөөрлийн зөвлөл”-ийн Дэд дарга Б.Баасандорж нь зарим асуудлыг холбогдох газарт нь уламжилж, хууль хоорондын давхцалыг “Зөвшөөрлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлэх саналыг оруулахаа мэдэгдэв. МҮХАҮТ-аас энэ удаагийн хэлэлцүүлгээс гарсан саналууд болон өмнө нь бизнес эрхлэгчдээс Танхимд ирүүлсэн саналуудыг нэгтгэн “Зөвшөөрлийн зөвлөл” болон холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэн ажиллахаар тохирлоо.

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих, бодлогыг тодорхойлох зорилгоор “Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг боловсруулаад байгаа бөгөөд тус төслийг



Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар нь БХБЯ, УБЗАА, Монголын Архитектурын Эвлэл ТББ, Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо ТББ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын Холбоо, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо ТББ, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (JICA) зэрэг хот байгуулалтын төлөөллүүд, архитекторуудыг хүлээн авч уулзаж, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дагуул 13 хот байгуулахаар төлөвлөсний дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогод олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, шинэ суурьшлын бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг Хөшгийн хөндийд Шинэ Зуунмод дагуул хотыг байгуулахаар ажиллаж байгаа билээ. Нийслэлийн хүн ам 2040 он гэхэд 2,248,000-д хүрэх тооцоо гарснаас 440,000 нь дагуул хотууд руу суурьшуулах төлөвлөлттэй байгаа ба Хөшгийн хөндийг 150 мянган хүн амтай хот болгохоор төлөвлөж байгаа юм байна. талаар тусгасны дагуу Одоогийн байдлаар ус хангамж, цахилгаан, үерийн далан шугамын нийт 162 тэрбум төгрөгийн ажил 2023, 2024 онд санхүүжигдээд явж байгаа ба суурь дэд бүтцийн хувьд 30%-ийн гүйцэтгэлтэй байна. Ирэх онуудад улсын төсөв, донор байгууллагуудын эх үүсвэрүүдээр дэд бүтцээ хийхээр төлөвлөж байна.

“ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД



Хот байгуулалтын төлөвлөлтийн хүрээнд: Оршин суугч нь оршин суугаа газраас 15 минутын хугацаанд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээний буудал, цэцэрлэгт хүрээлэн, худалдаа, үйлчилгээний газарт хүрэх боломжтой байх бөгөөд нисэх онгоцны буудлын ард Олон нийт, худалдаа үйлчилгээний бүс, Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүс, Оюутны хотхон, судалгаа шинжилгээний төв, Худалдаа, бөөний төв, Төмөр замын өртөө, тээвэр, логистик, үйлдвэрлэлийн бүс, Эдийн засгийн чөлөөт бүс гэж хуваасан бөгөөд олон улсын хурал, үзэсгэлэнгийн цогцолбор, 25,000 хүний суудалтай битүү цэнгэлдэх хүрээлэнг барихаар төлөвлөжээ.

Удирдлагын тогтолцооны хувьд: Хотын зөвлөл, Хотын захирагч, Хотын ерөнхий архитектор, Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорациас бүрдэнэ. Зөвлөл нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд Хотын захирагчийг хотын оршин суугчдаас шууд сонгуулийн үндсэн дээр сонгоно.

Хотын бизнесийн орчин, хөрөнгө оруулалт болоод хотод үзүүлэх татварын дэмжлэгийн хүрээнд бизнес эрхлэгчдэд худалдаа, татвар, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх бүртгэл, зөвшөөрлийн нэг цонхны үйлчилгээнд суурилж, импортын, гаалийн, НӨАТ-ын, газрын татвараас хөнгөлөх, чөлөөлөх, нийслэлээс нүүж тэнд байнгын байршиж ажиллах ААНБ-д ААНОАТ-аас хөнгөлөх, хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, худалдан авсан орон



сууцны үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлөх зэрэг дэмжлэгүүдийг үзүүлсэн байна. Уг уулзалт-хэлэлцүүлэгт **МБҮА ТББ-ын УЗГ, Ти энд жи ХХК-ийн Захирал, Зөвлөх инженер Н.Цогтоо нь:** Юуны өмнө тус хуулийн төслийг боловсруулан оруулж ирж буй “Ажлын хэсэг”-хэнд амжилт хүсье ээ. Энэ хуулийн төслийн зүйл заалтад редакцын жижиг сажиг асуудлууд байгаа ч тэрийг хуулийн “Ажлын хэсэг” нь засаад явна биз. Гол нь энэ хуулийн төсөлд Ерөнхий архитектор нь Зөвлөлийн гишүүдээ ахалдаг байвал зүгээр байх гэж бодож байна. Мөн Шинэ Зуунмод нь Хотын хөгжлийн корпорациас бүрдэнэ гэж оруулж ирж байгаа нь яваандаа бизнесийн эрх ашгийн зөрчил үүсэж магадгүй, хэрвээ оруулъя гэвэл тусдаа хуулиар зохицуулаад явбал зүгээр байх гэдэг саналыг хэлэв. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг Дагуул хот (ub.gov.mn) үзнэ үү.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ УУЛЗЛАА



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нь барилгын салбарын бизнес эрхлэгчидтэй уулзаж хотын барилгажилт, баримталж буй бодлогыг танилцуулан улмаар салбарын бизнес эрхлэгчдийн тулгамдаж буй асуудлыг сонсож, шийдвэрлэх арга замын талаар санал солилцов. Хотын дарга нь Улаанбаатар хот нь нэг төвт хотоос олон төвт хот болохоор зорьж буй бөгөөд 2 хотын төв, 5 дэд төвийг байгуулна. Дэд төвүүдийг байгуулснаар хотын төвийг чиглэсэн хөдөлгөөн нь 29%-иар буурна гэж үзэж буй. Өнөөдрийн байдлаар Баянхошуу, Сэлбэ дэд төвийн дэд бүтцийн ажлууд дууссан бол үлдсэн 3 дэд төвийн дэд бүтцийн ажил үргэлжилж байна. Дэд төвүүдийг байгуулснаар шинээр 182,300 ажлын байр бий болно. Өмнө нь “хот байгуулалтын тухай” хуульд барилгажих талбайн 70% нь барилга, 30% нь ногоон байгууламж байхаар заасан бол “Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай” хуулийг баталснаар 60% нь барилга, 40% нь ногоон байгууламж байхаар болсныг хэлж байв. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулгаж, дахин барилгажуулах төслүүдийг хэрэгжүүлнэ. Судалгаагаар Улаанбаатар хотод газар хөдлөлтөд тэсвэргүй 409, ашиглахыг хориглосон 357 барилга байна. Өнөөдрийн байдлаар 1,444 өрхийн 67 барилгыг буулгаж, 3,270 өрхийн 26 барилгыг ашиглалтад оруулаад байгаа юм байна. Тус уулзалтын үеэр **Барилга эм эн ХХК-ийн Захирал Г.Батсүх нь:** Юуны өмнө барилгын төлөөллүүдийг хүлээн авч уулзаж байгаа хотын удирдлагуудад баярлалаа, та бүхний танилцуулсан ажлууд нь богино хугацаанд хийгдэж амжихгүй тул цаашид төлөвлөсөн аажлуудаа тогтвортой хэрэгжүүлэх тогтолцоог хэрхэн хийх вэ. Олон асуудлууд дээр хамтран ажиллах талаар албан бичгээр хүргүүлсэн боловч ямар нэгэн хариуг өгөхгүй байна. Удахгүй барилгын салбарынхны нэгдсэн экспо болох гэж байгаа тул та бүхнийг хүрэлцэн ирж сонирхоорой хэмээж, урилгаа гардуулав.



Гурван бухат ХХК-ийн Захирал Т.Ганчимэг нь: Манай компани нь гэр хорооллын дахин төлөвлөлт дээр ажилладаг. Төслөө хэрэгжүүлэхийн тулд бүх асуудлаа өөрсдөө шийдээд, айлуудаа чөлөөлөөд, түрээсийн байранд оруулаад, тэгээд төслөө хэрэгжүүлдэг. Аливаа асуудлыг шийдүүлэхийн тулд төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдэд хүсэлтээ өгөхөд тэд хуулийн хугацаандаа шийднэ гээд ширээн дотроо дараад маш их цаг хугацааг алддаг. Нэг албан хаагчийн ширээний нүдэнд хийгдсэн албан бичгийн хариуг харж аж ахуйн нэгжүүд банканд өдөр хоногоор

мөнгөө алдаж суудаг. Төрийн байгууллагуудаас гарч байгаа аливаа шийдвэрүүд нь хурдан, аж ахуйн нэгжүүдээ бодсон байгаасай гэж хүсэх байна гэв.

Бармон ХХК-ийн Захирал Ш.Үнэнбат нь:



Хотын удирдлагууд энд сууж байгаа дээр хэлье. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гэж гаргачхаад тэрүүн дотор нь ахиад төлөвлөгөөг гаргаж байгааг ерөөсөө ойлгохгүй байна. Журмын дагуу явмаар байна. Мөн гэр хорооллын дахин төлөвлөлтөд оролцож байгаа компаниуд нь өнөөдөр маш хэцүү байдалд байна, энэ компаниудаа хүлээн авч уулзаад үүсээд байгаа, тулгамдаад байгаа асуудлуудыг шийдээд явах хэрэгтэй байна гэв. Ийнхүү бүтэн хоёр цаг гаруй үргэлжилсэн уулзалт арга хэмжээний төгсгөлд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар “Арцат, Зайсан, Бага тэнгэрийн аманд хууль бусаар газар олгосон, олгосон газрыг барилгын компаниудад зарсан асуудал бий. Энд баригдсан орон сууц, барилга улсын бүртгэлд бүртгэгдээгүй. Энэ нь өөрөө эдийн засгийн эргэлтэд орж чадахгүй нөхцөл байдалтай байна. Тиймээс БОАЖЯ-аас олгосон бүх газрыг нийслэлийн мэдэлд шилжүүлж, тусгай хамгаалалтаас гаргах хуулийн төслийг ирэх хоногт Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар төлөвлөж байна. Мөн Сэлбэ, Баянхошуу дэд төвд 20 мянга орчим айлын орон сууц барина. Уг хоёр байршилд газар чөлөөлж байна. Барилгын компаниудтай уян хатан байдлаар тохиролцоно. Ирэх долоо хоногт уг асуудлаар барилгын компаниудын төлөөлөлтэй дахин уулзалт зохион байгуулна” гэдгээ хэлэв. Уг арга хэмжээнд МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүд, Гишүүд, Ажлын албаны төлөөллүүд оролцож өөрсдийн байр суурыа илэрхийллээ.

МҮХАҮТ-ТАЙ ХАМТРАН ГАДААДЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ КВОТ, АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ХӨНГӨЛҮҮЛЭХ ТАЛААР ТАНХИМААР ДАМЖУУЛАН ТӨР ЗАСАГТ ДУУ ХООЛОЙГОО ХҮРГЭЛЭЭ



“Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин нь МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхантай санал солилцлоо. Тус хууль нь улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, гишүүдийнхээ болон гадаад дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор 1995 онд батлагдсан ч цаг үеийн нөхцөл байдлыг даган нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон талаар танилцууллаа.

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь: МБҮА ТББ-ын үйл ажиллагааг танилцуулаад барилгын салбарт үүсээд байгаа өнөөгийн нөхцөл байдал болоод барилгын салбарт сайн засаглалыг бий болгоход төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалахад мэргэжлийн төрийн бус байгууллагууд идэвх санаачилгатай оролцох, бизнес эрхлэгчид хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хамтын удирдлагын байгууллагаар дамжуулан дуу хоолойгоо төр болон олон нийтэд хүргэх нь чухал болохыг онцоллоо. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд гадаадын ажиллах хүчний квот, ажлын байрны төлбөр хураамжийг хөнгөлүүлэх талаар нийт бизнес эрхлэгчдийн хамт танхимаараа дамжуулан төр засагт дуу хоолойгоо хүргэснээр

асуудлыг нааштай шийднэ гэдэгт итгэлтэй байгааг дурдлаа. Цаашлаад ковид нөхцөл байдлын улмаас санхүүгийн хүндрэлтэй байгаа аж ахуйн нэгжүүдийг НӨАТ-ын татвараас чөлөөлөх асуудалд ч хамтын дуу хоолой чухал байгааг дурдсан юм.

МОНГОЛ УЛСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ КОМПАНИУД МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДТОЙ ХАМТРАХ БОЛОМЖТОЙ



БНХАУ-ын DHH LAW MONGOLIA ХХК нь АНУ, Канад, Япон зэрэг дэлхийн 12 улс оронд өөрийн салбар компанитай бөгөөд 2024.05.01-ны өдөр Монгол улсад салбар компани нээж “МОНГОЛ УЛС, БНХАУ ХОЁР ТАЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН” сэдэвт хэлэлцүүлгийг хууль болоод бизнесийн хүрээнийхний дунд хийлээ. Уг арга хэмжээний нээлтийн үеэр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь МБҮА ТББ-ыг танилцуулаад БНХАУ-ын DHH LAW MONGOLIA ХХК нь Монгол Улсад салбараа нээж, Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэхээр орж ирж байгаа нь зөвхөн Хятадын хөрөнгө оруулагч компаниудын ашиг сонирхлыг хамгаалаад зогсохгүй, Монголын эдийн засаг, Монголын компаниудад үр ашигтай байх, илүү мэргэжлийн суурь баталгаа болж байгаад бид баяртай байгаагаа илэрхийллээ. Мөн миний хувьд бизнесмэн хүн. Бизнесийн төслүүдтэй хамтраад ажиллаж байхад хөрөнгө оруулалт, гэрээ, бизнесийн хүндрэл, маргаантай асуудлууд олонтоо тохиолддог. Тиймээс Монгол улсад хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаагаа эрхлэх гэж байгаа Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд манайх шиг Мэргэжлийн холбоодын гишүүнээр элсэх, хамтран ажиллах замаар хөрөнгө оруулалтын орчныг илүү оновчтой, хууль эрх зүйн хүрээнд эрх ашиг нь хамгаалагдсан, төр болоод хувийн хэвшил, бизнесийн хүрээнд гүүр болох боломжтой юмаа гэдгийг онцоллоо.

МБҮА ТББ НЬ СЭЗИС-ТАЙ СУРГАЛТЫН ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО

МБҮА нь өөрийн гишүүн байгууллагуудын сургалт хөгжлийн эрэлт хэрэгцээг судлан тодорхойлох, СЭЗИС нь МБҮА-ийн гишүүн байгууллагуудын ажилтнуудад мэргэжлийн зэргийн болон богино хугацааны сертификат бүхий сургалтын хөтөлбөрүүдийг цахим болон танхимийн хэлбэрээр зохион байгуулж хамтран ажиллах хүрээнд МБҮА ТББ нь СЭЗИС-тай “ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ”-т гарын үсэг зурцгаалаа. Тус санамж бичгийн хүрээнд СЭЗИС-ийн үүсгэн байгуулсан өмгөөллийн “Легал Клиник ЮФИ” ХХК нь МБҮА-ийн үйл ажиллагааны дүрэм, эрх зүйн бусад баримт бичгүүдийг хууль дээдлэх зарчим, өрсөлдөх чадвар, тогтвортой хөгжил, гишүүдийн оролцоо, хариуцлагыг олон улсын түвшинд хүргэх зарчмын дагуу шинэчлэн боловсруулах ажлыг гэрээний дагуу гүйцэтгэх, Салбарын мэргэжилтнүүд, талуудын хүний нөөцийг чадавхжуулах, харилцан туршлага солилцох, хамтарсан сургалт, нээлттэй хэлэлцүүлэг, семинар, форум зохион байгуулах ажлыг хамтын хяналт, оролцоотой хэрэгжүүлэх, оюутнуудыг дадлагын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх практик, мэдлэг, ур чадвар, туршлага хуримтлуулах, эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хамтарч зах зээлийн судалгаа төсөл, хөтөлбөр, зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх, оюутны эрдэм шинжилгээний хурал, тэмцээн уралдаан, өдөрлөг хамтран зохион байгуулах, ивээн тэтгэх, нийгмийн хариуцлагын хүрээнд чиглэсэн ажлуудад оюутан суралцагчдыг идэвхтэй хамруулах олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх юм.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУДЫГ ХИЙВ



MNCA
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
SINCE 2009
15 anniversary

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ-ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД



+(976) 7011-1515
www.mnca.mn

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 500 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав. БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 1887 ААНБ-ын хүсэлт, материалыг баталгаажуулж, ХБҮОСЯ-нд цахимаар илгээв.





Огноо	Баталгаажуулалтын тоо	Дэмжигдсэн ААНБ-ын тоо	Нийт сунгалт	Нийт шинэ	Нийт нэмэлт	Дахин олгох	Барилга угсралт	Зураг төсөл	Өргөх байгууламж	БҮАТЗ Хүчингүй болгох
2024.12.13-ны байдлаар	49	1887	87	1253	520	27	1523	316	48	0

Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 1,887 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 12,154 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.

- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 40 удаа ХБҮОСЯ-нд хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газрын opendata.burtgel.gov.mn-д БУ: 4,256, ЗТ: 854, ӨБ: 160 ААНБ-ын нийт 5,270 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн www.mcis.gov.mn-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4,256, ЗТ: 854, ӨБ: 160 ААНБ-ын нийт 5,270 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 1,499, ЗТ: 305, ӨБ-48 ААНБ-ын мэдээллийг илгээв.
- ХБҮОС-ын Сайдын тушаалыг үндэслэн 1,884 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 1,767,000,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- Үйлчилгээний хөлсний 1,887 ААНБ-ын 1,125,010,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны
- 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.
- 2024.12.13-ны БХБ-ын Сайдын 48 удаагийн тушаалыг үндэслэн нийт 1852 үнэт цаасанд бичилт хийж баталгаажуул2024.12.13-ны өдрийн байдлаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

2019-2024 он хүртэлх тоон мэдээлэл

Огноо	Барилгын тусгай зөвшөөрөлтэй ААНБ	Барилга угсралт	Зураг төсөл	Өргөх байгууламж
2019	82	64	14	4
2020	852	769	62	21
2021	871	694	158	19
2022	963	714	220	29
2023	1228	988	195	45
2024	1259	1,027	205	42
Нийт	5,270	4,256	854	160





ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

ENERGY GLOBE AWARD 2023 (ДЭЛХИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ШАГНАЛ)-Д МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ДУЛААН ШИЙДЭЛ-1, 2 ТӨСӨЛ”-ИЙГ “ҮНДЭСНИЙ ЯЛАГЧ” ШАГНАЛ-ААР ШАГНАВ



Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод тулгарч буй болон МБҮА ТББ-ын нийгмийн хариуцлагын хүрээнд санаачилсан “АГААР, ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ” санаачилгын хүрээнд МБҮА ТББ нь Европын Холбооны тендерийн сонгон шалгаруулалтад оролцон шалгарч, санхүүжилтийг авснаар “ДУЛААН ШИЙДЭЛ-1 ТӨСӨЛ”-ийг Монгол Улс дахь Франц Улсын Жэрэс Монгол ОУТББ болон салбарын бусад түншлэгч байгууллагуудтай 2018-2022 онуудад хамтран амжилттай хэрэгжүүлэн дуусгаж, улмаар тус төсөл нь Европын Холбооноос тогтвортой хөгжлийн хүрээнд санхүүжүүлж буй Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид (БЖБЭ)-ийн үйлдвэрлэл болон хэрэглээг дэмжих зорилт бүхий SWITCH-ASIA хөтөлбөрийн “ШИЛДЭГ БИЗНЕС ЗАГВАРЧЛАЛ”-тай төслөөр 2020 онд шалгарч, 2021 онд Европын Холбооноос эмхэтгэн гаргасан “ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭ БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТУРШЛАГЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БИЗНЕС КЭЙСҮҮД” товхимолд ШИЛДГЭЭР шалгарсан төслөөр нийтлэгдсэн билээ. Иймээс МБҮА ТББ нь төслийн түншлэгч байгууллагуудтайгаа хамтран ТӨСЛИЙН II дахь үе шатыг хэрэгжүүлэх эрмэлзэлтэйгээр төслийн дараагийн саналыг боловсруулж, Европын Холбооны тендерийн сонгон шалгаруулалтад дахин 2021 онд оролцон шалгарч, санхүүжилтийг авснаар “ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛ”-ийг 2022-2026 онуудад хэрэгжүүлж эхэлсэн болно. Австри Улсад төвтэй Energy Globe Сан нь Дэлхийн 180 гаруй орноос жил бүр эрчим хүчний хэмнэлт, тогтвортой байдал, сэргээгдэх эрчим хүч, байгаль орчны асуудлыг шийдвэрлэсэн төслүүдийг үнэлж, сонгон шалгаруулан тодруулдаг зорилготой бөгөөд энэ удаагийн ENERGY GLOBE AWARD 2023 (Дэлхийн Эрчим Хүчний Шагнал)-д МОНГОЛ УЛСАД хэрэгжүүлж буй “ДУЛААН ШИЙДЭЛ-1, 2 ТӨСӨЛ”-ийг “ҮНДЭСНИЙ ЯЛАГЧ” ШАГНАЛ-аар шагнав. https://www.energyglobe.com/awards/national/winners


“ТУХТАЙ АМЬДРАЛ-ДУЛААН ГЭР-2024 ТӨСӨЛ” ШАЛГАРЛАА



Бодь Интернэшнл ХХК (Бодь Групп)-иас “Компанийн нийгмийн хариуцлага”-ын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, бүс нутгийн хөгжил, байгаль орчин гэсэн 4 салбарт нэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах зорилготой зарласан сонгон шалгаруулалтад МБҮА ТББ нь байгууллагын нийгмийн хариуцлага болон улс эх оронд тулгараад буй нийгмийн асуудлын хүрээнд “ТУХТАЙ АМЬДРАЛ-ДУЛААН ГЭР-2024 ТӨСӨЛ”-ийн саналыг боловсруулж, тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд нэн хэрэгцээтэй байгаа санхүүжилтийг олгож, хамтран шийдвэрлэж ажиллах хүсэлтийг илгээв. МБҮА ТББ-ын Төслийн нэгжийн хамтран хэрэгжүүлдэг “Дулаан шийдэл-2 төсөл” нь Барилгын бригадууд, бичил, жижиг бизнес эрхлэгчид

(БЖБЭ)-ийг дулаалгын технологийн болон бусад холбогдох сургалтуудаар дамжуулан шаардлагатай мэдлэг боловсролыг эзэмшүүлэн, чадавхжуулдаг ба Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийн байшинг дулаалах, мэргэжлийн чадварлаг ажиллах хүчнийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн нийлүүлдэг юм. МБҮА ТББ нь “Дулаан шийдэл төсөл”-ийг санаачлан Европын Холбооны санхүүжилттэй төслийн сонгон шалгаруулалтад оролцон шалгарч, 2018 оноос хойш уг төслийг төслийн бусад түншлэгч байгууллагуудтай хамтран амжилттай хэрэгжүүлж байна. Тус төслийн санал богино жагсаалтад багтаж, 2024.0.5.03-нд тендерийн сонгон шалгаруулалтын багт төслөө танилцууллаа. Уг төсөл нь хүлэмжийн хийн ялгарал, агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмрийг оруулж, байгаль орчноо хамгаалах, иргэдийн, тэр дундаа хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, нүүрсний зарцуулалтыг бууруулснаар айл өрхийн эдийн засагт эерэгээр нөлөөлөх, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилготой. Өөрөөр хэлбэл, "Дулаан шийдэл-1, 2 төсөл"-ийг хамтран хэрэгжүүлж ирсэн туршлагадаа тулгуурлан, Улаанбаатар хотын 3 дүүргийн зорилтот бүлгийн нийт 3 айлд бүтэн дулаалга хийх замаар дээрх зорилгодоо хүрэхээр Бодь пропертиз ХХК-тай хамтран ажиллахаар харилцан тохиролцов.

“БАРИЛГЫН АЖИЛ”-ЫН ЦАХИМ СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ ДУУСАЖ АШИГЛАЛТАД ОРЛОО



“Барилгын ажил”-ын цахим системийн хөгжүүлэлт өндөрлөж, бүрэн ашиглалтад өгөх туршилтын ажил дуусаж, ашиглалтад орлоо. Мөн системийн цаашдын үр өгөөж болон санхүүгийн дүн шинжилгээг хийлгүүлэх ажлын хүрээнд Гэрээт мэдээлэл технологийн зөвлөхийг ажиллуулж, цаашдын хөгжүүлэлт дээр төслийн багаас холбогдох саналыг авав. Мөн тус системийн хэрэглэгчид болох байгууллага, бригад, инженер, техникийн ажилтнуудын эрхээр туршилтаар нэвтэрч, шинэ бүртгэл, шинэ профайлыг үүсгэх, нууц үгийг сэргээх, мэдээ, зөвлөмжийг нийтлэх, системийн хандалтын тооны харагдах байдал зэрэг туршилтаар илэрсэн алдаа, дутагдлыг хөгжүүлэгч байгууллагад илгээж, засварлах ажлуудыг хийж дуусгав.

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ, МОНГОЛЫН НОГООН БАРИЛГЫН ХҮРЭЭЛЭН ТББ ХАМТРАН “НОГООН БАРИЛГА БА СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ” СЭДЭВТ ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙЛЭЭ



2024.04.08-нд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, Монголын ногоон барилгын хүрээлэн ТББ хамтран “Ногоон барилга ба сэргээгдэх эрчим хүч” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг өрнүүллээ. Хэлэлцүүлгээр “BestGer ногоон барилгын үнэлгээний систем, шалгуур үзүүлэлт”-ийг танилцуулж, “Барилгад тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх шаардлага, төрөөс баримтлах бодлого”-ын талаар асуудал хөндөв. Мөн ногоон барилга ба сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, “100 мянган нарны дээвэр” санаачилга, боломж ба сорилтын талаар талууд ярилцсан. Үр дүнд нь дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яамны хамтарсан Ажлын хэсэг байгуулагдаж, сэргээгдэх эрчим хүч тэр дундаа тархмал эх үүсвэрийн талаар Засгийн газар, холбогдох яамдад бодлогын зөвлөмж хүргүүлэхээр боллоо. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо чухал болохыг онцолсон юм.

ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСӨЛ 2024 ОНД 5 УДААГИЙН ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОЖ ОЛОН НИЙТЭД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАНИЛЦУУЛЛАА





2024.04.04-04.07-нд зохион байгуулагдсан "Улаанбаатар барилга экспо 2024" үзэсгэлэн худалдаанд, 2024.04.22-04.25-нд Төрийн банкнаас зохион байгуулсан “Тогтвортой хөгжил-ногоон ирээдүй” үзэсгэлэн худалдаанд, 2024.05.11-нд зохион байгуулагдсан Европын холбооны өдөрлөгт, 2024.05.16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “IREEE: Инновац, Сэргээгдэх эрчим хүч, Эрчим хүчний үр ашгийн олон улсын үзэсгэлэн, хуралд “Дулаан шийдэл-2 төсөл” үйл ажиллагаагаа танилцуулан оролцлоо. Уг үзэсгэлэн, хурлын үеэр иргэд, аж ахуйн нэгжүүдэд эрчим хүчний хэмнэлт, дулаалгын ач холбогдлыг танилцуулах зорилгоор төслийн баг дулаалгын зөвлөхүүдээ ажиллуулж 1000 гаруй иргэн, ААН-д мэдээлэл, зөвлөгөө өгч, байшингийн дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажил гүйцэтгэх захиалгууд авч, бизнесийн орлогоо нэмэгдүүлсэн болно.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ЗАГВАР СУУЦТАЙ ТАНИЛЦЛАА



Европын Холбооны Тайланд Улс дахь бүсийн төвийн Хамтын ажиллагааны дарга Даниел Хачэз-аар ахлуулсан төлөөлөгчид 2024.05.29-нд “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн нэвтрүүлээд буй загвар сууцтай танилцлаа. ШУТИС-ийн 5-р байрны гадна байрлах тэг эрчим хүч зарцуулах тус загвар сууц 2024.04-р сард ашиглалтад орж, нээлтээ хийсэн. Нээлтээ хийснээсээ хойш 500 гаруй дотоод, гадаадын зочид, төлөөлөгчид, олон нийтэд загвар сууцаа танилцуулаад буй. Энэ удаагийн төлөөлөгчдөд төслийг хамтран хэрэгжүүлэгчид болох Жэрэс ОУТББ нь төслийн үр дүнг танилцуулж, Барилгын эрчим хүч хэмнэлтийн төвийнхөн загвар сууцныхаа давуу талуудыг тайлбарлан, манай төслийн багийн хувьд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хэрхэн дэмждэг талаараа сонирхсон асуултуудад нь хариулсан юм.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙГЭЭР ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “НАЙРАМДАЛ” ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛОВ



Төсөл нь Дархан-Уул аймагт үйл ажиллагаагаа тэлж байгаатай холбогдуулан тус аймагт хэрэгжиж буй ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй төсөлтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлсний дагуу

Дархан-Уул аймагт үйл ажиллагаагаа явуулж буй ЕХ-ны санхүүжилттэй “Найрамдал төсөл” буюу аймгийн нийгэм-эдийн засгийн шинэлэг, тэгш, хүртээмжтэй тогтвортой өсөлтийг дэмжин, Европын Холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хэрэгжиж буй төсөлтэй тодорхой чиглэлүүдээр хамтран ажиллахаар болов. 2024.08.29-ний өдөр болсон уулзалтаар “Найрамдал төсөл” нь “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн Дархан-Уул аймаг дахь ББЖБЭ-ийн дунд зохион байгуулагдах элсэлт, сонгон шалгаруулалтын зарыг өөрсдийн сувгаар түгээх, чадавхжуулах сургалтуудын болон үдийн завсарлагыг зохион байгуулах танхимаар хангах зэргээр дэмжихээр болов.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН НЭЭЛТ ДАРХАН-УУЛ АЙМАГТ БОЛЛОО





Европын Холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн Хөндлөнгийн Зөвлөх Хорооны хурал 2024.10.23-нд Дархан-Уул аймагт зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хурлаар төслийг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд болон Дарханд хөндлөнгийн зөвлөх хороо байгуулах талаар хэлэлцэв. Хуралд Дархан-Уул аймгийн ЗДТГ болон Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Дархан-Уул аймгийн Барилгачдын холбоо, аймгийн Байгаль орчны газар, төслийн оролцогч талууд болон ижил төстэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд, олон улсын, төрийн байгууллагын төлөөлөл 40 орчим хүн оролцлоо. МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн баг нь 2024.09.13-10.06-ны хооронд Дархан-Уул аймгийн бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дунд нээлттэй элсэлтээ зарлаж, 2024.10.16-10.19-ны хооронд “Барилгын салбар дахь жендэрийн асуудал”, “Барилгын хог хаягдлын менежмент”, “Дулаалгын технологи”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт” гэсэн 4 төрлийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 114 бичил, жижиг бизнес эрхлэгчийг чадавхжуулж, 20 гаруй дулаалгын ажилтныг бэлтгэлээ. Мөн 2024.10.29-11.02-ны хооронд дараагийн ээлжийн багц сургалтаа зохион байгуулж, барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах Санамж бичиг байгуулан, эрчим хүчний хэмнэлт, дулаалгын зах зээлтэй холбохоор төлөвлөж байна. Мөн Дархан-Уул аймагт төслийг амжилттай хэрэгжүүлэхэд, орон нутгийн байгууллагуудын санаачилга, оролцоо, дэмжлэг, барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн идэвх, хичээл зүтгэл, айл өрхүүдийн дулаалгын эрэлт хэрэгцээ, аж ахуйн нэгжүүдийн ач холбогдол өгөх байдал гэх мэт чухал нөлөөтэйг хэллээ. Мөн Хялбар шийдэл аяны хүрээнд тус аймгийн Дархан сумын 1, 2, 3, 5, 6-р багт нийт 10-15 сургалт зохион байгуулах, 70 айлын дээврийг 5 см-аар дулаалах, 350 айл өрхөд хялбар шийдэл хэрэгжүүлэх, 30000 иргэнд мэдээлэл хүргэх зорилго тавин ажиллаж байгаа тухайгаа Монголын эмэгтэйчүүдийн сангийн Дулаан шийдэл II төслийн менежер Г.Гантулга ярилаа. Арга хэмжээний үеэр төслийн хүрээнд Дархан-Уул аймаг дахь Төслийн хөндлөнгийн зөвлөх хороог байгуулах, тус хороо нь төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүрэг хэрэгжүүлэхээр болсон юм.



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.6

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

БНХАУ БОЛОН МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН НЭГДСЭН БИЗНЕС ФОРУМ-ЫГ 2025 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД БЭЭЖИН ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛНА



БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (CHINCA)-ийн Ерөнхийлөгч Mr.Fang Qiuchen нь 2024.11.15-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Элчин сайдын яамны Худалдаа, эдийн засгийн төлөөлөгч Ц.Түмэнбаяр нарыг Бээжин хотноо хүлээн авч уулзлаа.

МБҮА ТББ нь 2010 оноос CHINCA-тай харилцаа тогтоож өнөөдрийг хүртэл хоёр улсын хувийн хэвшлийн барилгын аж ахуйн нэгжүүдийг холбох, хамтын ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд жил бүр тус байгууллагаас зохион байгуулалдаг “ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЭЦ, БАРИЛГЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ” форумд идэвхтэй оролцож байгаа билээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын ойрын төлөвлөгөөнд барилга, зам гүүр, дэд бүтцийн томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж их бүтээн байгуулалтын ажлууд ойрын жилүүдэд өрнөхөөр болоод байгаа нь хоёр орны хувийн хэвшлийн харилцааг өргөжүүлэх, Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай төслүүдэд хоёр улсын салбарын компаниудыг хамтран ажиллах, түншлэх боломжийг олгох, холбож өгөх үүднээс ирэх 2025 оны хавар Хятад, Монгол Улсын барилгын салбарын бизнес эрхлэгчдийн уулзалт, форумыг Бээжин хотноо зохион байгуулах боломжтой талаар МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан дурдсан юм. Мөн нэг талаар Монгол улсын барилга,үл хөдлөх хөрөнгийн төсөл хөгжүүлэгчдийн чадавх, төслийн хэмжээ зах зээлийн эрэлт хэрэгцээг дагаад сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаа бөгөөд нөгөө талаар төслүүдийг үр өгөөжтэй болгох, түүний дотор барилгын өртөгт нөлөөлж байдаг хүчин зүйлүүдийг бууруулах замаар хэрэглэгчдэд очдог орон сууцны үнийг бууруулж ингэснээр салбарын тогтвортой байдлыг хангах нь МБҮА ТББ-ын тэргүүлэх зорилтуудын нэг болохыг дурдаад энэ талаар БНХАУ-ын ижил төрлийн бизнес эрхлэгчидтэй, төслүүдэд хамтран ажиллах, хүний нөөцийн дутагдалтай байгаа салбарт тус улсад нэвтрүүлж эхлээд буй хүний оролцоог орлосон робот машин, хиймэл оюун ухааны технологи шингэсэн техник технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд харилцан хамтран ажиллах зэргээр хөрш улсынхаа хөгжлийн хурдтай хөл нийлүүлэн алхах боломжтой талаар ажил хэрэгч саналуудыг дэвшүүллээ.Түүнээс гадна аливаа том, жижиг төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд бизнесийн хамтрагчаа зөв сонгох нь хамгийн чухал шийдвэрүүдийн нэг бөгөөд энэ тал дээр хувийн хэвшлийн холбоод хамгийн үнэн зөв сайн мэдээлэлтэй байдаг тул бидний хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг эрсдэлгүй хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэйг онцоллоо.

Мөн Монгол Улсын барилгын салбарын бараа бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлж байгаа тээврийн саатал, хүндрэлүүдийг арилгахад Замын-Үүдийн чөлөөт бүсэд хамтарсан “БАРИЛГА-ДЭД БҮТЦИЙН ТЕРМИНАЛ” байгуулах төсөл дээр хамтран ажиллах боломжийн талаар санал солилцлоо.

БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (CHINCA)-ийн Ерөнхийлөгч Mr.Fang Qiuchen нь дээрх дэвшүүлсэн саналуудыг бүрэн дүүрэн дэмжиж ажил хэрэг болгох нь зүйтэйг илэрхийлээд 2025 оны эхний улиралд буюу Монголын барилгын ажлын улирал эхлэхээс өмнө хоёр талын бизнес форумыг Бээжин хотноо зохион байгуулахад хамтран ажиллах, БНХАУ-ын Засгийн газар болон Хятадаас жил бүр дэлхийн аль нэг улсад зохион байгуулдаг “CHINA CONSTRUCTION EXPO - 2025”-ыг Монгол улсад ирэх намар зохион байгуулахаар тогтсон ба уг арга хэмжээг Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийллээ.Мөн хоёр тал МБҮА ТББ-ын дэргэд АРБИРТ байгуулсантай холбогдож CHINCA-ийн дэргэдэх ЭВЛЭРҮҮЛЭН

ЗУУЧЛАХ (Mediation center) төвтэй хамтран ажиллахаар тохиролцсон ба уулзалтад БНХАУ-ын CHINCA-гийн Ерөнхийлөгч FANG Qiuchen, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, хуралдаан, экспо хариуцсан захирал XU Guolei, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Төслийн гэрээ, хөрөнгө оруулалтын газрын захирал SU Jianguo, Хуралдаан, экспо хариуцсан ажилтан ZHANG Lingqing нар оролцлоо.

ХЯТАДЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН НИЙГЭМЛЭГ (CHINCA) НЬ 1988 БАЙГУУЛАГДСАН

- Тус байгууллага байгуулагдсан цагаасаа хойш гишүүдийнхээ дуу хоолойг хүргэх, салбарын хэмжээнд хариуцлага, сахилга батыг бэхжүүлэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үүргээ идэвхтэй биелүүлж, гишүүдийн хөгжлийг дэмжиж, Хятадын олон улсын хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг хувь нэмэр оруулахыг зорьж ирсэн.
- Өдгөө CHINCA нь 1300 гаруй гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 1000 гаруй нь олон улсын төслийн инженерчлэл, гэрээ хэлэлцээр, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд салбарын нийт үйлдвэрлэлийн 90 орчим хувийг эзэлж, 190 гаруй улс орон, бүс нутагт түгээдэг.
- Олон жилийн турш CHINCA-ийн 60 гаруй гишүүд ENR (Engineering News-Record)-ийн шилдэг 250 олон улсын гэрээлэгчдийн жагсаалтад орж байгаа, мөн Fortune Global 500-д хэд хэдэн гол гишүүд багтсан.
- CHINCA-ийн гишүүд тээвэр, эрчим хүч, цахилгаан дулаан, орон сууц, нефтийн химийн үйлдвэр, харилцаа холбоо, ус, аж үйлдвэр, үйлдвэрлэлийн барилгын салбарт янз бүрийн төслүүдийг хэрэгжүүлсэн.

БНХАУ-Д УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД Н.ЭНХБОЛД МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРСАЙХАНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

БНХАУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Н.Энхболд болон Худалдаа, эдийн засгийн зөвлөх Ц.Түмэнбаяр нар МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайханыг 2024.11.13-ны өдөр Бээжин хотноо хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр Монгол Улс болон БНХАУ-ын барилга бүтээн байгуулалтын салбарын хамтын ажиллагаа, түүний дотор хоёр орны хувийн хэвшлийн харилцааг өргөжүүлэхэд Элчин сайдын зүгээс ямар дэмжлэг үзүүлж болох талаар харилцан санал солилцлоо.

Уулзалтын үеэр элчин сайд:

-Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө



оруулалттай төслүүдэд хоёр улсын компаниудыг хамтран ажиллахад бүх талаар дэмжлэг үзүүлэх, холбож өгөх, МБҮА нь 2025 оны хавар Хятад, Монгол Улсын барилгын салбарын бизнес эрхлэгчдийн уулзалтыг зохион байгуулахад хамтран ажиллах, уулзалтын байр танхимаар хангахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

Мөн Худалдаа, эдийн засгийн зөвлөх Ц.Түмэнбаярын зүгээс БНХАУ-ын хөгжлийн хурдтай манай улсын бүх салбарынхан хөл нийлүүлэн алхах боломжтойг дурдаад ялангуяа шинэ технологи, инновацийн чиглэлээр хамтран ажиллах, барилгын салбарт хүний оролцоог хэмнэсэн роботууд, хиймэл оюун ухаанд суурилсан шинэ техникүүд, шинэ технологиудыг нэвтрүүлэх, энэ чиглэлийн компаниудыг холбож өгөх боломжтой талаар дурдлаа.

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайханыг Хятадын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (China International Contractors Association (CHINCA)-ийн Ерөнхийлөгч Mr.Fang Qiuchen 2024.11.15-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо хүлээн авч уулзах бөгөөд Элчин сайдын яамыг төлөөлж Худалдаа, эдийн засгийн төлөөлөгч Ц.Түмэнбаяр хамт оролцох юм.

CHINCA-ИЙН “ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГЫН ХҮ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО



Хятадын Олон Улсын Гэрээт Гүйцэтгэгчдийн холбоо (CHINCA) болон Макаогийн Худалдаа, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хүрээлэн (IPIM) хамтран зохион байгуулдаг “Олон улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, барилгын XV удаагийн чуулга уулзалт (IIICF) 2024.06.19-21-ны өдрүүдэд Макао хотноо болж өнгөрлөө. Энэ удаагийн чуулганд 70 гаруй орны 800 гаруй байгууллагын төлөөлөл болох 3500 гаруй төлөөлөгчид оролцлоо. ***Чуулган “Ногоон инноваци болон салбарын цахимжуулалт” сэдвийн хүрээнд явагдсан ба дараах сэдвүүдээр 200 гаруй илтгэл тавигдан яриа хэлэлцээ өрнүүлж санал солилцов.***

- Сэргээгдэх эрчим хүчний технологийг тэргүүн эгнээнд тавьж, байгаль дэлхийд ээлтэй цэвэр эрчим хүч, ногоон барилгын туршлага, эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологи, материалын судалгаа инноваци шийдлүүд болон ухаалаг хотыг амжилттай хэрэгжүүлж буй хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт шийдлүүд
- Барилгын автоматжуулалт, BIM, робот технологи, ухаалаг мэдрэгч, хяналтын төхөөрөмж, цаг агаарын урьдчилан сэргийлэх болон байгаль хамгаалах ухаалаг систем, бие даасан жолоодлогын технологи, угсармал барилгын шинэ инженерийн шийдлүүд
- Олон улсын инженерийн төслүүдэд дижитал дэд бүтцийн шийдлүүд болон том өгөгдөл, үүлэн тооцоолол, цахим сүлжээний цогц хэрэглээ, төслийн менежмент, хот байгуулалтын дижитал өөрчлөлтийн хамгийн сүүлийн үеийн туршлагуудын талаар онцолж байсан юм.

Уг чуулганы бас нэг гол сэдэв бол бүтээн байгуулалтын ажлуудад гарч буй маргааныг Олон улсад идэвхтэй хөгжиж байгаа шүүхийн бус аргаар шийдвэрлэх тогтолцооны хөгжил, маргааны төрлүүд болон шийдвэрлэгдэж буй маргааны талаарх судалгааны талаар байсан бөгөөд Хятадын Олон Улсын Гэрээт Гүйцэтгэгчдийн Холбоо (CHINCA)-ны дэргэд “Маргаан Шийдвэрлэх Төв”-ийг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлснийг албан ёсоор зарлалаа. Олон Улсын Холбоодын нэгдсэн чуулганы үеэр МБҮА ТББ-ын 2023-2024 оны үйл ажиллагаанд олон улсын хамтын ажиллагаа, ногоон хөгжил, цахим шилжилт болон хууль эрх зүйн хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Д.Баасансүрэн танилцууллаа. Цаашид ногоон хөгжил, ажиллах хүчний чадавхжуулалт, сургалт, цахим шилжилт, барилгын автоматжуулалтын талаар нягт хамтран ажиллах, бүх холбоодын хамтын ажиллагаа, мэдээллийн нэгдсэн платформ байгуулан ажиллах саналуудыг тавьсан ба бусад холбоодын зүгээс бидний саналыг дэмжин ажиллахаа илэрхийлэв. Түүнээс гадна Олон Улсын Төслийн Менежментийн Холбоо, Итгэмжлэгдсэн Барилгын Инженерийн Институт, Сингапурын Олон улсын Эвлэрүүлэн зуучлалын Төвийн төлөөлөгчидтэй уулзан ярилцаж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцоо.

МБҮА ТББ-ЫН ТӨЛӨӨЛӨЛ КАНАД УЛСАД АЙЛЧИЛЛАА


Канад Улсын барилгын хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж, технологитой танилцах, ханган нийлүүлэгчдтэй харилцаа холбоог тогтоох, салбарын хамтын ажиллагаагаа сайжруулах, шинэчлэгдэн өөрчлөгдөж буй бетоны талаарх мэдээ, мэдээллийг авах “Барилгын болон бетоны үзэсгэлэн яармаг 2024”-т нийт 8,000 гаруй салбарын ААНБ-ууд оролцон өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг болон салбарын дэвшилтэт технологийн талаарх илтгэлүүдийг танилцуулсан, 2024.02.14-18-ны хооронд Торонто хотноо зохион байгуулагдсан үзэсгэлэнд БХБ-ын Сайд Ц.Даваасүрэнгээр ахлуулсан тус яамны удирдлагууд, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, ШУТИС-ын Барилга,

архитекторын сургууль, Монголын Бетоны Холбоо ТББ, МБҮА ТББ, Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо ТББ зэрэг төлөөллөөс бүрдсэн бүрэлдэхүүн нь оролцов. Айлчлалын үеэр Канадын Хүртээмжтэй Байдлын Холбоо, АНУ-ын Бетоны Холбоо, Бетон Шалны Гүйцэтгэгчдийн Холбоо, Бетон Хөрөөдөх, Өрөмдлөгийн Холбоо, Шилэн Хуванцар, Төмөр Бетоны Холбоо, Бэсис Уатэрпроофинг Супплай буюу барилгын эд анги, байгууламжийг хамгаалах, байгаль орчинд ээлтэй, нөөцийг хэмнэсэн бүтээгдэхүүний шинэлэг систем боловсруулах компани болон Засгийн газарт салбарын зах зээлд тэргүүлэгч шийдлүүдийг танилцуулдаг Сэйф смарт Аксэсс компани, төслийн удирдлага, бүтэц, механик, цахилгаан, барилгын инженерийн үйлчилгээгээр инженерийн зөвлөгөөг өгдөг Кю Инженеринг Эверсэйф Координатс компаниудтай уулзаж, харилцаа холбоог тогтоов. Тус айлчлалын үеэр Канадын барилга, бетоны салбарын тэргүүлэх хоёр технологийн компаниудаар зочилсноос:

SOLARWALL: Канадын Solarwall технологи нь барилгын гаднах фасадаар нарны дулааны эрчим хүчийг хуримтлуулж, тухайн барилгынхаа дулаан болон агаар сэлгэлтийг шийддэг, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг дэлхийд нэвтрүүлэх зорилготой юм. Уг нарны фасадын технологи нь ямар ч төрлийн барилгуудад суурилуулж болох бөгөөд барилгын дулаан, эрчим хүчний зардлыг хэмнэх шийдэлтэй юм. Conserval нь арилжааны болон үйлдвэрлэлийн салбарт нарны дулааны халаагуурыг анх хөгжүүлж танилцуулсан компани бөгөөд тэдний бүтээсэн SolarWall технологи нь АНУ-ын Эрчим хүчний яам, Канадын Ашигт малтмалын яам болон Америкийн Механик Инженерүүдийн Нийгэмлэгээс эрчим хүчний шилдэг шинэ бүтээлүүдийн нэгээр итгэмжлэгдэн шалгарсан билээ. SolarWall технологи нь барилгын төсөл бүрд тусгайлан хийгддэг ба уг барилгын зураг болон халаалт, агааржуулалтын системд зохицсон шийдлийг санал болгодог. 40 гаруй орны олон мянган үйлчлүүлэгчдэд уур амьсгалын өөрчлөлтийн зорилтуудаа биелүүлэх болон нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулахад нь туслан хувь нэмэр оруулж байгаа билээ. Түүнчлэн, тус компани Монгол Улсад өөрийн салбарыг нээсэн бөгөөд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх Захирал Л. Хулан цаашид тус компанитай хамтран ажиллаж тус дэвшилтэт технологийг сурталчлан таниулах тал дээр хамтран ажиллахаар боллоо.

ENERSION:Мөн айлчлалын үеэр Enersion хөргөлтийн систем үйлдвэрлэгч компани (нарны эрчим хүч, био хий, сэргээгдэх байгалийн хий)-ийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд тус компани нь хөргөлтийн хэрэглээнд өнгөц шингээх шинэ технологийг нээсэн байна. Өөрөөр хэлбэл, хуучирсан, бохирдуулагч ихтэй, эрчим хүч их шаарддаг технологиос эрчим хүчний хэмнэлттэй, хорт утаа ялгаруулдаггүй хөргөлтийн технологийг 4 жилийн судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд эрчим хүчний 3 салшгүй эх үүсвэр болох *хөргөлт, халаалт, цахилгааныг нэгтгэсэн* бүтээгдэхүүнийг бүтээжээ. Уг гуравласан систем нь ногоон эрчим хүчний ирээдүй бөгөөд чичиргээгүй, эрчим хүчний хэрэглээг 70 хүртэлх хувь хэмнэх бөгөөд тус компанийн хөргөх технологийг Монгол Улсад, нэн ялангуяа говийн аймгуудад тохиромжтой байгаагаараа онцлог байв. Уг айлчлалын үр дүнд тус компаниудын технологийг Монгол Улсад нэвтрүүлэх, нутагшуулах хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс дахь Канад Улсын Элчин Сайдын Яамтай хамтран “Эрчим хүчний хэмнэлтийн форум”-ыг 2024.06-р сард зохион байгуулахаар тохиролцов.

ФИДИК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ДОКТОР НЕЛСОН ОГУНШАКИН, УКРАИН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД САЙД БА ОРОН НУТАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН САЙД ОЛЕКСАНДР КУБРАКОВ НАР ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



ФИДИК-ийн Гүйцэтгэх захирал, Доктор Нелсон Огуншакин, Украин Улсын Сэргээн босголтын асуудал эрхэлсэн Дэд сайд ба Орон нутаг, дэд бүтцийн хөгжлийн асуудал

эрхэлсэн Сайд Олександр Кубраков нар гэрээнд гарын үсэг зурах үеэрээ Украин Улсын Засгийн газар болон ФИДИК-ийн хоорондын байгуулсан “Хамтын ажиллагааны шинэ гэрээ” нь тус улсын сэргээн босголтод туслахад чиглэгдсэн юм. ФИДИК нь Украин Улсын Орон нутаг, дэд бүтцийн хөгжлийн яамтай тус орны сэргээн босголт, төслийн хэрэгжилт болон Худалдан авалтын үйл ажиллагаанд шинэчлэлийг хийх зорилгоор 2024.01.19-ний өдөр ФИДИК болон Украйн Улсын холбогдох яамны төлөөллүүд нь Дэлхийн банкны төлөөлөгчийг байлцуулан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсгийг зурсан ба талуудын хооронд хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллах боломжуудыг бий болгож байна. Үүнд:

- Талууд нь Украйнд хэрэгжиж буй ОУСБ-ын хамтарсан дэд бүтцийн төслүүдийн хүрээнд ФИДИК-ийн гэрээ болон гэрээний удирдлагад ФИДИК-ийн алтан зарчмуудыг ашиглах
- ОУСБ-ын хамтарсан дэд бүтцийн төслүүдийг Украинд хэрэгжүүлэхийн хүрээнд тус улсын холбогдох байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах
- Украин дахь мэргэжлийн инженерүүдийн ур чадварыг чадавхжуулах, дотоодын зах зээлд төслийн менежментийг нэмэгдүүлэх
- ФИДИК -ийн дүрэм, бодлогод нийцүүлэн Украины тусгай нөхцөлүүдийг боловсруулах

ФИДИК -ийн чанар, бүрэн бүтэн байдал, тогтвортой байдлын үндсэн үнэт зүйлсийн дагуу Украины дэд бүтцийн мэргэжилтнүүд болон тэдний олон улсын мэргэжил нэгтнүүдийн хооронд ярилцах, хамтран ажиллах, шилдэг туршлагын мэдээллийг солилцох боломжийг судлах зэрэг болно. Уг арга хэмжээний үеэр FIDIC-ийн Гүйцэтгэх захирал, Доктор Нелсон Огуншакин нь: “5 жилийн хугацаатай энэхүү гэрээнд гарын үсэг зурсан нь ФИДИК-ийн хувьд чухал мөч бөгөөд бид Украины Сэргээн босголтын яам, Нийгэмлэгийн яамтай хамтран ажиллаж байгаадаа баяртай байна. Украины нутаг дэвсгэр, дэд бүтцийн хөгжил, эвдэрсэн дэд бүтцээ сэргээн босгох ажилд нь тусалж, Украин болон олон улсын хэмжээнд байгаа хамгийн сайн мэргэжлийн инженерүүд, төслийн менежментийн чадавхыг ашиглан хүчирхэг тогтолцоог бүрдүүлэхэд нь туслах болно. Энэхүү хамтын ажиллагааны гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлсэн Дэлхийн банк-нд бас талархаж байна. Хэлэлцээрт гарын үсэг зурах үеэр Украины сэргээн босголтын асуудал эрхэлсэн Дэд сайд, Украины нийгэмлэг, нутаг дэвсгэр, дэд бүтцийн хөгжлийн асуудал эрхэлсэн Сайд Александр Кубраков нь: “Бид ФИДИК-тэй хамтран ажиллаж, энэхүү гэрээнд гарын үсэг зурсандаа баяртай байна. ОХУ-ын түрэмгийллийн эсрэг ФИДИК-ээс Украинд дэмжлэг үзүүлсэнд талархаж байгаа бөгөөд энэхүү хэлэлцээрийн хүрээнд санал болгож буй мэдээлэл, туршлага солилцох нь Украины цаашдын үйл ажиллагаанд тус дөхөм болж, Украин дахь ОУСБ-ын төслүүдийн хүрээнд өндөр чанартай төслүүдийг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна” гэдгээ уламжлав.

ЖЕНЕВ ХОТНОО 2024.09.08-10-НЫ ӨДРҮҮДЭД ФИДИК-ИЙН 2024 ОНЫ ДЭЛХИЙН ДЭД БҮТЦИЙН ЧУУЛГАНААР ДЭЛХИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨӨЛЛҮҮД ЧУУЛЛАА



Швейцарын Женев хотноо 2024.09.08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдах ФИДИК-ийн 2024 оны дэлхийн дэд бүтцийн чуулганаар дэлхийн инженерчлэл, барилга байгууламж, дэд бүтцийн салбарын төлөөллүүд цугларч, салбарын өмнө тулгарч буй гол асуудал, боломжуудын талаар хоорондоо санал бодлоо хуваалцан чууллаа. Өнгөрсөн 2023 онд ФИДИК нь Сингапур Улсад дэлхийн зах зээл, зээлийн хүүгийн өсөлтийг бууруулж инфляцийг удаашруулах, өсөлтийг дэмжих тал дээр илүү их анхаарлыг хандуулсан талаар асуудлыг дэвшүүлсэн ба энэ нь дэд бүтцийн салбарт сайнаар нөлөөлсөн болно. Дэлхий даяар тогтвортой бөгөөд үр ашигтай дэд бүтцийг бий болгох шаардлагатай байгаа өнөөгийн нийгэмд энэхүү чуулган нь

цагаа олсон чухал арга хэмжээнд тооцогдов. Тус Чуулганд Олон Улсын Зөвлөх Инженерийн фирмүүд, Гэрээлэгч нар, Засгийн газар болон иргэний нийгмийн төлөөллүүд, Олон улсын санхүүгийн байгууллагууд, салбарын тэргүүлэгчид болон шийдвэр гаргагч нар цугларах юм. Улс орнуудын Засгийн газар болон санхүүжүүлэгчид нь дэд бүтцийг эдийн засаг болон эрүүл амьдрах нөхцөлд чухал үндэс, нөлөө үзүүлдэг гэж үздэг тул үүнийг хэрэгжүүлдэг инженер, барилгын мэргэжилтнүүдэд ихээхэн үүрэг хариуцлага, шаардлагыг тавьдаг билээ. Тиймээс ФИДИК-ийн жил бүрийн зохион байгуулдаг Тэргүүлэгч бага хурал нь дэд бүтцийн салбарын хувьд маш чухал арга хэмжээнүүдийн нэг билээ. ФИДИК-ийн дэлхийн дэд бүтцийн чуулган нь 2050 он хүртэл 139 их наяд ам.долларын хөрөнгө оруулалтыг хийх чадвар, нөөц бололцоотой дэд бүтцийн салбарынхныг цуглуулдаг томоохон байгууллага болно.


МАЛАЙЗЫН МАСТЕР БАРИЛГАЧДЫН ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТАД СУУСАН МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД СЕРТИФИКАТТАЙ БОЛЛОО


MBAM
MASTER BUILDERS ASSOCIATION MALAYSIA
PERSATUAN KONTRAKTOR BINAAN MALAYSIA
E-Certificate of Attendance
is presented to
BATCHIMEG ONON
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
For attending the
MBAM Contract Admin Programme – Session 3
The Trouble with Building Defects
New Trouble beyond Delay and Quantum Disputes
'Losing more than your Pants'
Held on 11 September 2024, Wednesday (5pm – 7 pm)
Organised by MBAM Contracts & Practices Committee
This e-certificate is issued by MBAM and authorised by
Ir Anthony Teoh
Chairman of Contracts & Practices Committee


MBAM
MASTER BUILDERS ASSOCIATION MALAYSIA
PERSATUAN KONTRAKTOR BINAAN MALAYSIA
E-Certificate of Attendance
is presented to
BYAMBAA SARANCHIMEG
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
For attending the
MBAM Contract Admin Programme – Session 3
The Trouble with Building Defects
New Trouble beyond Delay and Quantum Disputes
'Losing more than your Pants'
Held on 11 September 2024, Wednesday (5pm – 7 pm)
Organised by MBAM Contracts & Practices Committee
This e-certificate is issued by MBAM and authorised by
Ir Anthony Teoh
Chairman of Contracts & Practices Committee

Малайзын Мастер Барилгачдын Холбоо (MBAM)-ноос 2024.09.11-ны өдөр зохион байгуулсан “Барилгын гологдлоос үүдсэн асуудал, хугацаа хойшолт ба тоо хэмжээний маргааны асуудал” сэдэвт сургалтад МБҮА ТББ-ын УЗГ Эс Ди инженеринг энд констракшн ХХК-ийн захирал Б.Баасансүрэн, МБҮА ТББ-ын Ажлын албаны менежер Б.Саранчимэг, МБҮА ТББ-ын гишүүн Эм Си Эс проперти ХХК-ийн барилга хариуцсан Дэд захирал Г.Эрдэнэбаатар, гэрээ, төсөв хариуцсан Дэд захирал О.Батчимэг, төслийн хяналт хариуцсан Дэд захирал Г.Молор-Эрдэнэ, Инженерингийн албаны дарга С.Чинзориг нар оролцлоо. Энэхүү сургалтаар барилгын гологдол гэж юу вэ, яагаад гологдол гардаг, үүнээс үүдэж ямар үр дагавар гардаг талаарх мэдээллийг Малайз Улсын жишээгээр тайлбарлаж, дүн шинжилгээ хийж улмаар оролцогчдод сертификат гардууллаа. Мөн МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудын төлөөлөгчдийг сургалтад оролцох боломж олгож, сертификат ирүүлсэнд талархал илэрхийлж и-мэйлийг Х.Фарах Алиагаар дамжуулан илгээв. Дашрамд хэлэхэд энэхүү цуврал сургалтууд нь МБҮА ТББ-ын бүх гишүүдэд нээлттэй, үнэ төлбөргүй бөгөөд өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэхэд чухал хэрэгтэй гэдгийг онцлох байна.

ШИНЖЭЭЧ МЭРГЭЖИЛТНИЙ НОТОЛГООГ АШИГЛАХ НЬ МЭДЛЭГИЙГ ӨГЛӨӨ



Мөн Малайзын Мастер Барилгачдын Холбоо (MBAM)-ноос 2024.09.24-ний өдөр зохион байгуулсан “Шинжээч мэргэжилтний нотолгоог ашиглах нь” онлайн сургалтад МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Эс Ди инженеринг энд констракшн ХХК-ийн захирал Б.Баасансүрэн, МБҮА ТББ-ын Ажлын албаны менежер Б.Саранчимэг, МБҮА ТББ-ын гишүүн Эм Си Эс проперти ХХК-ийн гэрээ, төсөв хариуцсан Дэд захирал О.Батчимэг, Бодь Интернэйшнл ХХК-ийн Барилгын чанарын инженер Г.Цэвэгдорж нар оролцлоо. Сургалтаар шинжээч, мэргэжилтний нотолгоо нь бодит баримтаар хангах боломжгүй “санал”-ыг танилцуулахад баримт нотолгоо болгон ашигладаг ч шинжээч мэргэжилтэн нь шинжээчид нь баримт бий болгодоггүй, харин дүгнэлт гаргахын тулд баримтыг боловсруулдаг гэдгийг анхаарах нь зүйтэй, шинжээч мэргэжилтэн гэж хэн бэ, түүнийг хэрхэн сонгох талаарх мэдээллийг авлаа. Улмаар сургалтаас олж авсан мэдлэгээ үйл ажиллагаандаа хэрэглээд явах нь Монголын

барилгын салбарынханд ихээхэн тус дэм болохыг дурдсан юм.

ОЛОН УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ БАРИЛГЫН САЛБАРТ ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИТОЙ ТАНИЛЦАХ БИЗНЕС АЯЛЛЫН КАЛЕНДАРЫГ ГАРГАЛАА

МБҮА ТББ-ын Ажлын алба нь Олон Улсад зохион байгуулагдаж буй барилгын салбарт шинэ техник, технологитой танилцах бизнес аяллыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд энэ удаад дараах бизнес аяллуудын хуваарийн дагуу зохион байгуулахаар ажиллаж байна.



Үүнд:
2024.12.04-12.06-ны өдрүүдэд, Канад Улс, Торонто хот, Метро Торонто Конвэйншн төвд зохион байгуулагдах **THE BUILDING SHOW** Энэхүү арга хэмжээ нь “Канадын барилгын салбарын өнцөг булан бүрт нэвтрэх боломж” уриан дор 2-5 хоногийн хугацаанд нэг тасалбараар дөрвөн арга хэмжээг үзэж сонирхох боломжийг танд олгоно. Үзэсгэлэн яармагт дэлхийн өнцөг бүрээс барилгын зураг төсөл, архитектур, барилга, сэргээн засварлалт, үл хөдлөх хөрөнгийн мэргэжилтнүүд, ханган нийлүүлэгчид хүрэлцэн ирж туршлага хуваалцана. Үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдах семинар, сургалт, дугуй ширээний уулзалтад оролцсоноор “үргэлжлүүлэн суралцсан кредит” цуглуулах боломжтой. Барилгын салбарт 2 жилд нэг удаа зохион байгуулагддаг Архитектур, материал, системийн дэлхийн тэргүүлэгч үзэсгэлэн



гэгддэг **BAU 2025 (БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЗЭСГЭЛЭН)** нь 2025.01.13-17-ны өдрүүдэд, Герман улс, Мюнхен хотод зохион байгуулагдана. Тус үзэсгэлэнгийн үеэр нь барилгын салбар гарч буй шинэлэг санаа, дэвшилтэт технологи, материалыг бодит амьдрал дээр мэдрэх боломжийг олгож, ирээдүйн барилгын шилдгүүдийг нийт 18 танхим, 200.000 м2 талбайд ойролцоогоо 49 орны 2200 гаруй компаниуд шинэлэг бүтээгдхүүн, дэвшилтэт техник технилогиудаа танилцуулахаас гадна үндсэн 5 сэдвийг хамарсан уулзалт хэлэлцүүлэг болон биечилсэн уулзалтыг зохион байгуулагдахаар байна.
Үзэсгэлэнгийн агуулга: Архитектурын үйлчилгээ, барилгын засвар үйлчилгээ, барилгын менежмент, барилгын аюулгүй байдал, барилгын төлөвлөлт, зөвлөгөө, шал, дулаалга, дулаалгын материал, интерьер дизайн, барилгын материал, төслийн менежмент, төсөл төлөвлөлт, нарны хавтан, смарт технологи.


МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД ХБНГУ-ын БАВААРИ МУЖИД ЗОХИОН БАЙГУУЛСАН “ХОТЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, УС ХАДГАЛАЛТ”-ЫН ЧИГЛЭЛЭЭР ТЕХНИКИЙН СУРГАЛТАД ОРОЛЦЛОО

ХБНГУ-ын Баваари мужийн БАВААРИЙН БИЗНЕСИЙН ХОЛБОО-ны “БИ БИ ВИ ИНТЕРНЕШНЛ” (BBW) сургалтын байгууллагаас 2024.10.19-26-ны өдрүүдэд



“ХОТЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, УС ХАДГАЛАЛТ"-ын олон улсын техникийн семинарыг МБҮА ТББ-тай хамтран зохион байгууллаа. Тус семинарт “Майн Стекерсолар”-ын өндөр чанартай эрчим хүч үйлдвэрлэх систем, Мини RV систем, дээврийн системийн танилцуулга, “Стадт Асхаффенбург”-ын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын хамгаалалтын талаарх лекц, “Швайнфуртын бохир ус цэвэрлэх байгууламж”-ийнн 3 үе шаттай бохир ус цэвэрлэх байгууламж, ус зайлуулах хоолойн барилга байгууламж, “CAE”-ын эрчим хүчний судалгааны төв барилга, “KNAUF”-ын барилгын систем, гипсэн хавтан үйлдвэрлэл, “Ауктор инжиниор”-ын эко байгальд ээлтэй борооны усны тогтвортой менежменттэй орон сууцны байшин, “Линум байерн”-ийн байгальд ээлтэй модон барилга зэрэг барилга байгууламжтай танилцах, туршлагаас сонслоо. Мөн сургалтад нарны энергийг цахилгаан эрчим хүч болгон хадгалах систем, бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэ техник технологи, хот байгуулалт, байгальд ээлтэй модон барилгыг хэрхэн барьж байгаа аргууд болоод төвийн системээс үл хамаарсан бие даасан эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрээс бага өртгөөр гарган авч, байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг хамгийн бага хэмжээнд байлгаж, энергийн эх үүсвэрийг хэрхэн бий болгож эрчим хүчний тогтвортой хангамжийг бий болгож байгаа тухай онолын түвшинд хамрагдахаас гадна, үүнийг хэрхэн шийдэж байгаа туршлагуудтай танилцлаа. Техникийн сургалтын үеэр Монголын барилгын инженерүүд, архитекторууд, мэргэжилтнүүд Германаас хамгийн сайн чанарын эко гипсэн хавтанг, Монгол руу экспортлох ямар боломж байгаа талаар санал солилцов. “Хотын тогтвортой хөгжил, сэргээгдэх эрчим хүч, ус хадгалалт”-ын талаарх сургалтын сертификатыг МБҮА ТББ-ын УЗГ Сэрүүн ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жаргалзаяа, Эфэс констракшн ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Долгормаа, Гишүүн байгууллага болох Дабль пирамид констракшн ХХК-ийн Ерөнхий захирал М.Болдсүх, Булдорс Мон ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Атарбаясгалан, Өгөөж хишиг ХХК-ийн санхүү албаны захирал П.Амаржаргал, М Си Эс Проперти ХХК-ийн маркетингийн менежер Л.Лхамсүрэн, Сүндэр өргөө трейд ХХК-ийн Бүтээгдэхүүн үйлдвэр үйлчилгээний дарга Э.Туяацэцэг, МБҮА БҮАТЗХэлтсийн мэргэжилтэн А.Гантуул нар авч сурсан туршлагаа өөрсдийн бүтээн байгуулалт дээрээ турших, хэрэгжүүлэх боломжтой боллоо.

ФИДИК-ИЙН МАЛАЙЗЫН МАСТЕР БАРИЛГАЧДЫН ХОЛБОО (MBAM)-НООС БАРИЛГЫН САЛБАРЫН ИНЖЕНЕРҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТАЛ ДЭЭР ТӨВЛӨРЧ АЖИЛЛАХААР БОЛОВ



Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос зохион байгуулсан “Дэд бүтцийн салбарын маргаашийн ажиллах хүчнийг төлөвшүүлэх нь: Чадавх бэхжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт вебинарт оролцлоо. Хэлэлцүүлгээр залуу ажилтнууд ялангуяа инженерүүдийг чадавхжуулах, ур чадварыг нэмэгдүүлэх асуудал улс орон бүрийн сорилт болж байгаа бөгөөд үүнийг даван туулах арга зам нь хамтын ажиллагаа түүний дотор төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, тогтмол сургалт зохион байгуулах, мэргэжлийн боловсролын сургуулиудыг чадавхжуулах, зөвлөгч (mentor) ажиллуулах зэрэг олон арга байж болох юм, гэхдээ хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын хувьд мөнгө санхүүгийн дутагдалтай байдал гол асуудал болж байгааг ярилцлаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд ФИДИК-ээс гаргасан тайланг татаж авч үйл ажиллагаандаа хэрэглэхийг зөвлөлөө.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ
Монгол Улс, Улаанбаатар 15141
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

+(976) 70111515, 94444173

info@mnca.mn

www.mnca.mn